



МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОН ҮЙ ОЛНООР
ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН
УЛСЫН СТАНДАРТ

ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖ

2019 оны 6 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан



МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ САНХҮҮГИЙН АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) нь олон улсын санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс сэргийлэх бодлого боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус байгууллага юм. ФАТФ-ын зөвлөмжийг олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрдөг.

ФАТФ-тай холбоотой нэмэлт мэдээллийг веб хуудаснаас авна уу: www.fatf-gafi.org .

Энэ баримт бичиг болон ашиглагдсан зураг нь аливаа нутаг дэвсгэрийн талаархи статус, тусгаар тогтнол, олон улсын хил хязгаар, хот, газар нутгийн нэр хаяг зэргийг хөндөөгүй болно.

Тодруулга:

ФАТФ (2012-2019), Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, ФАТФ, Парис, Франц, www.fatf-gafi.org/recommendations.html

©2012-2019 ФАТФ/ЭЗХАХБ. Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан.

Урьдчилсан бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд хэвлэх, хуулбарлах болон орчуулахыг хориглоно.

Нийтээр нь болон хэсэгчилэн хэвлэхтэй холбоотой зөвшөөрөл хүссэн өргөдлийг

ФАТФ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт хүлээн авна:

2 Рью Андре Паскал 75775 Парис хот Цедекс 16, Франц Улс

(Факс: +33 1 44 30 61 37, э- мэйл: contact@fatf-gafi.org).

Орчуулгыг: Санхүүгийн мэдээллийн алба. 2020.01.08

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОН ҮЙ ОЛНООР
ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН
СТАНДАРТ

ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖ

ФАТФ-ЫН 2012 ОНЫ 2 ДУГААР САРЫН ЧУУЛГАНААР БАТЛАВ

2019 оны 6 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан

АГУУЛГА

ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖИЙН ЖАГСААЛТ	5
ОРШИЛ	8
ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖ.....	11
ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖИЙН ТАЙЛБАР	32
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, СББМҮҮ НАРТ ШААРДЛАГА ТАВИХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ.....	124
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	126
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	143
ХАВСРАЛТ I: ФАТФ-ЫН ГАРЫН АВЛАГА, БАРИМТ БИЧИГ	144
ХАВСРАЛТ II: ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖИД ОРСОН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ	145

ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Хуучин дугаар ¹	
А – МУТСТ бодлого болон зохицуулалт		
1	-	Эрсдэлээ үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх*
2	Зөвлөмж 31	Үндэсний хамтын ажиллагаа болон уялдаа холбоо
В – МӨНГӨ УГААХ БОЛОН ХӨРӨНГӨ ХУРААХ		
3	Зөвлөмж 1 & 2	Мөнгө угаах гэмт хэрэг*
4	Зөвлөмж 3	Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ*
С – ТЕРРОРИЗМ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ		
5	Тусгай зөвлөмж II	Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг*
6	Тусгай зөвлөмж III	Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ*
7		Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ*
8	Тусгай зөвлөмж VIII	Ашгийн бус байгууллага*
D – УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ		
9	Зөвлөмж 4	Санхүүгийн байгууллагын нууцлалын хууль тогтоомж <i>Харилцагчийг таньж мэдэх, баримт материал хадгалах</i>
10	Зөвлөмж 5	Харилцагчийг таньж мэдэх*
11	Зөвлөмж 10	Баримт материал хадгалах <i>Тусгай харилцагч, үйл ажиллагаатай холбоотой нэмэлт арга хэмжээ</i>
12	Зөвлөмж 6	Улс төрд нөлөө бүхий этгээд*
13	Зөвлөмж 7	Корреспондент банкны үйл ажиллагаа*
14	Тусгай зөвлөмж VI	Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ*
15	Зөвлөмж 8	Шинэ технологи
16	Тусгай зөвлөмж VII	Цахим шилжүүлэг*
<i>Бусдаар гүйцэтгүүлэх, хяналт болон санхүүгийн групп</i>		
17	Зөвлөмж 9	Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх*
18	Зөвлөмж 15 & 22	Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани*
19	Зөвлөмж 21	Өндөр эрсдэлтэй улс орнууд* <i>Сэжигтэй гүйлгээг мэдээлэх</i>

20	Зөвлөмж 13 & Тусгай зөвлөмж IV	Сэжигтэй гүйлгээг мэдээлэх*
21	Зөвлөмж 14	Мэдээллийг задруулах болон нууцлал <i>Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид (СББМҮҮ)</i>
22	Зөвлөмж 12	СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх*
23	Зөвлөмж 16	СББМҮҮ: Бусад арга хэмжээ*

Е – ЭРХ ЗҮЙН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭД БОЛОН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ, ИЛ ТОД БАЙДАЛ

24	Зөвлөмж 33	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал*
25	Зөвлөмж 34	Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч*

F – ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БОЛОН АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Зохицуулалт болон хяналт шалгалт

26	Зөвлөмж 23	Санхүүгийн байгууллагын зохицуулалт, хяналт шалгалт*
27	Зөвлөмж 29	Хянан шалгагчын эрх мэдэл
28	Зөвлөмж 24	СББМҮҮ-ийн зохицуулалт, хянан шалгалт*
		<i>Хууль сахиулах байгууллага болон үйл ажиллагаа</i>
29	Зөвлөмж 26	Санхүүгийн мэдээллийн алба*
30	Зөвлөмж 27	Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын үүрэг*
31	Зөвлөмж 28	Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын эрх мэдэл
32	Тусгай зөвлөмж IX	Бэлэн мөнгө зөөвөрлөгчид*

Ерөнхий шаардлага

33	Зөвлөмж 32	Статистик мэдээлэл
34	Зөвлөмж 25	Зааварчилгаа, эргэх холбоо

Шийтгэлийн арга хэмжээ

35	Зөвлөмж 17	Шийтгэлийн арга хэмжээ
----	------------	------------------------

G – ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

36	Зөвлөмж 35 & Тусгай зөвлөмж I	Олон улсын арга хэрэгслүүд
37	Зөвлөмж 36 & Тусгай зөвлөмж V	Эрх зүйн харилцан туслалцаа
38	Зөвлөмж 38	Эрх зүйн харилцан туслалцаа: хөрөнгө царцаах, хураах*
39	Зөвлөмж 39	Гэмт хэрэгтэн шилжүүлэх

40 Зөвлөмж 40 Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр*

1. “Хуучин дугаар” багана нь 2003 оны ФАТФ-ын зөвлөмжийн дугаар болно.

* тэмдэглэгээтэй зөвлөмжүүд нь тайлбартай бөгөөд зөвлөмжийн хамт уншвал зохионо.

2012 оны 2 дугаар сарын 15-нд баталсан хувилбар.

ОРШИЛ

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /The Financial Action Task Force FATF -ФАТФ/ нь 1989 онд гишүүн улс орнуудын сайд нарын байгуулсан олон улсын засгийн газар хоорондын байгууллага юм. ФАТФ-ын зорилго нь олон улсын санхүүгийн системийн цогц байдалд аюул, занал учруулж байгаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон бусад холбоотой заналхийлэлтэй тэмцэх хууль, эрх зүйн, зохицуулалтын болон үйл ажиллагааны стандартыг тогтоон хэрэгжүүлэхэд оршино. ФАТФ нь олон улсын бусад талуудын оролцоотойгоор тухайн улс орны үндэсний түвшний эмзэг сул талыг тогтоож олон улсын санхүүгийн системийг урвуулан ашиглахаас сэргийлэхийг мөн чухалчилна.

ФАТФ-ын Зөвлөмж нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхэд улс орны хэрэгжүүлэх шаардлагатай иж бүрэн, цогц арга хэмжээний ерөнхий хүрээг тодорхойлдог. Улс орнуудын хууль эрх зүй, засаг захиргаа, үйл ажиллагааны тогтолцоо болон санхүүгийн систем харилцан адилгүй тул дээр дурдсан аюул заналхийлэлтэй тэмцэх арга хэлбэр нь ч харилцан адилгүй юм. Иймд ФАТФ-ын Зөвлөмж нь улс орнууд өөрийн онцлог нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх олон улсын стандартыг тогтоож өгсөн гэж ойлгох хэрэгтэй. ФАТФ-ын Зөвлөмж улс орнуудад хандан дараах үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаарддаг. Үүнд:

- эрсдэлээ тодорхойлж бодлого боловсруулах, дотоод уялдаа, холбоо зохицуулалт;
- мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргийг шалгах;
- санхүүгийн болон бусад салбарт урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэх;
- эрх бүхий байгууллага (тухайлбал мөрдөн шалгах, хууль сахиулах болон хянан шалгах)-ын эрх мэдэл, үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг сайжруулах;
- олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх.

ФАТФ-ын анхны 40 Зөвлөмжийг хар тамхины наймааны мөнгийг санхүүгийн системээр дамжуулан угаахыг таслан зогсоох үүднээс 1990 онд боловсруулсан. Мөнгө угаах хандлага, арга технологи хувьсан өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ФАТФ нь 1996 онд 40 зөвлөмжөө шинэчилж мөнгө угаах гэмт хэргийн цар хүрээг тэлж хар тамхины наймаагаар хязгаарлахаа больжээ. Улмаар терроризм болон террорист байгууллагуудыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийг нэмэгдүүлснээр ФАТФ нь Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 8 Тусгай зөвлөмж (хожим 9 болсон)-ийг 2001 оны 10 дугаар сард баталжээ. ФАТФ зөвлөмжөө 2003 онд 2 дахь удаа шинэчилсэн бөгөөд үүнийг Тусгай зөвлөмжтэй нь хамт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) олон улсын стандарт гэж хүлээн зөвшөөрч дэлхийн 180 гаруй улс мөрдөн хэрэгжүүлж байна.

ФАТФ нь гишүүн орнуудын 3 дахь удаагийн харилцан үнэлгээний дүгнэлтийг үндэслэн ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагууд, ОУВС, Дэлхийн банк, НҮБ зэрэг байгууллагатай нягт хамтран ажиллаж өөрийн зөвлөмжөө дахин шинэчилсэн. Энэ өөрчлөлтөд шинээр бий болсон аюул заналхийлэлтэй холбоотой авах арга хэмжээг тусгахын сацуу Зөвлөмжийн тогтвортой жигд байх асуудалд анхаарч мөн өмнө нь байсан хэд хэдэн үүрэг хариуцлагыг тодорхой болгож баталгаажуулсан.

ФАТФ-ын шинэчилсэн стандартын дагуу улс орнууд өндөр эрсдэлтэй асуудалд илүүтэй анхаарах боломж олгож, өндөр эрсдэлтэй асуудалд чиглэж ажиллах болон хэрэгжилтийг сайжруулахад анхаарах боломж олгосон. Улс орнууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ тодорхойлж, үнэлсний үндсэн дээр эрсдэлээ бууруулах арга хэмжээ авах шаардлагатай. ФАТФ-ын эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлэх зөвлөмж нь улс орнуудад нөөц боломжоо оновчтой хуваарилах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрсдэлд нь тохируулах боломжийг олгоно.

Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нь томоохон сорилт хэвээр байна. Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд МУТСТ үр дүнтэй тогтолцоо нэн чухал үүрэгтэй билээ. Терроризмын санхүүжилттэй холбоотой Тусгай зөвлөмжүүд өдгөө 40 зөвлөмж дотор ч тусгалаа олж, харилцан хамаарал холбоотой болжээ. Гэсэн хэдий ч цэвэр терроризмын санхүүжилттэй холбоотой зөвлөмжүүд ФАТФ-ын Зөвлөмжийн С хэсэгт бий: Зөвлөмж 5 (терроризмыг санхүүжүүлэхийг гэмт хэрэгт тооцох); Зөвлөмж 6 (терроризм болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ);

Зөвлөмж 8 (ашгийн бус байгууллагуудыг урвуулан ашиглахаас сэргийлэх). Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх нь аюулгүй байдалтай холбоотой томоохон асуудал болон хувирсан тул ФАТФ-ын чиг үүргийг өргөжүүлж 2008 оноос эхлэн тус асуудлыг зөвлөмждөө тусгаж ирсэн. Иймээс энэ аюул заналхийлэлтэй тэмцэх талаар ФАТФ нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрийн дагуу санхүүгийн зорилгот хориг арга хэмжээг тууштай, үр дүнтэй авах талаар шинэ зөвлөмж (Зөвлөмж 7)-ийг боловсруулжээ.

ФАТФ-ын стандарт нь Зөвлөмж, Зөвлөмжийн тайлбар болон Нэр томъёоны тайлбар хэсгээс бүрдэнэ. ФАТФ-ын стандартыг ФАТФ, ФАТФ-ын төрлийн бүсийн байгууллагын бүх гишүүн орнууд дагаж хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэгжилтийг нь ФАТФ-ын Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалын дагуу хийх Харилцан үнэлгээ, ОУВС, Дэлхийн банкны үнэлгээгээр үнэлнэ. Зарим Зөвлөмжийн тайлбар болон Нэр томъёоны тайлбарыг хэрхэн хэрэгжүүлэх жишээгээр баяжуулсан болно. Эдгээр жишээ нь ФАТФ-ын стандартын заавал мөрдөх элемент биш бөгөөд зөвхөн санаа өгөх зорилготой юм. Эдгээр жишээ нь асуудлыг ойлгоход тус дөхөмтэй ч нөхцөл байдал бүрт тохирно гэсэн үг биш юм.

ФАТФ-аас улс орнуудад зориулан Удирдамж, Сайн жишиг болон бусад төрлийн баримт бичгүүд гаргадаг. Бусад төрлийн баримт бичгийг заавал хэрэгжүүлэх албагүй ч стандартуудыг хэрэгжүүлэхэд тус дэмтэй байх нь гарцаагүй. ФАТФ-ын хүчин төгөлдөр Удирдамж, Сайн жишгийг ФАТФ-ын веб хуудаст байршуулсан бөгөөд ФАТФ-ын Зөвлөмжид хавсаргасан.

ФАТФ нь санхүүгийн системийн цогц байдлыг хангахад чухал үүрэгтэй хувийн хэвшил, иргэний нийгэм, бусад сонирхогч талтай нягт хамтран ажиллахыг эрмэлздэг. Тэдэнтэй өргөн хүрээнд зөвлөлдөж, санал авсны үндсэн дээр Зөвлөмжүүдийг шинэчилсэн болно. Дэлхийн санхүүгийн системд тулгарч байгаа шинэ эрсдэл, аюул заналтай холбоотойгоор ФАТФ нь стандартаа цаашид ч боловсронгуй болгохын төлөө ажиллана.

ФАТФ нь улс орнуудад хандан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо ФАТФ-ын шинэчилсэн зөвлөмжтэй нийцүүлэх шаардлагатай, үр дүнтэй арга хэмжээ авахыг уриалж байна.

ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖ**A. МУТСТ БОДЛОГО БОЛОН ЗОХИЦУУЛАЛТ****1. Эрсдэлээ үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх***

Улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС)-тэй холбоотой улсын эрсдэлээ тодорхойлж, үнэлж, ойлгох шаардлагатай бөгөөд эрсдэлээ үнэлэх эрх бүхий байгууллагыг эсвэл зохицуулалтыг хийж, нөөц бололцоог зөв хуваарилах, эрсдэлээ үр дүнтэй бууруулах арга хэмжээ авбал зохино. Эрсдэлийн үнэлгээнээс эрсдэлд суурилсан аргачлал (ЭСА)-ыг нэвтрүүлэх замаар МУТС эрсдэлд тохирсон урьдчилан сэргийлэх болон тодорхойлсон эрсдэлээ бууруулах арга хэмжээ авах шаардлагатай. Энэ аргачлал нь МУТСТ тогтолцооны нөөцийн хуваарилалтыг үр ашигтай байлгах, ФАТФ-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үндэс суурь нь билээ. Улс орнууд өндөр эрсдэл илрүүлсэн тохиолдолд МУТСТ тогтолцоо нь өндөр эрсдэлээ зохицуулдаг байх шаардлагатай. Харин эрсдэл бага гэж үнэлэгдсэн үед ФАТФ-ын зарим зөвлөмжийг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан хялбаршуулсан байдлаар хэрэгжүүлэх боломжтой юм.

Улс орнууд санхүүгийн байгууллага болон Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ) нараас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ тодорхойлох, үнэлж, эрсдэл бууруулах арга хэмжээ авахыг шаардах ёстой.

2. Үндэсний хамтын ажиллагаа болон уяалдаа холбоо

Улс орнууд МУТСТ эрсдэлээ тогтмол үнэлж шинэчлэж байдаг, үүн дээр суурилсан үндэсний хэмжээний МУТСТ бодлоготой бөгөөд ийм бодлогыг хариуцах эрх бүхий байгууллага эсвэл зохицуулалт бусад механизмтай байвал зохино.

Улс орнууд бодлого боловсруулагчид, Санхүүгийн мэдээлийн алба (СМА), хууль сахиулах байгууллага, хянан шалгагчид болон бусад холбогдох эрх бүхий байгууллагууд мөнгө угаах, терроризмын санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого боловсруулах болон үйл ажиллагааны түвшинд хамтран ажиллах, зохицуулах мэдээлэл солилцох бодлого, үйл ажиллагааг хамтран боловсруулж хэрэгжүүлэх арга хэрэгслүүдтэй байвал зохино. Эдгээр МУТСТ холбоотой байгууллага хоорондын хамтын ажиллагаа, зохицуулалт нь Мэдээлэл хадгалах, Хувийн нууцлалын зохицуулалт болон бусад ийм төрлийн зохицуулалттай нийцсэн байх шаардлагатай.

В.МӨНГӨ УГААХ БОЛОН ХӨРӨНГӨ ХУРААХ

3. Мөнгө угаах гэмт хэрэг*

Улс орнууд Венийн болон Палермогийн конвенцийн дагуу мөнгө угаах үйл үйлдлийг гэмт хэрэгт тооцвол зохино. Мөнгө угаах гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг түүний дотор өргөн хүрээний суурь гэмт хэргийг хамруулвал зохино.

4. Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ*

Улс орнууд Венийн конвенц, Палермогийн конвенц, Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц тусгагдсантай адил арга хэмжээ, тухайлбал хууль батлан хэрэгжүүлж гэм зэмгүй гуравдагч этгээдийн эрхэнд халдахгүйгээр дараах хөрөнгийг царцаах, битүүмжлэх болон хураах эрхийг холбогдох байгууллагуудад олгоно: (a) угаасан өмч хөрөнгө, (b) мөнгө угаах болон суурь гэмт хэрэг үйлдэж олсон орлого, ашигласан буюу ашиглахаар зэхсэн хэрэгсэл, (c) терроризм, террорист үйлдэл, террорист бүлэглэлийг санхүүжүүлэхэд ашигласан, ашиглахаар завдсан, эсвэл хуваарилсан орлогоос үүдэлтэй өмч хөрөнгө, эсвэл (d) дүйцэхүйц үнийн дүнтэй өмч хөрөнгө.

Холбогдох эрх бүхий байгууллага нь дараах үйл ажиллагаа явуулах эрхтэй байвал зохино. Үүнд: (a) хураах хөрөнгийг тогтоох, илрүүлэх, үнэлэх; (b) хөрөнгө царцаах, битүүмжлэх зэрэг түр арга хэмжээ авах замаар хөрөнгө арилжаалах, шилжүүлэх, устаж үгүй болохоос сэргийлэх; (c) улс орны хөрөнгө царцаах, битүүмжлэх чадварт сөргөөр нөлөөлөх үйлдлээс сэргийлж чаддаг байх; мөн (d) мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах.

Гэмт хэрэг үйлдэж олсон орлого, ашигласан хэрэгсэл, хөрөнгийг эрүүгийн шийтгэлгүй хураах арга хэмжээг улс орнууд боловсруулсан байвал зохино. Эсвэл хураах хөрөнгийг хууль ёсны гаралтай гэдгээ батлахыг гэмт хэрэгтнээс шаардах арга хэмжээг дотоодын хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах хэрэгтэй.

С. ТЕРРОРИЗМ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

5. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг*

Улс орнууд терроризмыг санхүүжүүлэхийг Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенцийн дагуу гэмт хэрэгт тооцох бөгөөд зөвхөн тодорхой террорист үйлдэл үйл явдалтай хамааралтай эсэхээс үл хамааран террорист байгууллага, этгээд болон террорист үйлдлийг санхүүжүүлэхийг гэмт хэрэгт тооцвол зохино. Улс орнууд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөнгө угаах суурь гэмт хэрэгт тооцно.

6. Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ*

Улс орнууд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн терроризм, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбоотой тогтоолыг биелүүлж санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлбэл зохино. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолууд нь улс орнуудаас дараах хувь хүн, хуулийн этгээдийн мөнгө болон бусад хөрөнгийг цаг алдалгүй царцаахыг, хөрөнгө мөнгөөр шууд буюу шууд бусаар хангахгүй байхыг шаарддаг: (i) НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс НҮБ-ын Дүрмийн 7 дугаар бүлгийн дагуу буюу түүнийг үндэслэн үүний дотор 1267-р тогтоол (1999) болон дагалдан гарсан тогтоолын дагуу жагсаалтад оруулсан; эсвэл (ii) 1373 (2001) тогтоолын дагуу тухайн улсаас жагсаалтад оруулсан зэрэг болно.

7. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ*

Улс орнууд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай тогтоолуудыг хэрэгжүүлж санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлбэл зохино. Эдгээр тогтоол нь улс орнуудаас НҮБ-ын Дүрмийн 7 дугаар бүлгийн дагуу тодорхойлсон хувь хүн, хуулийн этгээдийн хөрөнгө мөнгө, хөрөнгийг цаг алдалгүй царцаах, хөрөнгө мөнгөөр шууд буюу шууд бусаар хангахгүй байхыг шаарддаг.

8. Ашгийн бус байгууллага*

Улс орнууд терроризмыг санхүүжүүлэхэд өртөх эмзэг сул талтай гэж тодорхойлсон ашгийн бус байгууллагуудтай холбоотой хууль тогтоомжийн нийцтэй байдлыг авч үзэх шаардлагатай. Эрсдэлд суурилсан аргачлалын дагуу чиглэсэн, эрсдэлтэй нь дүйцэхүйц арга хэмжээг ашгийн бус байгууллагын хувьд хэрэгжүүлж, тэднийг терроризмыг санхүүжүүлэхэд дараах байдлаар урвуулан ашиглагдахаас хамгаална:

- (a) Хууль ёсны байгууллагын нэрэн дор террорист байгууллага нуугдах;
- (b) Хуулийн этгээдийг терроризмыг санхүүжүүлэхэд ашиглахаас (үүнд хөрөнгө царцаахаас зайлсхийх явдал мөн хамаарна);
- (c) Хууль ёсны дагуу зарцуулагдах хөрөнгө мөнгийг нуун далдалж, зориулалтыг нь өөрчлөх замаар террорист бүлэглэлд ашиглуулахаас.

D. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

9. Санхүүгийн байгууллагын нууцлалын хууль тогтоомж

Санхүүгийн байгууллагын нууцлалтай холбоотой хууль, тогтоомж нь ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд саад учруулахгүй байвал зохино.

ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ, БАРИМТ МАТЕРИАЛ ХАДГАЛАХ

10. Харилцагчийг таньж мэдэх*

Санхүүгийн байгууллага нэргүй, нууц данс болон илэрхий хуурамч нэрээр данс ашиглахыг хориглох шаардлагатай.

Дараах тохиолдолд санхүүгийн байгууллагууд харилцагчийг таньж мэдэх (ХТМ) арга хэмжээ авна:

- i. бизнесийн харилцаа тогтооход;
- ii. байнгын бус гүйлгээний дүн нь: (i) босго дүн болох 15,000 ам.доллар/евроогоос дээш бол; эсвэл (ii) Зөвлөмж 16-ийн Тайлбарт хамаарах нөхцлөөр хийсэн цахим шилжүүлэг бол;
- iii. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх сэжиг байгаа бол;
- iv. харилцагчийн талаар өмнө нь авсан мэдээлэл бүрэн бус, бодит бус гэх эргэлзээ санхүүгийн байгууллагад төрсөн бол.

Санхүүгийн байгууллагын ХТМ үүргийг хуульд тусгаж өгвөл зохино. Улс орнууд ХТМ тодорхой үүргийг хуулиар тогтоох уу, бусад арга хэлбэрээр тогтоох уу гэдгээ өөрсдөө сонгоно.

ХТМ хүрээнд дараах арга хэмжээ авна:

- (a) Харилцагчийг хэн болохыг тогтоож, баримт бичгийг найдвартай, хараат бус мэдээлийн эх үүсвэр, өгөгдөл, мэдээллээр баталгаажуулна;
- (b) Эцсийн өмчлөгчийг тогтоож, санхүүгийн байгууллага нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг баталгаажуулах боломжит буюу эцсийн өмчлөгч хэн болох талаар хангалттай мэдээлэл авсан гэж үзэх хүртэл боломжит арга хэмжээ авна. Санхүүгийн байгууллага нь хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн удирдлагын бүтэц болон эзэмшлийг ойлгож байвал зохино;
- (c) Бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг ойлгож шаардлагатай тохиолдолд мэдээлэл гаргуулан авах;

(d) Бизнесийн харилцааг тогтмол нягтлах, бизнесийн харилцааны хүрээнд хийгдэж байгаа гүйлгээнүүдэд нарийвчилсан дүн шинжилгээ хийх замаар гүйлгээ болон эх үүсвэр нь харилцагч, түүний бизнесийн үйл ажиллагаа, эрсдэлийн төрлийн талаархи санхүүгийн байгууллагын төсөөлөлтэй нийцэж байгааг баталгаажуулах.

Санхүүгийн байгууллага нь ХТМ (a)-(d)-д заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ. Эдгээр арга хэмжээг чухам ямар байдлаар хэрэгжүүлэхээ эрсдэлд суурилсан аргачлал болон энэ Зөвлөмжийн болон Зөвлөмж 1-ийн Тайлбарыг ашиглана.

Санхүүгийн байгууллага нь бизнесийн харилцаа тогтоохоос өмнө эсвэл бизнесийн харилцаа тогтоох явцдаа болон нэг удаагийн гүйлгээ хийгдэх үед харилцагч болон эцсийн өмчлөгчийг хэн бэ гэдгийг шалгана. Хэрэв МУТС эрсдэлээ үр дүнтэй удирдаж байгаа болон бизнесийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах шаардлагатай бол санхүүгийн байгууллагуудад ХТМ үйл ажиллагааг харилцаа тогтоосны дараа богино хугацаанд гүйцэтгэх боломжийг олгож болно.

Санхүүгийн байгууллага нь ХТМ (a)-(d) дэх (авах арга хэмжээний түвшинг эрсдэлд суурилсан аргачлалын дагуу тогтоосноор) шаардлагыг биелүүлэх боломжгүй тохиолдолд санхүүгийн байгууллага данс нээх, бизнесийн харилцаа тогтоох, гүйлгээ хийхээс зайлсхийж өмнө нь тогтоосон бизнесийн харилцааг зогсоож харилцагчтай холбоотой сэжигтэй гүйлгээг мэдээлэх үүрэгтэй.

Санхүүгийн байгууллага нь дээрх шаардлагыг бүх шинэ харилцагчдад тавихаас гадна энэ Зөвлөмжийг бодит хүчин зүйлс болон эрсдэлд тулгуурлан хуучин харилцагчдад нэгэн адил тавих шаардлагатай бөгөөд ХТМ үйл ажиллагааг хуучин харилцагчдын хувьд шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлнэ.

11. Баримт материал хадгалах

Санхүүгийн байгууллага нь дотоод болон гадаад гүйлгээний холбогдох бүх баримт материалыг эрх бүхий байгууллагыг шаардсан үед гаргаж өгөх зорилгоор гүйлгээ хийгдсэнээс хойш хамгийн багадаа 5 жилийн хугацаанд хадгална. Гүйлгээний баримт материал нь тухайн гүйлгээг (гүйлгээний дүн, валютын төрөл зэрэг) “сэргээхэд” хангалттай, шаардлагатай тохиолдолд гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд нотлох баримт болохуйц байна.

Санхүүгийн байгууллага нь ХТМ үйл ажиллагаагаар (паспорт, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхний хуулбар г.м.) олж авсан мэдээлэл, дансны файлууд, бизнес захидал шуудан, үүний дотор анализ хийсэн дүгнэлтүүдийг (тухайлбал, өндөр дүнтэй гүйлгээний зорилго болон үндэслэлийг магадласан лавлагаа г.м) бизнесийн харилцаа дуусгавар болсноос хойш буюу нэг удаагийн гүйлгээ хийгдсэнээс хойш хамгийн багадаа 5 жилийн хугацаанд хадгалах үүрэгтэй байна.

Санхүүгийн байгууллагын гүйлгээний болон ХТМ хүрээнд олж авсан мэдээллийг хадгалах үүргийг хуулиар зохицуулна.

Эрх бүхий дотоодын байгууллагууд бүрэн эрхийнхээ хүрээнд ХТМ болон гүйлгээний талаархи мэдээллийг гаргуулан авах эрхтэй байна.

ТУСГАЙ ХАРИЛЦАГЧ, ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ АРГА ХЭМЖЭЭ

12. Улс төрд нөлөө бүхий этгээд*

Санхүүгийн байгууллага нь гадаадын улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ) (харилцагч эсвэл эцсийн өмчлөгчийн хувьд)-ийн хувьд энгийн ХТМ үйл ажиллагааг гүйцэтгэхээс гадна нэмэлтээр дараах арга хэмжээг авах үүрэг хүлээнэ:

- (a) харилцагч буюу эцсийн өмчлөгч нь УТНБЭ мөн эсэхийг тогтоох эрсдэлийн удирдлагын системтэй байх;
- (b) бизнесийн харилцаа тогтоохдоо (эсвэл одоогийн харилцаагаа үргэлжлүүлэхдээ) дээд шатны удирдлагаас зөвшөөрөл авах;
- (c) хөрөнгө мөнгө, баялагийн эх сурвалжийг тогтоох зохистой арга хэмжээг авах;
- (d) бизнесийн харилцаанд тогтмол өргөтгөсөн хяналт тавих шаардлагатай.

Санхүүгийн байгууллага нь тухайн харилцагч буюу эцсийн өмчлөгч нь дотоодын УТНБЭ үү аль эсвэл олон улсын байгууллагыг төлөөлж байгаа нөлөө бүхий этгээд үү гэдгийг тодорхойлох зохистой арга хэмжээ авах үүрэг хүлээнэ. Тухайн этгээдтэй тогтоох бизнесийн харилцаа өндөр эрсдэлтэй бол санхүүгийн байгууллага нь (b), (c) болон (d)-д заасан арга хэмжээг авах шаардлагатай.

УТНБЭ-д тавих шаардлага нь түүний гэр бүлийн гишүүд, ойр дотны хүмүүст нэгэн адил үйлчилнэ.

13. Корреспондент банкны үйл ажиллагаа*

Санхүүгийн байгууллага нь хил дамнасан корреспондент банкны харилцаа болон ижил төрлийн харилцааны хувьд энгийн ХТМ үйл ажиллагааг гүйцэтгэхээс гадна нэмэлтээр дараах арга хэмжээг авах үүрэг хүлээнэ:

- (a) Респондент байгууллагын бизнесийн үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэл цуглуулж бизнесийн үйл ажиллагааг ойлгох, нээлттэй мэдээллийн эх сурвалжаас тухайн байгууллагын нэр хүнд, хяналт шалгалтын чанарыг тогтоох, үүний дотор МУТС-тэй холбоотойгоор шалгагдаж байсан эсэх буюу зохицуулагчдын зүгээс арга хэмжээ авч байсан эсэхийг тогтоох;

- (b) Респондент байгууллагын МУТСТ хяналтын тогтолцоог үнэлэх;
- (c) Шинэ корреспондент харилцаа тогтоохын өмнө дээд шатны удирдлагаас зөвшөөрөл авах;
- (d) Корреспондент байгууллагуудын үүрэг хариуцлагын хуваарилалтыг сайтар ойлгох;
- (e) “Дамжин өнгөрөх данс”-ны хувьд - респондент банк нь корреспондент банкны дансанд хандах эрхтэй харилцагчдын ХТМ үйл ажиллагааг гүйцэтгэсэн, корреспондент банкны хүсэлтээр шаардлагатай ХТМ мэдээллийг гаргаж өгөх боломжтойг магадласан байх шаардлагатай.

Санхүүгийн байгууллагад “халхавч банк”-тай корреспондент банкны харилцаа үүсгэх буюу үргэлжлүүлэхийг хориглох шаардлагатай. Санхүүгийн байгууллага нь респондент байгууллага өөрийн дансыг “халхавч банк”-нд ашиглуулдахгүй байх нөхцлийг бүрдүүлсэн байвал зохино.

14. Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ*

Улс орнууд мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ (МҮБЗШҮ) үзүүлж байгаа хувь хүн болон хуулийн этгээдийг тусгай зөвшөөрөл эсвэл бүртгэлд хамруулж ФАТФ-ын Зөвлөмжийн холбогдох заалтыг биелүүлж байгаа эсэхэд хяналт шалгалтын арга хэмжээ авах шаардлагатай. Тусгай зөвшөөрөлгүй, бүртгэлгүй МҮБЗШҮ эрхэлж байгаа хувь хүн болон хуулийн этгээдийг илрүүлж, тохирох шийтгэлийн арга хэмжээ авах шаардлагатай.

МҮБЗШҮ-ийн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж байгаа аливаа хувь хүн болон хуулийн этгээдийг мөн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл эсвэл бүртгэлд хамруулна. Эсвэл МҮБЗШҮ үзүүлэгч нь өөрийн төлөөлөгчийн жагсаалтыг тухайн үйл ажиллагаа явуулж байгаа улс орны болон төлөөлөгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа улс орны эрх бүхий байгууллагад гаргаж өгөхөд бэлэн байлгах шаардлагатай. Улс орнууд төлөөлөгчөөр дамжуулан үйл ажиллагаа явуулдаг МҮБЗШҮ нь өөрийн төлөөлөгчдөө МУТСТ хөтөлбөрт хамруулж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авч байгааг хянах шаардлагатай.

15. Шинэ технологи

Улс орнууд болон санхүүгийн байгууллага нь а) шинэ бүтээгдэхүүн, бизнесийн хэрэглээнээс үүдэлтэй (тухайлбал, түгээлтийн шинэ механизм); болон б) шинэ бүтээгдэхүүн буюу хөгжүүлж байгаа технологитой холбоотойгоор үүсч болох МУТС эрсдэлээ тодорхойлж үнэлнэ. Санхүүгийн байгууллагын хувьд шинэ бүтээгдэхүүн, бизнесийн хэрэглээг болон шинэ, хөгжүүлж байгаа технологи нэвтрүүлэхээс өмнө

эрсдэлийн үнэлгээ хийж мөн эрсдэлээ удирдах, бууруулах шаардлагатай арга хэмжээг авбал зохино.

Улс орнууд виртуал хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг удирдах, бууруулах үүднээс виртуал хөрөнгөтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгч нарыг тусгай зөвшөөрөл эсвэл бүртгэлд хамруулж ФАТФ-ын Зөвлөмжийн холбогдох заалтыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих арга хэмжээ авах шаардлагатай.

16. Цахим шилжүүлэг*

Санхүүгийн байгууллага нь цахим мөнгөний шилжүүлэгт болон холбогдох мэдээлэлд шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар холбогдох шаардлагатай мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв тусгасан байх үүрэгтэй бөгөөд энэ мэдээлэл нь шилжүүлгийн үе шат болгонд дагалдаж байгаад улс орнууд хяналт тавих арга хэмжээ авах шаардлагатай.

Улс орнууд санхүүгийн байгууллага нь шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээлэл бүрэн бус цахим шилжүүлгийг илрүүлж, холбогдох арга хэмжээ авч байгаад хяналт тавих шаардлагатай.

Санхүүгийн байгууллага нь цахим мөнгөн шилжүүлгийн хувьд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс терроризм, терроризмын санхүүжилтээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай 1267-р тогтоол (1999) болон дагалдан гарсан тогтоол, 1373-р (2001) тогтоолоор жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг царцааж, гүйлгээг нь хийхгүй байвал зохино.

БУСДААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ, ХЯНАЛТ БОЛОН САНХҮҮГИЙН ГРУПП

17. Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх*

Улс орнууд санхүүгийн байгууллагыг Зөвлөмж 10-т заасан ХТМ (а)-(с) дэх арга хэмжээг хэрэгжүүлэх эсвэл бизнесийн харилцаа тогтоохдоо гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрч болох бөгөөд ингэхдээ дор дурдсан шалгуурыг хангахыг шаардана. Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж байгаа санхүүгийн байгууллагын ХТМ үйл ажиллагааны эцсийн хариуцлага санхүүгийн байгууллага өөрт нь оногдоно.

Дараах шалгуурыг хангана:

- (а) Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж байгаа санхүүгийн байгууллага нь Зөвлөмж 10-т заасан ХТМ арга хэмжээний (а)-(с)-тэй холбоотой мэдээллийг нэн даруй олж авах;
- (б) Санхүүгийн байгууллага нь гуравдагч этгээдээс харилцагчийг хэн болохыг тодорхойлох баримт бичгийн хуулбар болон ХТМ-тэй холбоотой мэдээлэл, бусад баримт бичгийн хуулбарыг тухай бүр түргэн шуурхай гаргуулж авах;

(c) Санхүүгийн байгууллага нь гуравдагч этгээдийн үйл ажиллагаа хяналттай, зохицуулалттай хууль журмын дагуу явагддаг, гуравдагч этгээд нь Зөвлөмж 10, 11-ийн дагуу ХТМ болон баримт бичиг хадгалах шаардлагыг дагаж мөрддөг гэдэгт санхүүгийн байгууллага итгэлтэй байх;

(d) Шалгуур хангаж байгаа гуравдагч этгээдийн байрлах улс орныг тодорхойлохдоо тухайн улсын эрсдэлийн түвшинг харгалзан үзэх.

Хэрэв санхүүгийн байгууллага нь нэг санхүүгийн группд харьяалагддаг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол (i) групп нь Зөвлөмж 10, 11, 12-н дагуу ХТМ болон баримт материал хадгалах шаардлагыг биелүүлдэг, Зөвлөмж 18-д заасан МУТСТ хөтөлбөртэй; болон (ii) нэгдлийн түвшин дэх ХТМ, баримт материал хадгалах шаардлагад хяналт тавьдаг холбогдох эрх бүхий байгууллага байдаг бол холбогдох эрх бүхий байгууллагын зүгээс тухайн санхүүгийн байгууллага (b), (c)-д заасан арга хэмжээг хэрэгжүүлдэг гэж үзэн, улмаар (d) нь (улс орны өндөр эрсдэлийг тухайн нэгдлийн МУТСТ механизмууд хангалттай түвшинд бууруулах тохиолдолд) гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх угтвар нөхцөл байх албагүй хэмээн шийдвэрлэж болно.

18. Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани*

Санхүүгийн байгууллага нь МУТСТ хөтөлбөртэй байх шаардлагатай. Санхүүгийн групп нь МУТСТ хөтөлбөрийг санхүүгийн группын хэмжээнд хэрэгжүүлэх бөгөөд групп дотроо МУТСТ мэдээлэл солилцох бодлого, журамтай байна.

Санхүүгийн байгууллага нь гадаад дахь салбар болон ихэнх хувийг эзэмшдэг охин компанидаа өөрийн орны ФАТФ-ын Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээтэй нийцсэн группын түвшинд боловсруулсан МУТСТ хөтөлбөр хэрэгжүүлнэ.

19. Өндөр эрсдэлтэй улс орнууд*

Санхүүгийн байгууллага нь ФАТФ-аас тухайн улсын эсрэг арга хэмжээ ав гэж уриалсан бол тухайн улсын хувь хүн, хуулийн этгээд, санхүүгийн байгууллагатай бизнесийн харилцаа тогтоох, гүйлгээ хийхдээ өргөтгөсөн таних үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Өргөтгөсөн таних үйл ажиллагааны төрөл нь эрсдэлтэй тохирохуйц, үр дүнтэй байвал зохино.

Улс орнууд ФАТФ-аас хариу арга хэмжээ авахыг уриалсан үед түүнийг хэрэгжүүлэх боломжтой байх шаардлагатай. ФАТФ-ын зүгээс албан ёсны хариу арга хэмжээ авах уриалга гаргаагүй байсан ч улс орнууд хариу арга хэмжээ авахад бэлэн байх шаардлагатай. Ийм хариу арга хэмжээ нь эрсдэлтэй нь тохирохуйц, үр дүнтэй байвал зохино.

СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ

20. Сэжигтэй гүйлгээг мэдээлэх*

Санхүүгийн байгууллага нь аливаа хөрөнгө, мөнгийг гэмт хэргийн гаралтай эсвэл терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзэх, сэжиглэх үндэслэл байгаа бол Санхүүгийн мэдээллийн албанд нэн даруй мэдэгдэхийг хуулиар шаардана.

21. Мэдээллийг задруулах болон нууцлал

Санхүүгийн байгууллага, түүний захирал болон албан хаагчид нь:

- (a) мэдээлэл өгсөн этгээд цаад гэмт хэргийн үйл ажиллагааны талаар тодорхой мэдэхгүй байсан ч, үнэхээр ийм хууль бус үйлдэл болсон эсэхээс үл хамааран сэжигтэй үйлдлийн талаар СМА-нд шударгаар мэдээлсэн бол гэрээ, хууль, эрх зүйн болон захиргааны хэм хэмжээгээр тогтоосон мэдээлэл задруулахыг хориглосон заалтыг зөрчсөн гэж эрүүгийн, иргэний хариуцлагад татахаас хуулиар хамгаална.
- (b) Санхүүгийн мэдээллийн албанд сэжигтэй гүйлгээний мэдээллийг болон бусад холбогдох мэдээллийг мэдээлж байгааг бусдад задруулахыг хуулиар хориглоно. Энэ шаардлага нь Зөвлөмж 18-ын дагуу мэдээлэл солилцохыг хумих зорилгогүй.

САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС, МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД /СББМҮҮ/

22. СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх*

Зөвлөмж 10, 11, 12, 15, 17-д заасан ХТМ, баримт бичгийг хадгалах шаардлага дараах нөхцөлд СББМҮҮ-дэд хамаарна:

- (a) Казино – харилцагч нь босго дүнтэй тэнцүү буюу түүнээс дээш үнийн дүнтэй санхүүгийн гүйлгээ хийх үед;
- (b) Үл хөдлөх хөрөнгийн зуучлагч – харилцагчийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах үйл ажиллагаанд оролцох үед;
- (c) Үнэт металл, үнэт чулуу арилжаалагчид – харилцагчтай босго дүнтэй тэнцүү буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн гүйлгээ хийх үед;
- (d) Өмгөөлөгч, нотариатч, бусад хараат бус хуульчид болон нягтлан бодогчид – харилцагчын өмнөөс дараах үйл ажиллагааг бэлтгэх буюу гүйцэтгэх үед. Үүнд:
 - үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
 - харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаас болон бусад хөрөнгийг удирдах;

- банкны, хадгаламжийн болон үнэт цаасны дансыг удирдах;
 - компани үүсгэх, ажиллуулах болон удирдах;
 - хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд (arrangements)-ийг үүсгэн байгуулах, ажиллуулах, удирдах болон бизнесийн этгээдийг худалдан авах, худалдах.
- (е) Траст, компанийн үйлчилгээ үзүүлэгчид - харилцагчдын өмнөөс дараах үйл ажиллагааг бэлтгэх буюу гүйцэтгэх үед. Үүнд:
- хуулийн этгээдийг үүсгэн байгуулах төлөөлөгчөөр ажиллах;
 - компанийн захирал, нарийн бичгийн дарга; нөхөрлөлд хувь эзэмшигч; бусад хуулийн этгээдэд адил төстэй албан тушаалтны хувиар ажиллах (буюу өөр хүнийг эдгээр албан тушаалд ажиллуулах нөхцөл бүрдүүлэх);
 - компани, нөхөрлөл, хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг оффис, бизнесийн хаяг буюу байр байшин, шуудангийн болон захиргааны хаягаар хангах;
 - экспрес трастын трастийгаар ажиллах буюу эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн адил төстэй үүрэг гүйцэтгэх (буюу өөр этгээдээр эдгээр үүргийг гүйцэтгүүлэх нөхцөл бүрдүүлэх);
 - Өөр хүний өмнөөс нэрлэсэн хувьцаа эзэмшигчийн үүрэг гүйцэтгэх (буюу өөр хүнээр ийм үүргийг гүйцэтгүүлэх нөхцлийг бүрдүүлэх).

23. СББМҮҮ: Бусад арга хэмжээ*

Зөвлөмж 18-21-д заасан шаардлага дараах нөхцөлд бүх СББМҮҮ-дэд хамаарна:

- (a) Өмгөөлөгч, нотариатч, бусад хараат бус хуульчид болон нягтлан бодогчид харилцагчдынхаа өмнөөс буюу заавраар хийж байгаа Зөвлөмж 22-ын (d)-д тусгагдсан санхүүгийн гүйлгээг сэжигтэй гүйлгээгээр мэдээлэх үүрэгтэй байна. Улс орнууд мэдээлэх үүргийг нягтлан бодогчдын бусад үйл ажиллагаанд ч (тухайлбал аудит) хамааруулбал зохино.
- (b) Үнэт металл, үнэт чулуу арилжаалагчид босго дүнтэй тэнцүү буюу түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг харилцагчтай хийх үед сэжигтэй гүйлгээгээр мэдээлэх үүрэгтэй.

- с) Траст, компанийн үйлчилгээ үзүүлэгч нар харилцагчдынхаа өмнөөс буюу заавраар Зөвлөмж 22-ын (е)-д тодорхойлсон гүйлгээ хийх үед сэжигтэй гүйлгээгээр мэдээлэх үүрэгтэй.

Е. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ЭРХ ЗҮЙН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ БОЛОН ИЛ ТОД БАЙДАЛ

24. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал*

Улс орнууд хуулийн этгээдийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглуулахгүй байх арга хэмжээ авна. Эрх бүхий байгууллага нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаарх үнэн зөв, бодитой мэдээллийг тухай бүр гаргуулан авах эрхтэй байна. Ялангуяа мэдүүлэгчийн хувьцаа /bearer shares/ болон мэдүүлэгчийн хувьцааны баталгаа /bearer shares/ гаргах эрхтэй хуулийн этгээдтэй эсвэл нэрлэсэн хувьцаа эзэмшигчид болон захирлууд байхыг зөвшөөрдөг улс орнууд хуулийн этгээдийг урвуулан ашиглуулахгүй байхад онцгой анхаарах шаардлагатай. Зөвлөмж 10, 22-т заасан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт эцсийн өмчлөгчийн мэдээллийг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлж өгөх талаар судлана.

25. Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч*

Улс орнууд эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглуулахгүй байх арга хэмжээ авна. Ялангуяа эрх бүхий байгууллагууд нь экспрес траст, сетлор, трастий, үр шим хүртэгчийн талаар үнэн зөв, бодитой мэдээллийг тухай бүр авах эсвэл хандах эрхтэй байна. Улс орнууд Зөвлөмж 10, 22-т заасан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ нарт эцсийн өмчлөгчийн мэдээллийг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлж өгөх талаар судална.

Б. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БОЛОН АВАХ АРГА ХЭМЖЭЭ

ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

26. Санхүүгийн байгууллагын зохицуулалт, хяналт шалгалт*

Санхүүгийн байгууллагууд нь ФАТФ-ын Зөвлөмжүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоотой байх шаардлагатай. Эрх бүхий байгууллага, санхүүгийн хянан шалгагчдын зүгээс гэмт этгээд, тэдний хамсаатан санхүүгийн байгууллагын ихэнх хэсэг эсвэл хяналтын багцыг эзэмших, эцсийн өмчлөгч болох, удирдах албан тушаал хашихаас сэргийлэх арга хэмжээг хууль, журмын дагуу авна. Улс орнууд халхавч банк үүсгэн байгуулах, үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулахыг хориглох хэрэгтэй.

Үндсэн Зарчмуудыг мөрдөх үүрэгтэй санхүүгийн байгууллагуудын хувьд зохистой үйл ажиллагааг хангуулах хяналт шалгалт, зохицуулалтын арга хэмжээ нь МУТСТ-д холбоотой бол МУТСТ хяналт шалгалтыг ижил төстэйгээр хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд санхүүгийн группын түвшинд хэрэгжүүлэх МУТСТ хяналт шалгалт орно.

Бусад санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа нь холбогдох бүртгэл эсвэл тусгай зөвшөөрлийн дагуу МУТСТ хяналт, шалгалтад хамрагддаг байх шаардлагатай бөгөөд ингэхдээ тухайн секторын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг харгалзан үзнэ. Наад зах нь мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх болон валют солих үйлчилгээ үзүүлж байгаа санхүүгийн байгууллага бүртгэлтэй эсвэл тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд МУТСТ шаардлагын биелэлтэд хяналт тавих үр дүнтэй тогтолцоотой байна.

27. Хянан шалгагчийн эрх мэдэл

Хянан шалгагч нь санхүүгийн байгууллагад шалгалт хийх, МУТСТ шаардлагын биелэлтэд хяналт тавих болон хэрэгжилтийг хангуулах хангалттай эрх мэдэлтэй байвал зохино. Хянан шалгагч нь үүнтэй холбоотойгоор санхүүгийн байгууллагаас шаардлагын биелэлттэй хамааралтай мэдээлэл гаргуулан авах, Зөвлөмж 35-д заасны дагуу зөрчилд шийтгэл ногдуулах эрхтэй байна. Хянан шалгагч нь санхүүгийн байгууллагад захиргааны болон санхүүгийн олон төрлийн шийтгэлийн арга хэмжээ авах эрхтэй байх шаардлагатай бөгөөд үүний дотор тусгай зөвшөөрлийг түр хязгаарлах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл шийтгэл оногдуулах эрхтэй байна.

28. СББМҮҮ-ийн зохицуулалт, хяналт шалгалт*

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид /СББМҮҮ/ дараах зохицуулалт, хяналт шалгалтын арга хэмжээнд хамрагддаг байна.

- (a) Казинод МУТСТ зохицуулалт болон шаардлагын биелэлтийг хангуулах иж бүрэн хяналт шалгалт, зохицуулалтын тогтолцоо байх шаардлагатай. Хамгийн багадаа:
- Казино нь тусгай зөвшөөрөлтэй байна;
 - Эрх бүхий байгууллагын зүгээс гэмт этгээд, тэдний хамсаатан казиногийн ихэнх хэсэг эсвэл хяналтын багцыг эзэмших, эцсийн өмчлөгч болох, удирдах албан тушаал хаших, казино ажиллуулахаас сэргийлэх арга хэмжээг хууль, журмаар авна;
 - Эрх бүхий байгууллагын зүгээс казиногийн МУТСТ шаардлагын биелэлтэд зохих хяналт тавьж хэрэгжүүлнэ.
- (b) Бусад СББМҮҮ-ийн МУТСТ шаардлагын биелэлтийг хангуулах үр дүнтэй хяналтын тогтолцоотой байвал зохино. Үүнийг эрсдэлд суурилсан хэлбэрээр гүйцэтгэнэ. Энэ хяналт, шалгалтыг (a) хянан шалгагч эсвэл (б) өөрийгөө зохицуулах байгууллага (ӨЗБ) (гишүүд нь МУТСТ шаардлагыг бүрэн биелүүлж байгааг хянаж чаддаг бол) хийж гүйцэтгэнэ.

Түүнчлэн хянан шалгагч болон ӨЗБ зүгээс (a) гэмт этгээд, тэдний хамсаатан мэргэжлийн тусгай зөвшөөрөл авах эсвэл хяналтын багцыг эзэмших, эцсийн өмчлөгч болох, удирдах албан тушаал хаших, казино ажиллуулахаас сэргийлэх арга хэмжээг “шалгуур үзүүлэлт” (“fit and proper”)-ээр шалгаж авах; (b) МУТСТ шаардлагын биелэлтийн зөрчилд Зөвлөмж 35-ын дагуу зөрчилд нь тохирсон, давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэхүйц шийтгэл оногдуулна.

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГА БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА

29. Санхүүгийн мэдээллийн алба*

Улс орнууд үндэсний түвшинд (a) сэжигтэй гүйлгээний тайлан, (b) мөнгө угаах, түүнтэй холбоотой суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийж эрх бүхий байгууллагуудад шилжүүлэх чиг үүрэгтэй санхүүгийн мэдээллийн алба (СМА)-тай байвал зохино. СМА нь өөрийн чиг үүргээ зохих түвшинд гүйцэтгэхийн тулд санхүүгийн, захиргааны болон хууль сахиулахтай холбоотой мэдээлэлд хугацаа алдалгүй хандах болон мэдээлэх үүрэгтэй этгээдээс нэмэлт мэдээлэл тухай бүр гаргуулан авах эрхтэй байна.

30. Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын үүрэг*

Улс орнууд МУТСТ үндэсний бодлогын хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг зохих ёсоор шалгах үүрэг бүхий хууль сахиулах байгууллагатай байна. Хамгийн багадаа их хэмжээний орлого олж байгаа гэмт хэрэгт

хууль сахиулах байгууллага нь мөнгө угаах, түүнтэй холбоотой суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөж шалгахдаа идэвхтэй (pro-active) “санхүүгийн зэрэгцээ мөрдөн шалгалт” (“parallel financial investigation”) хийнэ. Үүнд суурь гэмт хэрэг өөр улс оронд үйлдэгдэх тохиолдол ч хамаарах шаардлагатай. Улс орнууд эрх бүхий байгууллагад гэмт хэргийн гаралтай буюу гэмт хэрэг үйлдэж олсон байж болзошгүй гэж сэжиглэгдэж байгаа, хураан авч болох, хураан авбал зохих хөрөнгийг нэн даруй илрүүлэх, мөшгих, царцаах, битүүмжлэх, хураах үйл ажиллагааг явуулах үүрэг оногдуулна. Улс орнууд шаардлагатай тохиолдолд санхүүгийн болон хөрөнгийн мөрдөн шалгалтаар мэргэшсэн байнгын эсвэл түр зуурын байгууллага хоорондын ажлын хэсгүүдийг ашиглана. Шаардлагатай тохиолдолд бусад улс орнуудын эрх бүхий байгууллагатай хамтарсан мөрдөн шалгалт хийнэ.

31. Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагын эрх мэдэл

Эрх бүхий байгууллага нь мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгахдаа шаардлагатай баримт бичиг, мэдээллийг гаргуулан авч мөрдөн шалгах, яллах болон бусад үйл ажиллагаанд ашиглах эрхтэй байна. Эрх бүхий байгууллага нь санхүүгийн байгууллага, СББМҮҮ болон бусад хувь хүн, хуулийн этгээдээс тайлан мэдээллийг албадан гаргуулах, хувь хүн болон орон байранд нэгжлэг хийх, гэрчийн мэдүүлэг авах, баталгаа, нотолгоог цуглуулах, олж авах эрхтэй байна.

Улс орнууд мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгахдаа эрх бүхий байгууллага нь өргөн хүрээний арга техник ашиглах боломжтой байна. Өргөн хүрээний арга техникд: гүйцэтгэх ажиллагаа, харилцаа холбооны хэрэгслийг чагнах, компьютерийн системд нэвтрэх, хяналттай хүргэлт зэрэг багтана. Түүнчлэн улс орнууд нь хувь хүн, хуулийн этгээд данс эзэмшиж, хянаж байгааг шуурхай тогтоох механизмтай байвал зохино. Мөн эрх бүхий байгууллага нь эзэмшигчид нь мэдэгдэлгүйгээр хөрөнгийг илрүүлэх боломжтой байна. Эрх бүхий байгууллага нь мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгахдаа СМА-наас холбоотой мэдээлэл хүсэх эрхтэй байна.

32. Бэлэн мөнгө зөөвөрлөгчид*

Улс орнууд хилээр нэвтрүүлж байгаа мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэл (bearer negotiable instruments)-ийг илрүүлэх арга хэрэгсэл, тухайлбал мэдүүлгийн болон мэдээлэх системтэй байх шаардлагатай.

Улс орнууд эрх бүхий байгууллагад терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах, суурь гэмт хэрэгт холбоотой байж болзошгүй гэж сэжиглэсэн эсвэл худал мэдүүлсэн, мэдээлсэн мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэл (bearer negotiable instruments)-ийг саатуулах, хязгаарлах эрх олгоно.

Улс орнууд худал мэдүүлсэн, мэдээлсэн этгээдэд зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийн арга хэмжээ авна. Хэрвээ мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэл (bearer negotiable instruments) нь терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэгтэй холбоотой бол түүнийг Зөвлөмж 4-ийн хүрээнд хураах хүртэл арга хэмжээг хууль, журмын дагуу авна.

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

33. Статистик

Улс орнууд МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдалд хамааралтай иж бүрэн статистик мэдээллийг гаргана. Үүнд хүлээн авсан СГТ, шилжүүлсэн СГТ, МУТС-ээр шалгасан, ялласан, шийдвэрлэсэн хэрэг, царцаасан, битүүмжилсэн болон хураагдсан эд хөрөнгө, хууль эрх зүйн харилцан туслалцаа болон олон улсын хамтын ажиллагааны бусад хүсэлтийн тоо мэдээ, статистик багтана.

34. Зааварчилгаа, эргэх холбоо

Эрх бүхий байгууллага, хянан шалгагчид болон ӨЗБ нь санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчидэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагааг явуулахад нь туслалцаа үзүүлэх зааварчилгаа гаргаж, эргэх холбоогоор хангана.

ШИЙТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭ

35. Шийтгэлийн арга хэмжээ

Улс орнууд МУТСТ шаардлагаа биелүүлэхгүй байгаа Зөвлөмж 6, Зөвлөмж 8-аас 23-т хамаарах хувь хүн, хуулийн этгээдэд зөрчилд нь дүйцэхүйц, зөрчил дахин үйлдэхээс сэргийлэхүйц, эрүүгийн, иргэний, захиргааны шийтгэл оногдуулна. Хариуцлагыг санхүүгийн байгууллага, СББМҮҮ-дэд төдийгүй захирал, дээд шатны удирдлагад хүлээлгэнэ.

Г. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

36. Олон улсын гэрээ

Улс орнууд нэн даруй Венийн конвенц (1988); Палермогийн конвенц (2000); Авилгын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц (2003); Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц (1999) зэрэгт нэгдэж, бүрэн хэрэгжүүлбэл зохино. Шаардлагатай тохиолдолд улс орнууд Кибер гэмт хэрэгтэй тэмцэх Европын Зөвлөлийн конвенц (2001); Терроризмын эсрэг Америкийн конвенц (2002); болон Европын Зөвлөлийн Гэмт хэргээс олсон орлогыг угаах, илрүүлэх, битүүмжлэх, хураах болон Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой конвенц (2005) болон бусад холбогдох олон улсын гэрээнд нэгдэж холбогдох арга хэмжээ авах шаардлагатай.

37. Эрх зүйн харилцан туслалцаа

Улс орнууд мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн мөрдөн шалгах, яллах ажиллагаатай холбоотой олон төрлийн эрх зүйн харилцан туслалцааг түргэн шуурхай, үр дүнтэй байдлаар үзүүлнэ. Улс орнууд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд гэрээ байгуулах болон бусад зохицуулалтын механизмыг ашиглан олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ. Улс орнууд дараах зүйлийг биелүүлсэн байвал зохино:

- (a) Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхдээ үндэслэлгүй эсвэл хэт хязгаарласан нөхцлийг тавихгүй байх.
- (b) Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх механизмтай байх. Улс орнууд хүсэлтийг шилжүүлж, биелүүлэх төв байгууллагатай байвал зохино. Хүсэлтийг хэрэгжүүлж байгаад хяналт тавих үүднээс хүсэлтийн удирдлагын системтэй байвал зохино.
- (c) Зөвхөн татвартай холбоотой асуудал гэдгээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзахгүй байх.
- (d) Хууль тогтоомжийн дагуу санхүүгийн байгууллага эсвэл санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нар нь нууцлалыг хангах шаардлагатай гэдгээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзахгүй байх (хүсэлттэй холбоотой мэдээлэл нь хууль, эрх зүйн болон мэргэжлийн эрхийн дагуу нууцлалд хамаарах нөхцлөөс бусад тохиолдолд).
- (e) Мөрдөн шалгах ажиллагааны цогц байдлыг хангах үүднээс хүлээн авсан эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт, түүнд агуулагдаж байгаа мэдээллийн нууцлалыг дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмын дагуу хадгалах

шаардлагатай. Хэрэв хүсэлтийн нууцлалыг хангах боломжгүй бол нөгөө талд энэ тухай нэн даруй мэдэгдэнэ.

Улс орнууд эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт нь албадлагын арга хэмжээтэй холбоогүй тохиолдолд харилцан гэмт хэрэгт (dual criminality) тооцсоны үндсэн дээр туслалцаа үзүүлнэ гэж шаардаж болохгүй. Улс орнууд харилцан гэмт хэрэгт тооцох (dual criminality) нөхцөл бүрдээгүй нөхцөлд өргөн хүрээний эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх боломжтой арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Улс орнууд харилцан гэмт хэрэгт тооцсоны үндсэн дээр (dual criminality) эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх шаардлагатай болсон тохиолдолд улсууд гэмт хэргийг нэг ижил ангиллын гэмт хэрэгт хамруулж үздэг эсэх, тухайн гэмт хэргийг тайлбарлахдаа нэг ижил нэр томьёо ашигладаг эсэхээс үл хамаарч тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон нь шаардлагыг биелүүлсэн гэж үзэхэд хангалттай байна.

Хэрэв гадаадын шүүх болон хууль сахиулах байгууллага нь дотоодын ижил төстэй байгууллагуудад шууд хүсэлт гаргасан нь дотоодын тогтолцоонд нийцэж байвал 31 дүгээр зөвлөмжийн дагуу дотоодын эрх бүхий байгууллагууд нь өөрийн эрх мэдэл, мөрдөн шалгах арга техникийн хүрээнд Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтэд хариулж болно. Эдгээр эрх мэдэл, арга техникт дараах зүйлсийг хамруулан үзнэ. Үүнд:

- (a) Санхүүгийн байгууллага, хувь хүнээс мэдээлэл, баримт, нотолгоо (тухайлбал, санхүүгийн бүртгэл) хайх, гаргуулан авах болон гэрчийн мэдүүлэг авах;
- (b) Бусад өргөн хүрээтэй эрх мэдэл, мөрдөн шалгах арга техник.

Гэмт хэрэгт яллах ажиллагаа хэд хэдэн улсын нутаг дэвсгэр дээр явагдах нөхцөл үүссэн тохиолдолд харьяаллын зөрчил үүсэхээс сэргийлэх, яллагдагчид шударга ёс, хуулийн дагуу яллах хамгийн тохиромжтой байршлыг тодорхойлох, хэрэгжүүлэх механизмыг бий болговол зохино.

Улс орнууд эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт гаргахдаа хүсэлтээ түргэн шуурхай, үр дүнтэй шийдвэрлүүлэх зорилгоор шаардлагатай баримт, мэдээлэл болон хууль, эрх зүйн холбогдох мэдээллийг бүрэн өгөх бөгөөд хүсэлтийг хэр яаралтай шийдүүлэх шаардлагатай байгааг тодорхой бичиж, цаад талд түргэн шуурхай хүргүүлэх арга хэмжээ авах шаардлагатай. Улс орнууд нь эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт явуулахаасаа өмнө туслалцааг авахтай холбогдсон хууль, эрх зүйн шаардлага, процедурыг тодорхой судлах шаардлагатай.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх эрх бүхий байгууллага (ж.нь Төв байгууллага) нь санхүүгийн, хүний нөөцийн болон техникийн нөөц бололцоогоор бүрэн хангагдсан байх хэрэгтэй. Түүнчлэн энэ байгууллагын ажилтан нь мэргэжлийн

түвшинд бэлтгэгдсэн, нууцлалыг өндөр түвшинд хадгалдаг, шударга ёсыг хангасан, зохих мэргэжил, ур чадвартай байх шаардлагатай.

38. Эрх зүйн харилцан туслалцаа: Хөрөнгө царцаах, хураах*

Улс орнууд мөнгө угаасан өмч хөрөнгө, мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс үүдэлтэй орлого, гэмт хэрэгт ашигласан буюу ашиглахаар завдсан хэрэгсэл, дүйцэх дүнтэй өмч хөрөнгийг илрүүлэх, царцаах, битүүмжлэх, хураан авах, гаднаас ирсэн хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх эрх бүхий байгууллагатай байвал зохино. Үүнд бусад улс орноос эрүүгийн шийтгэлгүй хөрөнгө хураах /non conviction based/-аар тавьсан хүсэлтийг дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшлаагүй тохиолдолд хэрэгжүүлэх орно. Ийм хөрөнгө, хэрэгсэл, дүйцэхүйц үнэтэй өмчийг битүүмжлэх, хураан авах зорилгоор үйл ажиллагааг чиглүүлэх, удирдах, хураасан хөрөнгийг хувиарлах үр дүнтэй тогтолцоотой байвал зохино.

39. Гэмт хэрэгтэн шилжүүлэх

Улс орнууд МУТС-тэй холбоотойгоор гэмт хэрэгтнийг шилжүүлэх хүсэлтийг түргэн шуурхай, үр дүнтэй, үндэслэлгүй саатуулалгүйгээр гүйцэтгэвэл зохино. Улс орнууд терроризмыг санхүүжүүлэх, террорист үйл ажиллагаа эсвэл террорист байгууллагыг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдсон этгээдийг орогнуулахгүй байвал зохино. Улс орнууд ялангуяа дараах зүйлст анхаарна:

- (a) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбоотой этгээдийг гадаад улсад шилжүүлэх боломжтой гэмт хэргийн ангилалд оруулах;
- (b) Хэрэгтнийг шилжүүлэх хүсэлтийг түргэн шуурхай, нэн даруй гүйцэтгэх арга хэмжээтэй байх. Хүсэлтийг хэрэгжүүлж байгаад хяналт тавих үүднээс хүсэлтийн удирдлагын системтэй байвал зохино;
- (c) Хүсэлтүүдийг гүйцэтгэхэд хэт үндэслэлгүй, хязгаарласан шаардлага тавихгүй байх;
- (d) Хэрэгтэн шилжүүлэх хууль, эрх зүйн орчинг бүрдүүлсэн байх.

Аливаа улс орон өөрийн иргэнээ шилжүүлж өгөхийг зөвшөөрөх ёстой эсвэл иргэншилтэй холбоотойгоор тухайн улс орон шилжүүлж өгөхөөс татгалзаж байгаа бол цаг алдалгүйгээр өөрийн эрх бүхий байгууллагуудад шилжүүлж, нөгөө улсаас ирүүлсэн хүсэлтэд дурдсан хэргийг яллуулах шаардлагатай. Эдгээр эрх бүхий байгууллага нь дотоод хууль тогтоомжийнхоо дагуу хүнд, ноцтой гэмт хэргийг шалгадаг шигээ уг хэргийг мөрдөж шалгана. Яллах үйл ажиллагааг үр дүнтэй болгохын тулд улс орнууд мөрдөн шалгах болоод хэргийг нотлох тал дээр хамтран ажиллах шаардлагатай.

Улс орнууд харилцан гэмт хэрэгт тооцсоны үндсэн дээр (dual criminality) эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх шаардлагатай тохиолдолд улсууд гэмт хэргийг нэг ижил ангиллын гэмт хэрэгт хамруулж үздэг эсэх, тухайн гэмт хэргийг тайлбарлахдаа нэг ижил нэр томъёо ашигладаг эсэхээс үл хамаарч тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон нь шаардлагыг биелүүлсэн гэж үзэж харилцан эрх зүйн туслалцааг үзүүлнэ.

Дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчимтай нийцэж байгаа тохиолдолд улс орнууд хэрэгтэн шилжүүлэх хялбаршуулсан механизмтай, тухайлбал, холбогдох байгууллагууд урьдчилан баривчлах хүсэлтийг өөр хоорондоо шууд тавих; зөвхөн баривчлах шийдвэр, шүүхийн шийдвэрийн дагуу хэрэгтэн шилжүүлэх; хэрэгтэн шилжүүлэх албан ёсны процедураас татгалзаж байгаа этгээдийг өөрөө зөвшөөрсөн тохиолдолд хялбаршуулсан байдлаар шилжүүлэх зэрэг механизмтай байвал зохино. Гэмт хэрэгтэн шилжүүлэх эрх бүхий байгууллага нь санхүүгийн, хүний нөөцийн болон техникийн нөөц бололцоогоор бүрэн хангагдсан байх хэрэгтэй. Түүнчлэн энэ байгууллагын ажилтан нь мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, нууцлалыг өндөр түвшинд хадгалдаг, шударга ёсыг хангасан, зохих мэргэжил, ур чадвартай байх шаардлагатай.

40. Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэр*

Эрх бүхий байгууллага нь олон улсын хамтын ажиллагааны хүрээнд мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотойгоор бүхий л төрлийн туслалцааг түргэн шуурхай, үр дүнтэй үзүүлвэл зохино. Улс орнууд өөр хоорондоо хүсэлтийн дагуу болон сайн дурын үндсэн дээр хамтран ажиллах бөгөөд хамтран ажиллаж, харилцан туслалцаа үзүүлэх хууль, эрх зүйн үндэс суурийг бий болгох шаардлагатай. Эрх бүхий байгууллага нь олон улсын хамтын ажиллагааны хамгийн үр дүнтэй арга хэрэгслүүдийг ашиглавал зохино. Эрх бүхий байгууллага нь ХОСБ зэрэг хоёр эсвэл олон талын гэрээ хэлэлцээр байгуулах шаардлагатай бол ийм баримт бичгүүдийг аль болох олон улстай түргэн шуурхай байгуулна.

Эрх бүхий байгууллага нь мэдээлэл хүссэн хүсэлтийг шийдвэрлэх, мэдээлэл шилжүүлэх болон бусад төрлийн туслалцаа үзүүлэх ажиллагааг үр дүнтэй авч хэрэгжүүлэх тодорхой механизм, сувгуудтай байна. Эрх бүхий байгууллага нь хүсэлтийн ач холбогдлын эрэмбийг тогтоож, түргэн шуурхай гүйцэтгэх, хүлээн авсан мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үр дүнтэй арга хэрэгслүүдтэй байвал зохино.

ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖИЙН ТАЙЛБАР

ЗӨВЛӨМЖ 1-ИЙН ТАЙЛБАР

(ЭРСДЭЛЭЭ ҮНЭЛЭХ, ЭРСДЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ)

1. Эрсдэлд суурилсан аргачлал (ЭСА) нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй арга юм. Улс орнууд ЭСА-ийг тухайн салбарт хэрэгжүүлэхдээ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үйл ажиллагааны туршлага, чадамжийн талаар бодолцох хэрэгтэй. ЭСА-ыг хэрэгжүүлэхдээ өөрийн сонголтоор шийдэх эрх, хүлээлгэх хариуцлага талаасаа МУТСТ үйл ажиллагааны боломж, туршлага ихтэй санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ) салбарт илүү тохиромжтой. Энэ нь санхүүгийн байгууллага, СББМҮҮ-дийг өндөр эрсдэлтэй нөхцөл байдал илрүүлсэн тохиолдолд тэднийг өргөтгөсөн арга хэмжээ авах шаардлагаас чөлөөлөх ёсгүй. Эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлснээр эрх бүхий байгууллага, санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх болон багасгах арга хэмжээ нь тогтоосон эрсдэлийн түвшинтэй уялдаж, өөрийн нөөцийг хамгийн үр дүнтэй ашиглах талаар шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ.
2. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нь ЭСА-ыг хэрэгжүүлэхдээ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ тодорхойлох, үнэлэх, хянах, удирдах болон бууруулах зохицуулалттай байна. ЭСА-ын ерөнхий зарчим бол улс орнууд эрсдэл өндөр байгаа тохиолдолд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-ээс эдгээр эрсдэлээ удирдах, бууруулах талаар өргөтгөсөн арга хэмжээ авахыг шаардах ёстой; мөн эрсдэл багатай тохиолдолд хялбаршуулсан арга хэмжээг авахыг зөвшөөрч болно. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэсэн сэжиг байгаа тохиолдолд хялбаршуулсан арга хэмжээ авахыг зөвшөөрөх ёсгүй. Зөвлөмжийн хэсгүүд энэ ерөнхий зарчим нь тодорхой шаардлагад хэрхэн нийцэхийг илүү нарийвчлан заасан болно. Түүнчлэн улс орнууд маш хязгаарлагдмал нөхцөлд, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл багатай тохиолдолд тодорхой Зөвлөмжийг санхүүгийн байгууллага эсвэл үйл ажиллагаанд, эсвэл СББМҮҮ-д хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно (доор үзнэ үү). Үүнтэй адилаар, улс орнууд эрсдэлийн үнэлгээгээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлтэй гэж тодорхойлсон санхүүгийн байгууллага эсвэл СББМҮҮ-ийн тодорхойлолтод хамрагдаагүй байгууллага, үйл ажиллагаа, бизнес эсвэл мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч илэрсэн тохиолдолд энэ салбарт МУТСТ шаардлагыг хэрэгжүүлэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

А. Улс орнуудын хүлээх үүрэг, шийдвэр

3. **Эрсдэлээ үнэлэх** - Улс орнууд¹ нь (i) хууль, тогтоомж, бусад арга хэмжээний өөрчлөлт зэрэг тухайн улсын МУТСТ тогтолцоонд гарсан өөрчлөлтийн талаар мэдээлэх; (ii) МУТСТ нөөцийг эрх бүхий байгууллагаас хуваарилах, эрэмбэлэхэд ашиглах; (iii) эрсдэлийн үнэлгээ хийх санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-ийг мэдээллээр хангахын тулд өөрсдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ байнга тодорхойлох, үнэлэх чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай байна. Улс орнууд эрсдэлийн үнэлгээг байнга шинэчилж, үр дүнгийн талаар холбогдох бүх эрх бүхий байгууллага, өөрийгөө зохицуулах байгууллага (ӨЗБ), санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-ийг холбогдох мэдээллээр хангах механизмтай байх ёстой.
4. **Өндөр эрсдэл** - Улс орнууд өндөр эрсдэл илрүүлсэн тохиолдолд, МУТСТ тогтолцоонд энэ өндөр эрсдэлээ тусгаж, өндөр эрсдэлээ бууруулахын тулд авч байгаа бусад арга хэмжээ авахад саад учруулахгүйгээр санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-д өргөтгөсөн арга хэмжээ авахыг даалгаж эсвэл эрсдэлээ зохих ёсоор зохицуулах, бууруулах зорилгоор санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ-ийн хийж буй эрсдэлийн үнэлгээнд энэ мэдээллийг оруулсан эсэхийг баталгаажуулах шаардлагатай. ФАТФ-ын Зөвлөмжид өндөр эрсдэлтэй гэж үзсэн нэмэлт эсвэл тодорхой арга хэмжээ авахыг шаардсан тохиолдолд шаардлагатай бүх арга хэмжээг авах бөгөөд эрсдэлийн түвшингээс шалтгаалан ямар хэмжээнд хэрэгжүүлэх үү гэдгээ шийдэж болно.
5. **Бага эрсдэл** - Улс орнууд бага эрсдэлтэй гэж тодорхойлсон бөгөөд энэ нь 3 дахь хэсэгт заасанчлан тухайн улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээтэй нийцэж байгаа тохиолдолд ФАТФ-ын зарим зөвлөмжийг санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-д хялбаршуулсан хэлбэрээр хэрэгжүүлэхээр зөвшөөрч болно.

Өмнөх хэсэгтэй уялдуулан эрсдэлийн тодорхой ангиллыг тодорхойлох шийдвэр гаргахаас үл хамааран дараах Б хэсэгт ("Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-ийн үүрэг, хариуцлага") болон 7-р хэсэгт заасан шаардлагууд хангагдсан тохиолдолд улс орнууд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт хялбаршуулсан харилцагчийг таньж мэдэх (ХТМ) үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч болно.

6. **Хамаарахгүй байх** - Улс орнууд дараах тохиолдолд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-ээс тодорхой арга хэмжээ авахыг шаардсан ФАТФ-ын зарим зөвлөмжийг мөрдөхгүй байхаар шийдвэрлэж болно:

- (a) мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бага гэдэг нь батлагдсан; энэ тохиолдолд маш хязгаарлагдмал, үндэслэлтэй нөхцөлтэй байх; санхүүгийн

¹ Энэ шаардлагыг нийт үндэсний хэмжээнд МУТСТ эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэхээр биелэлтийг үнэлэх хэрэгтэй.

байгууллага болон СББМҮҮ-ийн үйл ажиллагааны тодорхой хэлбэр, үйл ажиллагааг хамаарсан байх;

- (б) хувь хүн, хуулийн этгээд нь санхүүгийн үйл ажиллагааг (мөнгө, үнэт зүйл шилжүүлэхээс бусад) маш хязгаарлагдмал хүрээнд буюу цөөн тоотой хийдэг бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бага байх тохиолдолд.

Цуглуулсан мэдээлэл нь эрсдэлийн түвшингээс хамааран өөр байж болох ч, мэдээллийг хадгалах Зөвлөмж 11-ийн шаардлага нь цуглуулсан бүх мэдээлэлд хамаарах ёстой.

7. **Эрсдэлийн хяналт, шалгалт** - Хянан шалгалгч (эсвэл СББМҮҮ салбарын өөрийгөө зохицуулах байгууллага (ӨЗБ)) нь санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ-ууд дор дурдсан үүргийг үр дүнтэй хэрэгжүүлж байгааг баталгаажуулах ёстой. Энэ чиг үүргийг гүйцэтгэхдээ хянан шалгалгч болон ӨЗБ нь Зөвлөмж 26, 28-ийн Тайлбарт заасанчлан шаардлагатай бол санхүүгийн байгууллага, СББМҮҮ-ээс боловсруулсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн төрөл, үнэлгээтэй танилцаж үнэлэлт өгөхдөө ашиглана.

Б. Санхүүгийн байгууллага, СББМҮҮ үүрэг болон авах арга хэмжээ

8. **Эрсдэлээ үнэлэх** - Санхүүгийн байгууллага, СББМҮҮ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ (үйлчлүүлэгч, улс орон эсвэл газар зүйн бүс; бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ эсвэл түгээх сувгийн) тодорхойлох, үнэлэх талаар зохих арга хэмжээ авах шаардлагатай. Эдгээр этгээд нь эрсдэлийн үнэлгээний баримт материалыг баримтжуулан, үнэлгээний үндэслэлийг харуулж, үнэлгээг шинэчлэж байгааг баримтжуулж эрх бүхий байгууллага болон ӨЗБ-д эрсдэлийн үнэлгээний мэдээллийг өгөх зохих механизмтай байх ёстой. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн аливаа үнэлгээний шинж чанар, цар хүрээ нь тухайн бизнесийн шинж чанар, хэмжээтэй тохирч байх ёстой. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нь өөрсдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ үргэлж ойлгож байх ёстой, гэхдээ эрх бүхий байгууллага болон ӨЗБ нь тухайн салбартай холбоотой үндсэн эрсдэлийг тодорхойлж ойлгосон тохиолдолд тусгайлсан эрсдэлийн үнэлгээг тусад нь хийх шаардлагагүй гэж үзэж болно.
9. **Эрсдэлийн менежмент болон бууруулах арга хэмжээ** - Санхүүгийн байгууллага, СББМҮҮ нь тодорхойлсон (улс орон, санхүүгийн байгууллага болон СББМҮҮ) эрсдэлээ үр дүнтэй удирдах, бууруулах бодлого, хяналт болон дүрэм журамтай байх шаардлагатай. Эдгээр байгууллагууд нь хэрэгжилтэндээ хяналт тавьж шаардлагатай бол сайжруулах хэрэгтэй. Бодлого, хяналт болон дүрэм журмыг дээд шатны удирдлага батлах бөгөөд эрсдэлээ (бага болон өндөр) удирдах, бууруулах арга

хэмжээ нь үндэсний шаардлага болон ӨЗБ-ын гаргасан аргачлалтай нийцсэн байвал зохино.

10. **Өндөр эрсдэл** - Өндөр эрсдэл тогтоогдсон тохиолдолд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-ээс эрсдэлээ удирдах, бууруулах өргөтгөсөн арга хэмжээ авахыг шаардана.
11. **Бага эрсдэл** - Бага эрсдэл тогтоогдсон тохиолдолд улс орнууд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-д эдгээр эрсдэлийг удирдах, бууруулах хялбаршуулсан арга хэмжээ авахыг зөвшөөрч болно.
12. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нь эрсдэлээ үнэлэхээс өмнө нийт эрсдэл болон түүнийг бууруулах зохих арга хэмжээг тодорхойлоход хамаатай эрсдэлийн бүх хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нь авах арга хэмжээний түвшинг эрсдэлийн төрөл, түвшин болон бусад нөлөөлөх хүчин зүйлсээс хамаарч ялгаатай тогтоож болно (жишээ нь тодорхой нөхцөлд үйлчлүүлэгчийг хүлээн зөвшөөрөхдөө ердийн ХТМ-ийг хэрэглэж болох боловч хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд нэмэлт ХТМ арга хэмжээ авах гэх мэт, эсвэл эсрэгээр нь хэрэгжүүлж болно).

ЗӨВЛӨМЖ 3-ЫН ТАЙЛБАР

(МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ)

1. Улс орнууд мөнгө угаахыг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенц (Венийн конвенц) болон НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны конвенц (Палермо конвенц)-ийн дагуу гэмт хэрэгт тооцно.
2. Улс орнууд мөнгө угаах гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг хамруулж, өргөн хүрээний суурь гэмт хэргийг хамруулвал зохино. Суурь гэмт хэрэгт бүх гэмт үйлдлийг; эсхүл хүнд гэмт хэргийн ангилалд хамаарах үйлдлийг хамруулах; эсхүл суурь гэмт хэрэгт оногдуулах хорих ялаас (босго аргачлал) хамааран; эсвэл суурь гэмт хэргийн жагсаалт гарган; эсвэл эдгээр аргуудыг хослуулан холимог аргагчлалаар хамруулж болно.
3. Улс орнууд босго аргачлал хэрэглэсэн тохиолдолд суурь гэмт хэрэгт үндэсний хууль тогтоомжийн дагуу хүнд гэмт хэргийн ангилалд багтдаг бүх гэмт хэргийг хамруулах, эсвэл нэг жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгэдэг гэмт хэргийг хамруулах; гэмт хэргийн хамгийн бага ялыг тогтоодог хууль эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудын хувьд суурь гэмт хэрэг нь зургаан сараас дээш хугацаагаар хорих ялаар шийтгэдэг бүх гэмт хэргийг хамруулвал зохино.
4. Ямар аргачлалыг хэрэглэхээс үл хамааран улс орнууд суурь гэмт хэргийн ангилалд орсон хэд хэдэн төрлийн гэмт үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт хамруулах шаардлагатай. Мөнгө угаах гэмт хэрэгт бүх төрлийн хөрөнгийг үнийн дүнгээс үл хамааран, гэмт хэргээс шууд ба шууд бусаар олсон эсэхээс үл хамааран хамруулах шаардлагатай. Тухайн хөрөнгө нь гэмт хэрэг үйлдэж олсон гэдгийг тогтооход тухайн этгээд нь заавал суурь гэмт хэргээр яллагдсан байхыг шаардаж болохгүй.
5. Бусад улсад үйлдэгдсэн суурь гэмт хэрэг нь дотоодод үйлдэгдсэн тохиолдолд суурь гэмт хэрэг гэж тооцогдох байсан бол мөнгө угаахтай холбоотой суурь гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай. Улс орнууд суурь гэмт хэрэгт хамруулах шалгуураар зөвхөн дотоодод үйлдэгдсэн тохиолдолд суурь гэмт хэрэгт тооцогдох байсан бол гэсэн нөхцөлийг тавьж болно.
6. Улс орнууд дотоод хууль тогтоомжийн үндсэн зарчимд нийцүүлэн мөнгө угаах гэмт хэрэгт суурь гэмт хэргийг үйлдсэн хүмүүс хамаарахгүй байхаар тусгаж болно.
7. Улс орнууд дараах зүйлсийг баталгаажуулах хэрэгтэй:
 - a. Мөнгө угаах гэмт хэргийг нотлоход шаардагдах зорилго болон мэдсэн байх шаардагдах мэдээллийг бодит, объектив нөхцөл байдлаас нотлох.

- b. Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд үр дүнтэй, гаргасан үйлдэлд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
- c. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага (дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмын дагуу) хүлээлгэх боломжгүй бол иргэний эсвэл захиргааны хариуцлага, шийтгэл ноогдуулна. Энэ нь олон төрлийн хариуцлага оногдуулах боломжтой улс орны хувьд хуулийн этгээдтэй холбоотой эрүүгийн, иргэний эсвэл захиргааны хэргийн зэрэгцээ ажиллагаа явуулахад саад болох ёсгүй. Ийм арга хэмжээ нь хувь хүний эрүүгийн хариуцлагаас хамааралгүй байх ёстой. Энэ нь олон төрлийн хариуцлага оноох боломжтой улс оронд давхар эрүүгийн, иргэний эсвэл захиргааны журмаар хариуцлага хүлээлгэхэд саад болох ёсгүй. Эдгээр арга хэмжээ нь хувь хүнийг эрүүгийн хариуцлагад татахад саад болохгүй байх шаардлагатай. Хариуцлага болон шийтгэл нь үр дүнтэй гаргасан үйлдэлд нь дүйцэхүйц дахин үйлдэхээс сэргийлсэн байх шаардлагатай.
- d. Дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшлахгүй бол мөнгө угаах гэмт хэрэгт оролцсон, хамтран зохион байгуулсан, үйлдэхийг завдсан, дэмжлэг үзүүлсэн, нөхцөл бололцоогоор хангаж өгсөн, захиалсан, зөвлөгөө мэдээллээр хангасан зэрэг мөнгө угаах гэмт хэргийн хавсралт үйлдлүүд нь гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 4 болон 38-ЫН ТАЙЛБАР

(ХӨРӨНГӨ ХУРААХ БОЛОН ТҮР ЗУУРЫН АРГА ХЭМЖЭЭ)

Улс орнууд эрх бүхий байгууллагад царцаасан, битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг үр дүнтэй удирдах, шаардлагатай тохиолдолд захиран зарцуулах тогтолцоог бий болговол зохино. Энэ тогтолцоо нь дотоод болон гадаад улс орнын хүсэлтийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжвэл зохино.

ЗӨВЛӨМЖ 5-ЫН ТАЙЛБАР

(ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГ)

А.Зорилго

1. Улс орнуудад терроризмыг санхүүжүүлсэн этгээдийг мөрдөн шалгах болон эрүүгийн хариуцлагад татах эрх зүйн чадамжийг олгох зорилгоор Зөвлөмж 5-ыг боловсруулсан. Олон улсын терроризм, тухайлбал мөнгө угаах гэмт хэрэгтэй нягт уялдаатай байдгийг харгалзан Зөвлөмж 5-ын өөр нэг зорилго нь улс орнуудад терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт хамруулахыг үүрэг болгосноор энэ холбоосыг онцолж өгөх явдал юм.

Б.Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн шинж чанар

2. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт мөнгө болон бусад хөрөнгийг аливаа хэлбэрээр (а) террорист үйл ажиллагаа (нууд) явуулахад; (b) террорист байгууллагад; (c) террорист этгээд бүхлээр нь болон хэсэгчлэн хэрэглэхийг мэдсээр байж эсхүл хууль бусаар тэдэнд ашиглуулах зорилгоор шууд болон шууд бусаар, сайн дураараа өгсөн эсхүл цуглуулж байгаа этгээдийг хамруулах шаардлагатай.
3. Терроризмыг санхүүжүүлэхэд оршин сууж байгаа болон харьяалалын улс орноос бусад улс оронд зорчиж террорист үйл ажиллагаа явуулах, төлөвлөх, бэлтгэх, оролцох, террорист үйл ажиллагааны сургалт хийх, сургалтад оролцох зорилгоор аялсан этгээдийг санхүүжүүлэх хамрах шаардлагатай.
4. Терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг зөвхөн туслах болон дэмжлэг үзүүлэх, оролдлого, үгсэн хуйвалдах үйлдлийн үндсэн дээр гэмт хэрэгт тооцох нь энэ Зөвлөмжийг биелүүлэхэд хангалтгүй болно.
5. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хууль ёсны болон хууль бус эх үүсвэрээс олсноос үл хамааран аливаа мөнгө болон бусад хөрөнгө хамруулах шаардлагатай.
6. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт тооцохын тулд мөнгө болон бусад хөрөнгийг (а) террорист үйл ажиллагаанд ашигласан буюу ашиглахыг завдсан; эсхүл (b) тодорхой террорист үйлдэлтэй(үүдтэй) холбогдсон байх шаардлага тавих ёсгүй.
7. Улс орнууд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг нотлоход шаардагдах зорилго болон санаатайгаар үйлдсэн нөхцөлийг хэргийн объектив бодит хүчин зүйлсээр баталгаажуулах ёстой.
8. Терроризмыг санхүүжүүлсэн хувь хүнд үр дүнтэй, гаргасан үйлдэлд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

9. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага (дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмын дагуу) хүлээлгэх боломжгүй бол иргэний эсвэл захиргааны хариуцлага, шийтгэл ноогдуулна. Энэ нь олон төрлийн хариуцлага оногдуулах боломжтой улс орны хувьд хуулийн этгээдтэй холбоотой эрүүгийн, иргэний эсвэл захиргааны хэргийн зэрэгцээ ажиллагаа явуулахад саад болох ёсгүй. Ийм арга хэмжээ нь хувь хүний эрүүгийн хариуцлагаас хамааралгүй байх ёстой. Хариуцлага болон шийтгэл нь үр дүнтэй, гаргасан үйлдэлд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн байх шаардлагатай.
10. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдэх гэж оролдох нь мөн гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай.
11. Мөн дараах үйлдэлд оролцох нь гэмт хэрэгт тооцогдож байх шаардлагатай:
- (a) Энэ Тайлбарын 2, 9-р зүйлд тусгасан үйлдэлд хамтран оролцогч байх;
 - (b) Энэ Тайлбарын 2, 9-р зүйлд тусгасан үйлдлийг гүйцэтгэх зорилгоор бусдыг зохион байгуулах, чиглүүлэх;
 - (c) Энэ Тайлбарын 2, 9-р зүйлд тусгасан үйлдлийг нэгэн зорилготой бүлэг этгээд гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн бол. Ийм туслалцаа нь санаатай үйлдэл бөгөөд (i) энэ бүлгийн үйл ажиллагаа болон зорилго нь терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой бөгөөд бүлгийн гэмт хэргийн үйл ажиллагаа болон зорилгыг дэмжих зорилгоор, (ii) бүлгийг терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулах зорилгыг мэдсээр байж үйлдсэн бол.
12. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг тухайн гэмт хэрэг(үүд)-ийг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа этгээд террорист үйл ажиллагаа явагдсан/явагдах болон террорист этгээд(үүд)/байгууллага(ууд) байрлаж байгаа улсаас өөр улсад байрлаж байгаагаас үл хамааран гэмт хэрэгт тооцох шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 6-ЫН ТАЙЛБАР

(ТЕРРОРИЗМ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ЗОРИЛТОТ САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ)

А.Зорилго

1. Зөвлөмж 6 нь улс орнууд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолыг биелүүлж санхүүгийн зорилтот хориг арга хэмжээнд орсон (i) НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс НҮБ-ын Дүрмийн 7 дугаар бүлгийг үндэслэн, Аюулгүйн Зөвлөлийн 1267 (1999) тогтоол болон дагалдан гарсан тогтоолд² тусгасны дагуу жагсаалтад орсон аливаа хүн³ эсвэл этгээдэд; эсвэл (ii) Аюулгүйн Зөвлөлийн 1373 (2001) тогтоолын дагуу тухайн улсаас жагсаалтад оруулсан аливаа хувь хүн, этгээдийн мөнгө болон бусад хөрөнгийг хугацаа алдалгүй царцаах, хөрөнгө мөнгөөр хангахгүй байх шаардлагатай.
2. Зөвлөмж 6-д заасан үүрэг нь Зөвлөмж 4 (хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ)⁴-ийн дагуу эрүүгийн, иргэний, захиргааны үйл ажиллагааны явцад мөнгө болон бусад хөрөнгөтэй холбоотой авч байгаа арга хэмжээг орлох зорилгогүй. Зөвлөмж 6-д заасан арга хэмжээг хоригт орсон хувь хүн, этгээдийн эсрэг эрх бүхий байгууллага эсвэл шүүхээс хэрэгжүүлж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд нэмэлтээр ашиглаж болох боловч арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл болж болохгүй. Зөвлөмж 6-ын гол зорилго нь террорист бүлэглэлийн мөнгө болон бусад хөрөнгийн урсгалыг зогсоох, мөнгө болон бусад хөрөнгийг террорист бүлэглэл ашиглахыг зогсооход шаардлагатай онцгой урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах юм. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны хүрээг тодорхойлох, өргөн хүрээний дэмжлэг авахын тулд улс орнууд хүний эрхийг хүндэтгэх, хууль дээдлэх зарчмыг хүндэтгэн, гэм зэмгүй гуравдагч этгээдийн эрхийг хүлээн зөвшөөрөх ёстой.

² Зөвлөмж 6 нь Аюулгүйн Зөвлөлийн 1267 (1999) тогтоол, дагалдан гарсан тогтоол болон НҮБ-ын АЗ-ийн терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гаргах зорилтот санхүүгийн хориг арга хэмжээний тогтоолууд хамаарна. Энэ Тайлбарыг гаргах үед (2012 оны 2 дугаар сар) 1267 (1999) тогтоолын дагалдан гарсан тогтоолоор дараах тогтоолууд байв: 1333 (2000), 1363 (2001), 1390 (2002), 1452 (2002), 1455 (2003), 1526 (2004), 1617 (2005), 1730 (2006), 1735 (2006), 1822 (2008), 1904 (2009), 1988 (2011), and 1989 (2011).

³ Хувь хүн болон хуулийн этгээд

⁴ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенц (Венийн конвенц), НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны конвенц (Палермо конвенц)-д үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбоотойгоор царцаах, битүүмжлэх, хураан авах үүргийг тусгасныг мөрдлөг болгоно. Нэмэлтээр Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц (1999)-д терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотойгоор царцаах, битүүмжлэх, хураан авах үүргийг тусгасныг мөрдлөг болгоно. Эдгээр үүргүүд нь Зөвлөмж 6 болон НҮБ-ын АЗ-ийн терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой тогтоолоос тусдаа үүргүүд юм.

Б. ТЕРРОРИСТ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИЖ БАЙГАА БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЖ БАЙГАА ХУВЬ ХҮН, ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ, ЖАГСААЛТАД ОРУУЛАХ

3. 1267-р тогтоол (1999) болон дагалдан гарсан тогтоолын хувьд 1267 Хороо Аль-Каидатай холбоотой хориг арга хэмжээний жагсаалтыг гаргадаг бол Талибан болон Афганистантай холбогдох эрсдэлийг 1988 Хороо хориг арга хэмжээний жагсаалтыг гаргадаг бөгөөд энэ хоёр хороо нь НҮБ-ын Дүрмийн 7 дугаар бүлгийн бүрэн эрхийг үндэслэн үйл ажиллагаагаа явуулж байна. 1373 (2001) тогтоолын хувьд улс орнууд үндэстний хэмжээнд өөрийн улс орны санаачлагаар эсвэл өөр улсаас ирсэн хүсэлтийг хүлээн авсан улс холбогдох хууль тогтоомжийн дагуу хүсэлт гаргасан заалтыг 1373 (2001) тогтоолын E хэсэгт заасан жагсаалтад оруулах тусгай шалгууруудыг хангаж байгаа гэж үзэх үндэслэлтэй болон үндэслэлтэй гэж сэжиглэх боломжтой бол жагсаалтад оруулна.
4. Улс орнууд Аюулгүйн Зөвлөлийн тогтоолд⁵ тусгасан үүрэгт нийцүүлэн Аюулгүйн Зөвлөлийн 1267 (1999) тогтоол болон дагалдан гарсан тогтоолд хамаарах хувь хүн, этгээдийг жагсаалтад оруулах саналыг тодорхойлох болон санал болгох эрх мэдэлтэй, үр дүнтэй дүрэм, журам, аргачлал, байгууллагатай байх ёстой. Аюулгүйн Зөвлөлийн тогтоолын дагуу Аюулгүйн Зөвлөлийн жагсаалтад суурилсан хөтөлбөрт нийцүүлэн Аюулгүйн Зөвлөлд хувь хүн, этгээдийг хоригийн жагсаалтад оруулах санал гаргахад дээрх эрх мэдэл, журам, аргачлал нэн чухал болно. Улс орнууд Аюулгүйн Зөвлөлийн тогтоолд тусгасан үүрэгт нийцүүлэн Аюулгүйн Зөвлөлийн S/RES/1373 (2001) тогтоолд хамаарах хувь хүн, байгууллагыг жагсаалтад оруулах саналыг тодорхойлох болон санал болгох эрх мэдэлтэй, үр дүнтэй дүрэм журам, аргачлал бүхий байгууллагатай байх ёстой. Дээрх эрх мэдэл, журам, аргачлал нь 1373 (2001) тогтоолын E хэсэгт тодорхойлсон тусгай шалгуурыг хангасан хувь хүн, этгээдийг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай. Аюулгүйн Зөвлөлийн 1267 (1999) болон дагалдан гарсан тогтоолыг болон 1373 (2001) тогтоолыг хэрэгжүүлэх улс орны тогтолцоо дараах шаардлагатай зүйлсийг тусгасан байх хэрэгтэй:
 - a. Улс орнууд эрх бүхий байгууллага эсвэл шүүхэд дараах үүргийг хариуцуулах шаардлагатай:
 - (i). Эрх бүхий байгууллага нь АЗ-ийн 1989 (2011) (Аль-Каидатай холбоотой) тогтоол болон дагалдан гарсан бусад тогтоолд заасан шалгуурыг хангасан гэж үзэх хангалттай нотлох баримттай үед хувь

⁵ Холбогдох Аюулгүйн Зөвлөлийн тогтоол нь улс орнуудаас холбогдох НҮБ-ын Хороонд хувь хүн этгээдийг тодорхойлж ирүүлэхийг шаардаагүй бөгөөд ийм эрх түүнийг хэрэгжүүлэх байгууллага үр дүнтэй журам, аргачлалтай байхыг л шаардсан болно.

хүн, этгээдийг 1267 Хороонд хоригийн жагсаалтад оруулахаар санал болгох;

- (ii). Эрх бүхий байгууллага нь АЗ-ийн 1988 (2011) (Афганистаны тогтвортой байдал аюулгүй байдалд заналхийлж байгаа Талибан болон Талибантай холбоо бүхий этгээдүүд) тогтоол болон дагалдан гарсан бусад тогтоолд заасан шалгуурыг хангасан гэж үзэх хангалттай нотлох баримттай үед хувь хүн, этгээдийг 1988 Хороонд хоригийн жагсаалтад оруулахаар санал болгох;
 - (iii). Эрх бүхий байгууллага нь АЗ-ийн 1373 (2001) тогтоолд заасан шалгуурыг хангасан гэж үзсэн, тухайн улс өөрийн санаачлагаар эсвэл өөр улсаас ирсэн хүсэлтийг хүлээн авсан улс холбогдох хууль тогтоомжийн дагуу хүсэлт гаргасан заалтыг 1373 (2001) тогтоолын E хэсэгт заасан жагсаалтад оруулах тусгай шалгууруудыг хангаж байгаа гэж үзэх үндэслэлтэй болон үндэслэлтэй гэж сэжиглэх боломжтой бол хоригийн жагсаалтад оруулахаар санал болгох.
- b. Улс орнууд 1988 (2011) тогтоол, 1989 (2011) тогтоол болон холбогдох тогтоол, 1373 (2001) (E хэсэгт заасан АЗ-ийн холбогдох тогтоолын хориг арга хэмжээний тусгай шалгуурыг харна уу) тогтоолуудад заасан хориг арга хэмжээний жагсаалтын шалгуур үзүүлэлтэд үндэслэн жагсаалтад оруулах этгээдийг тодорхойлох аргачлал(ууд)тай байх ёстой. Үүнд 1373 (2001) тогтоолд тусгасан бусад орны хөрөнгө царцаах механизмын дагуу хүсэлт гаргасан арга хэмжээг шалгаж хэрэгжүүлэх эрх мэдэл, үр дүнтэй журам болон аргачлалтай байх багтана. Улс орнуудын хооронд үр дүнтэй хамтын ажиллагааг хангахын тулд улс орнууд бусад орноос хүсэлт хүлээн авахдаа тухайн хүсэлт нь холбогдох (үндэстэн дамнасан) үндэсний зарчмын дагуу сэжиглэх үндэслэлтэй, "хангалттай үндэслэлтэй" эсвэл 1373 (2011) тогтоолын E хэсэгт тусгасан хориг арга хэмжээний жагсаалтад оруулах тусгай шаардлага хангасан эсэхийг тодорхойлох шаардлагатай.
- c. Эрх бүхий байгууллага нь Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолын дагуу хориг арга хэмжээний жагсаалтад оруулах шаардлага хангасан гэж үзсэн хувь хүн, этгээдийг тодорхойлохын тулд сэжиглэх үндэслэлтэй эсвэл хангалттай үндэслэлтэй болохын тулд бүх холбогдох эх үүсвэрээс холбогдох мэдээлэл цуглуулах, гаргуулж авах хуулиар олгогдсон эрх, журам болон аргачлалтай байна.
- d. Хориг арга хэмжээний жагсаалтад оруулах санал гаргах эсэхийг тогтоохдоо "үндэслэлтэй" эсвэл "хангалттай үндэслэлтэй" гэдгийг баримтжуулан баталгаажуулах стандарттай байна. Эрх бүхий байгууллага нь хувь хүн,

этгээдийг жагсаалтад оруулах, хөрөнгө царцаах ажиллагаа эхлүүлэхээр тодорхойлохдоо өөрийн улсын эрх зүйн тогтолцоог баримтлан нотлох баримтын чанар, хэмжээг үнэлж "үндэслэлтэй" эсвэл "хангалттай үндэслэлтэй" гэдгийг тогтооно. Үүнийг жагсаалтад оруулах санал тухайн улс орны өөрийн санаачлагаар эсвэл бусад улс орны санаачлагаар хийгдсэнээс үл хамааран хийнэ. Жагсаалтад оруулах санал нь гэмт хэргийн мөрдөн шалгах үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхээс хамаарах ёсгүй.

- e. Аль-Каидагийн хориг арга хэмжээний жагсаалтад оруулахаар 1267 Хороонд нэр санал болгоход 1267 (1999) тогтоол болон дагалдан гарсан тогтоолуудын дагуу улс орнууд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой:
- (i). 1267 Хорооноос баталсан жагсаалтад оруулах журам болон стандарт маягтыг дагаж мөрдөх;
 - (ii). жагсаалтад оруулахаар санал болгож буй этгээдийн нэртэй холбоотой холбогдох мэдээллийг бүрэн өгөх, тухайлбал хувь хүн, бүлэг, аж ахуйн нэгж, этгээдүүдийг зөв, баталгаатай тодорхойлох хангалттай мэдээлэл мөн боломжтой тохиолдолд Интерполын Тусгай Мэдэгдэл гаргахад шаардагдах мэдээллийг өгөх;
 - (iii). жагсаалтад оруулах үндэслэл, танилцуулга нь аль болох нарийвчилсан мэдээлэл агуулсан дэлгэрэнгүй байх ба үүнд: тухайн хүн эсвэл этгээд нь тухайн жагсаалтад орох холбогдох шалгуурыг хангаж байгааг нотлох мэдээллээр хангах (Е хэсэгт заасан Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолд тусгасан хориг арга хэмжээний жагсаалтад оруулах тусгай шалгуурыг үзнэ үү); мэдээллийн шинж чанар; дагалдах мэдээлэл болон танилцуулах баримт бичиг; санал болгож буй этгээд болон жагсаалтад байгаа этгээд хооронд ямар нэгэн холбоо, хамаарал байгаа бол энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл; тайлангийн хэсгийг гишүүн орны зүгээс 1267 Хороонд ирүүлэхдээ нууц гэж зааснаас бусад үед хүсэлт гаргасан тохиолдолд Жагсаалтад оруулах үндэслэл танилцуулгыг ил гаргах боломжтой байх;
 - (iv). тухайн улсын хориг арга хэмжээний жагсаалтад оруулах хүсэлтийг ил болгож болох эсэхийг тодорхойлох.
- f. Талибаны хориг арга хэмжээний жагсаалтад оруулахаар 1988 Хороонд нэр санал болгоход 1988 (2011) тогтоол болон дагалдан гарсан тогтоолуудын дагуу улс орнууд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой:
- (i). 1988 Хорооноос баталсан жагсаалтад оруулах журмыг дагаж мөрдөх;

- (ii). жагсаалтад оруулахаар санал болгож буй этгээдийн нэртэй холбоотой холбогдох мэдээллийг бүрэн өгөх, тухайлбал хувь хүн, бүлэг, аж ахуйн нэгж, этгээдүүдийг зөв, баталгаатай тодорхойлох хангалттай мэдээлэл мөн боломжтой тохиолдолд Интерполын Тусгай Мэдэгдэл гаргахад шаардагдах мэдээлэллийг өгөх;
 - (iii). жагсаалтад оруулах үндэслэл танилцуулга нь аль болох нарийвчилсан мэдээлэл агуулсан дэлгэрэнгүй байх ба үүнд: тухайн хүн эсвэл этгээд нь тухайн жагсаалтад орох холбогдох шалгуурыг хангаж байгааг нотлох мэдээллээр хангах (Е хэсэгт заасан Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолд тусгасан хориг арга хэмжээний жагсаалтад оруулах тусгай шалгуурыг үзнэ үү); мэдээллийн шинж чанар; дагалдах мэдээлэл болон танилцуулах баримт бичиг; санал болгож буй этгээд болон жагсаалтад байгаа этгээд хооронд ямар нэгэн холбоо, хамаарал байгаа бол энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл; тайлангийн хэсгийг гишүүн орны зүгээс 1988 Хороонд ирүүлэхдээ нууц гэж зааснаас бусад үед хүсэлт гаргасан тохиолдолд Жагсаалтад оруулах үндэслэл танилцуулгыг ил гаргах боломжтой байх;
- g. АЗ-ийн 1373 (2001) тогтоолын дагуу бусад улсаас хөрөнгө царцаах арга хэмжээ авахыг хүсэх тохиолдолд тухайн этгээдийн нэртэй холбоотой холбогдох мэдээллийг бүрэн өгөх, тухайлбал хувь хүн, бүлэг, аж ахуйн нэгж, этгээдүүдийг зөв, баталгаатай тодорхойлох хангалттай мэдээлэл өгөх, тухайн жагсаалтад орох холбогдох шалгуурыг хангаж байгааг нотлох мэдээллээр хангах (Е хэсэгт заасан Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолд тусгасан хориг арга хэмжээний жагсаалтад оруулах тусгай шалгуурыг үзнэ үү);
- h. Улс орнууд нь хориг арга хэмжээний жагсаалтад оруулахаар судлагдаж байгаа болон тодорхойлогдсон хувь хүн, этгээдийн талаар бие даасан хараат бус байдлаар (ex parte) шийдвэр гаргах журамтай байна.

В. ЖАГСААЛТАД ОРСОН ХҮН, ЭТГЭЭДИЙН МӨНГӨ БОЛОН БУСАД ХӨРӨНГИЙГ ЦАРЦААХ, МӨНГӨ БОЛОН БУСАД ХӨРӨНГӨӨР ХАНГАХЫГ ХОРИГЛОХ

5. Улс орнууд нь 1267 Хороо болон 1988 Хороо (АЗ-ийн 1267 (1999) тогтоол болон дагалдан гарсан тогтоолуудын хувьд)-ноос НҮБ-ын Дүрмийн 7 дугаар бүлгийн бүрэн эрхийн дагуу хориг арга хэмжээний жагсаалтад оруулсан хувь хүн этгээдийн эсрэг зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг хугацаа алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай. АЗ-ийн 1373 (2001) тогтоолын хувьд, жагсаалтад орсон хүн болон хуулийн этгээдийн мөнгө болон бусад хөрөнгийг царцаах, мөнгө болон бусад хөрөнгөөр хангахыг хориглох арга хэмжээг хугацаа алдалгүй авах шаардлага нь

үндэсний хэмжээнд хоригийн жагсаалтад оруулснаар хэрэгжин, тухайн улс өөрийн санаачлагаар эсвэл өөр улсаас ирсэн хүсэлтийг хүлээн авсан улс холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргасан хүсэлтийг 1373 (2001) тогтоолын Е хэсэгт заасан жагсаалтад оруулах тусгай шалгууруудыг хангаж байгаа гэж үзэх үндэслэлтэй болон хангалттай үндэслэлтэй гэж үзсэнээр хэрэгжинэ.

- б. Улс орнууд дараах стандарт, журмын дагуу зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй эрх бүхий байгууллагыг хуулийн хүрээнд байгуулна:
 - а. Улс орнууд⁶ нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн болон этгээдийн мөнгө болон бусад хөрөнгийг хугацаа алдалгүй, урьдчилан мэдэгдэлгүйгээр царцаахыг өөрийн улсын бүх хувь хүн, хуулийн этгээдээс шаардана. Энэ хөрөнгө царцаах үүрэг нь жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн эзэмшиж буй болон хяналтад байгаа бүх мөнгөн болон бусад хөрөнгө; эдгээр нь зөвхөн тодорхой нэгэн террорист үйлдэл, завдал болон аюул заналхийлэлтэй холбоотой хөрөнгөөр хязгаарлагдахгүй; жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн бүтнээр нь буюу тодорхой хувийг шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хяналтад байгаа хөрөнгө; жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хяналтад байгаа хөрөнгөнөөс үүссэн хөрөнгө, жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн нэрийн өмнөөс эсвэл зааврын дагуу үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, этгээдийн хөрөнгө;
 - б. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолуудын дагуу тусгай зөвшөөрөлтэй, тусгай эрх олгогдсон эсвэл өөр байдлаар мэдэгдсэнээс бусад нөхцөлд улс орнууд нь өөрсдийн харьяат эсвэл өөрсдийн хууль, тогтоомжид захирагдаж байгаа этгээдэд мөнгөн болон бусад хөрөнгө, эдийн засгийн эх үүсвэр, санхүүгийн болон бусад холбогдох үйлчилгээгээр жагсаалтад орсон хувь хүн, этгээд; жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хянаж байгаа хуулийн этгээд; жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн нэрийн өмнөөс эсвэл зааврын дагуу үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, этгээдийг шууд болон шууд бусаар, бүтнээр эсвэл хэсэгчлэн хангахыг хориглох шаардлагатай;
 - с. Улс орнууд нь жагсаалтад орсон этгээдийн талаар санхүүгийн салбар болон СББМҮҮ нарт цаг алдалгүйгээр мэдээлэх, дамжуулах сувагтай байх, зааварчилгаа өгөх тухайлбал хоригт орсон мөнгө болон бусад хөрөнгийг хадгалж байж болзошгүй санхүүгийн байгууллага, хувь хүмүүс болон этгээд (СББМҮҮ нарыг оролцуулаад)-д хөрөнгө царцаах арга хэмжээний дагуу хэрэгжүүлэх үүргийн талаар тодорхой зааварчилгаа өгөх шаардлагатай;

⁶ Европын холбооны хувьд үндэстэн дамнасан улс болох тул Зөвлөмж 6 дараах байдлаар хэрэгжинэ. Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн хөрөнгийг ЕХ-ны журам болон нэмэлт өөрчлөлтөөр зохицуулна. ЕХ-ны гишүүн улс орнууд ЕХ-ны хууль эрх зүйд захирагдаж байгаа хувь хүн хуулийн этгээдэд царцаах, мөнгөн болон бусад хөрөнгөөр жагсаалтад орсон хувь хүн, этгээд хангахыг хориглох талаар нэмэлт арга хэмжээ авна.

- d. Улс орнууд нь санхүүгийн байгууллага болон СББМҮҮ⁷ нарыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолын хоригийн шаардлагын дагуу авсан аливаа арга хэмжээ, гүйлгээ хийх оролдлого болон хөрөнгө царцаасан талаар эрх бүхий байгууллагад мэдээлэхийг, эрх бүхий байгууллагууд энэ мэдээллийг үр дүнтэй ашиглаж байхыг шаардана;
- e. Улс орнууд нь Зөвлөмж 6-г хэрэгжүүлэхдээ гэм зэмгүй гуравдагч этгээдийн эрх (bona fide)-ийг хамгаалах зохицуулалттай байх шаардлагатай.

Г. ЖАГСААЛТААС ГАРГАХ, ЦАРЦААСАН ХӨРӨНГИЙГ ЧӨЛӨӨЛӨХ, ЦАРЦААСАН ХӨРӨНГӨ БОЛОН БУСАД ХӨРӨНГИЙГ АШИГЛАХ ЭРХ ОЛГОХ

7. Улс орнууд нь хориг арга хэмжээний жагсаалтад байх болон шалгуур нөхцөл хангахгүй болсон тохиолдолд АЗ-ийн 1267(1999) тогтоол болон дагалдан гарсан тогтоолоор хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийг жагсаалтаас хасуулах талаар АЗ-д хүсэлт явуулах олон нийтэд ил журам хэрэгжүүлнэ. АЗ-ийн 1267 Хороо эсвэл 1988 Хорооны хувьд хувь хүн, этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтаас хассан тохиолдолд хөрөнгө царцаах үүрэг дуусна. Аль-Кайдатай холбоотой жагсаалтаас хасах хүсэлт нь 1267 Хорооноос Аюулгүйн Зөвлөлийн 1730 (2006), 1735 (2006), 1822 (2008), 1904 (1230), 1989 (2011) тогтоол болон дагалдан гарсан тогтоолын дагуу гаргасан журмыг мөрдсөн байх шаардлагатай. Талибан болон Афганистан Улсын энх тайван, аюулгүй байдал, тогтвортой байдалд заналхийлэхтэй холбоотой жагсаалтаас хасах хүсэлт нь 1988 Хорооноос Аюулгүйн Зөвлөлийн 1730 (2006), 1735 (2006), 1822 (2008), 1904 (2009), 1988 (2011) тогтоол болон дагалдан гарсан тогтоолын дагуу гаргасан журмын дагуу байх шаардлагатай.
8. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1373 (2001) тогтоолын дагуу хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, этгээдийг жагсаалтад орох шалгуур нөхцөл үгүй болсон тохиолдолд жагсаалтаас хасах болон царцаасан хөрөнгийг суллах эрх бүхий байгууллага, журам, аргачлалтай байх шаардлагатай. Жагсаалтад орсон хувь хүн, этгээд хүсэлт гаргасан тохиолдолд, шүүх болон бусад эрх бүхий бие даасан байгууллага жагсаалтад оруулах шийдвэрийг дахин судлах журамтай байх шаардлагатай.
9. Жагсаалтад орсон хувь хүн, этгээдтэй ижил, төстэй нэртэй хувь хүн, этгээдийн андуурагдан царцаагдсан мөнгө болон бусад хөрөнгийг тухайн хувь хүн, этгээд нь жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд биш гэдгийг шалгасны дараа хугацаа алдалгүй чөлөөлөх, олон нийтэд ил аргачлал хэрэгжүүлнэ.
10. Улс орнууд НҮБ-ын АЗ-ийн болон холбогдох хороодоос гаргасан жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн мөнгө болон бусад хөрөнгийг зайлшгүй хэрэгцээний зардал,

⁷ Аюулгүйн Зөвлөлийн тогтоол тухайн улсад байгаа бүх хувь хүн болон хуулийн этгээдэд хамаарна

тодорхой төрлийн хураамж, үйлчилгээний хөлс төлөх болон төлөвлөгдөөгүй онцгой зардалд зориулсан хөрөнгө гэж тодорхойлсон тохиолдолд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1452 (2002) тогтоол болон дагалдан гарсан тогтоолуудтай нийцүүлэн гаргасан журмын дагуу зарцуулах эрх олгох шаардлагатай. Үүнтэй ижил үндэслэлээр улс орнууд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1373 (2001) тогтоол болон 1963 (2010) тогтоолын дагуу үндэстэн, (үндэстэн дамнасан) хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдэд царцаасан хөрөнгийг ашиглах эрх олгох шаардлагатай.

11. Улс орнууд хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, этгээд нь шүүх болон бусад эрх бүхий байгууллагаар жагсаалтад оруулах шийдвэрийг давж заалдах боломжтой байх шаардлагатай. "Аль Каида"-гийн хориг арга хэмжээний жагсаалтын хувьд улс орнууд нь 1904 (2009) тогтоолын дагуу НҮБ-ын Омбудперсонд хандан жагсаалтаас хасах хүсэлт гаргах боломж байгааг тухайн жагсаалтад орсон хувь хүн, этгээдэд мэдэгдэх ёстой.
12. Улс орнууд нь жагсаалтаас хасагдсан этгээдийн талаар санхүүгийн салбар болон СББМҮҮ нарт цаг алдалгүйгээр мэдээлэх, дамжуулах сувагтай байх, зааварчилгаа өгөх тухайлбал хоригт орсон мөнгө болон бусад хөрөнгийг хадгалж байгаа санхүүгийн байгууллага, хувь хүмүүс болон этгээд (СББМҮҮ нарыг оролцуулаад)-д хоригийн жагсаалтаас гаргах болон хөрөнгө царцаах арга хэмжээг хүчингүй болсны дагуу хэрэгжүүлэх үүргийн талаар тодорхой зааварчилгаа өгөх шаардлагатай.

Д. НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТАД ОРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

13. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолд хоригт оруулах дараах шалгуур үзүүлэлтүүд тусгагдсан болно:

(а) Аюулгүйн Зөвлөлийн 1267 (1999), 1989 (2011) тогтоол болон дагалдан гарсан тогтоолд⁸:

- i. Аль-Каида, эсвэл салбар бүлэглэл, хамсаатан, салан тусгаарласан бүлэглэл эсвэл уламжлан⁹ гарсан бүлэглэлийг санхүүжүүлэх, төлөвлөх, туслалцаа үзүүлэх, бэлтгэх, хэрэгжүүлэхэд оролцсон; зэвсэг, түүнтэй холбоотой материалыг нийлүүлэх, худалдах, шилжүүлэх; эсвэл гишүүнээр элсүүлэх; эсвэл аливаа бусад үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн аливаа хувь хүн, этгээд; эсвэл

⁸ Зөвлөмж 6 нь Аюулгүйн Зөвлөлийн 1267 (1999) тогтоол болон дагалдан гарсан тогтоол, ирээдүйд гарах тогтоолд хамаатай. Энэ Тайлбарыг гаргах үед (2012 оны 2 дугаар сар) 1267 (1999) тогтоолын дагалдан гарсан тогтоолоор дараах тогтоолууд байв: 1333 (2000), 1367 (2001), 1390 (2002), 1455 (2003), 1526 (2004), 1617 (2005), 1735 (2006), 1822 (2008), 1904 (2009), 1988 (2011), and 1989 (2011).

⁹ ОР2 1617 (2005) тогтоолд Аль-Каида, Усама Бин Ладентай холбоотой этгээдийн тодорхойлолт байгаа

- ii. Энэ хэсгийн 13(a)(i)-д заасан хүн, этгээд, эсвэл тэдгээрийн нэрийн өмнөөс эсвэл тэдний удирдлаган дор үйл ажиллагаа явуулж буй этгээдийг шууд болон шууд бусаар эзэмшдэг, хяналт тавьдаг аливаа этгээд.

(б) Аюулгүйн Зөвлөлийн 1267 (1999), 1988 (2011) тогтоол болон дагалдан гарсан тогтоолд:

- i. Афганистаны энх тайван, тогтвортой байдал, аюулгүй байдалд заналхийлж байгаа Талибантай холбоотой хувь хүн, хуулийн этгээд, бүлэглэл, этгээд эсвэл тэдгээрт хамааралтай үйл ажиллагааг хамтран, тэдгээрийн нэрийн өмнөөс, эсвэл дэмжиж санхүүжүүлэх, төлөвлөх, туслалцаа үзүүлэх, бэлтгэх, хэрэгжүүлэхэд оролцсон; зэвсэг, түүнтэй холбоотой материалыг нийлүүлэх, худалдах, шилжүүлэх; эсвэл гишүүнээр элсүүлэх; эсвэл аливаа бусад үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн аливаа хувь хүн, этгээд; эсвэл
- ii. Энэ хэсгийн 13(б)(i)-д заасан хувь хүн, этгээд, эсвэл тэдгээрийн нэрийн өмнөөс эсвэл тэдний удирдлаган дор үйл ажиллагаа явуулж буй этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшдэг, хяналт тавьдаг аливаа этгээд.

(в) Аюулгүйн Зөвлөлийн 1373 (2001) тогтоолд:

- (i) террорист үйл ажиллагаа үйлдсэн эсвэл үйлдэхийг завдсан, эсвэл террорист үйл ажиллагаанд оролцсон эсвэл үүнд туслалцаа үзүүлсэн аливаа хүн, этгээд;
- (ii) энэ хэсгийн 13(в)(i)-д заасан хүн эсвэл этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хяналтад байгаа аливаа этгээд;
- (iii) энэ хэсгийн 13(в)(i)-д заасан хүн эсвэл этгээдийн нэрийн өмнөөс эсвэл түүний удирдлаган дор ажиллаж байгаа аливаа хүн, этгээд.

ЗӨВЛӨМЖ 7-ЫН ТАЙЛБАР

(ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ)

А. ЗОРИЛГО

1. Зөвлөмж 7 нь улс орнуудаас НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлж НҮБ-ын дүрмийн 7 дугаар бүлгийг үндэслэн Аюулгүйн Зөвлөлийн тогтоолоор үй олноор хөнөөх зэвсэх дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс¹⁰ сэргийлэх таслан зогсоохтой холбоотой хоригийн жагсаалтад орсон хувь хүн¹¹, этгээдийн мөнгө болон бусад хөрөнгийг хугацаа алдалгүй царцаах, мөнгө болон бусад хөрөнгөөр шууд буюу шууд бусаар хангахыг хориглох санхүүгийн¹² зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаардсан.
2. Зөвлөмж 7-д заасан үүрэг нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх¹³ тухай олон улсын гэрээ болон АЗ-ийн тогтоолоор хүлээсэн үүргийн дагуу эрүүгийн, иргэний, захиргааны үйл ажиллагааны явцад мөнгө болон бусад хөрөнгөтэй холбоотой авч байгаа арга хэмжээг орлох зорилгогүй. Зөвлөмж 7-ийн гол зорилго бол мөнгө болон бусад хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон хүлээн авагч нарыг мөнгө болон бусад хөрөнгөөр хангахыг таслан зогсоох шаардлагатай онцгой урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад чиглэсэн.

Б. ЖАГСААЛТАД ОРУУЛАХ

3. Аюулгүйн Зөвлөл нь холбогдох тогтоолын хавсралтаар эсвэл эдгээр тогтоолын дагуу байгуулагдсан Аюулгүйн Зөвлөлийн Хороо нь хориг арга хэмжээний

¹⁰ Зөвлөмж 7 нь Аюулгүйн Зөвлөлийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээний хүчин төгөлдөр тогтоол болон дагалдан гарсан тогтоол, ирээдүйд гарах тогтоолд хамаатай. Энэ Тайлбарыг гаргах үед үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээний хүчин төгөлдөр тогтоолууд нь дараах байв: 1718 (2006), 1874 (2009), 2087 (2013), 2094 (2013), 2270 (2016), 2321 (2016) and 2356 (2017). Иран улсын өргөн хэмжээний хамтарсан ажлын төлөвлөгөөг баталсан 2231 (2015) тогтоол үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээний 1737 (2006), 1747 (2007), 1803 (2008) and 1929 (2010) тогтоолуудыг хүчингүй болгосон гэхдээ санхүүгийн тодорхой хязгаарлалт тогтоосон. АЗ-өөс 2016 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр харилцан үүрэг хүлээснийг хүлээн зөвшөөрч хоригийг цуцалсан.

¹¹ Хувь хүн болон хуулийн этгээд

¹² Зөвлөмж 7 зорилтот санхүүгийн хориг арга хэмжээнд чиглэсэн. Эдгээр нь АЗ-ийн 2231 (2015) тогтоол (Хавсралт В 6 (с), (d) хэсгийг харна уу)-д хориг арга хэмжээг тусгасан. Гэхдээ холбогдох НҮБ-ын АЗ-ийн тогтоолууд нь илүү өргөн хүрээнд гарч өөр хориг тогтоодог (аялах эрхийг хязгаарлах), санхүүгийн бусад арга хэмжээ авахыг шаарддаг үйл ажиллагааг хориглох, төрлийг хязгаарлах, анхаарал хандуулахыг уриалах г.м). ФАТФ-аас НҮБ-ын АЗ-ийн тогтоолыг хэрэгжүүлэх, үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээ, санхүүгийн арга хэмжээтэй холбоотой заавал биелүүлэх шаардлагагүй зааварчилгаа гаргасан.

¹³ Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай Гэрээ, Биологийн болон токсины зэвсэг боловсруулах конвенци, Химийн зэвсгийн конвенци болон АЗ-ийн 1540 (2004), 2235 (2016) тогтоолуудыг шаардлагыг үндэслэсэн. Энэ шаардлагууд Зөвлөмж 7-ийн Тайлбар хэсгээс тусдаа шаардлага болно.

жагсаалтад оруулна. НҮБ-ын гишүүн орнууд нь Аюулгүйн Зөвлөлд эсвэл Аюулгүйн Зөвлөлийн холбогдох хороонд жагсаалтад оруулах талаар санал хүргүүлэх тодорхой үүрэг хүлээгээгүй болно. Гэсэн хэдий ч бодит байдал дээр Аюулгүйн Зөвлөл эсвэл холбогдох хороо нь гишүүн орнуудын жагсаалтад оруулах санал хүсэлтээс шууд хамааралтай байдаг. Аюулгүйн Зөвлөлийн 1718 (2006) тогтоолоор холбогдох хороо нь энэ тогтоол болон дагалдан гарсан тогтоолын тогтоосон арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай заавар, удирдамжийг гаргахыг заасан болно. Аюулгүйн Зөвлөлийн 2231 (2015) тогтоолоор тогтоосон арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаанд мөрдөж ажиллах арга хэмжээг тусгахыг заасан болно.

4. Улс орнууд Аюулгүйн Зөвлөлийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах холбогдох тогтоолын хориг арга хэмжээний дагуу хоригийн жагсаалтад хувь хүн, этгээдийг оруулах санал гаргах эрх бүхий байгууллага, үр дүнтэй журам, процедуртай байх ёстой. Үүнд дараах зүйлсийг харгалзан үзвэл зохино:

(а) дараах үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, гүйцэтгэх эрх үүрэг бүхий байгууллага эсвэл шүүхийн байгууллага(ууд)ыг томилно:

- (i) Эрх бүхий байгууллага нь хангалттай нотлох баримт, үндэслэл (Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолуудын Е хэсэгт заасан тусгай шалгуурыг үзнэ үү) байна гэж үзвэл 1718 (2006) тогтоол болон дагалдан гарсан тогтоолд¹⁴ заасан жагсаалтад оруулах тусгай шалгуурыг хангасан хувь хүн, этгээдийг шаардлагатай тохиолдолд хориг арга хэмжээний жагсаалтад оруулах тухай 1718 Хоригийн Хороонд санал хүргүүлэх;
- (ii) Эрх бүхий байгууллага нь хангалттай нотлох баримт, үндэслэл (Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолуудын Е хэсэгт заасан тусгай шалгуурыг үзнэ үү) байна гэж үзвэл 2231 (2015) тогтоол болон дагалдан гарсан тогтоолд заасан жагсаалтад оруулах тусгай шалгуурыг хангасан хувь хүн, этгээдийг шаардлагатай тохиолдолд хориг арга хэмжээний жагсаалтад оруулах тухай Аюулгүйн зөвлөлд санал хүргүүлэх.

(б) АЗ-ийн 1718 (2006) тогтоол, 2231 (2015) тогтоол болон дагалдан гарсан тогтоолуудад тусгасан хориг арга хэмжээний жагсаалтын шалгуур үзүүлэлтэд үндэслэн жагсаалтад оруулах этгээдийг тодорхойлох механизм(ууд)тай байх ёстой (Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолуудын Е хэсэгт заасан тусгай шалгуурыг

¹⁴ Зөвлөмж 7 нь Аюулгүйн Зөвлөлийн 1718 (2006) тогтоол болон дагалдан гарсан тогтоол, ирээдүйд гарах тогтоолд хамаатай. Энэ Тайлбарыг гаргах үед (2017 оны 6 дугаар сар) 1718 (2006) тогтоолын дагалдан гарсан тогтоолоор дараах тогтоолууд байв: 1874 (2009), 2087 (2013), 2094 (2013), 2270 (2016), 2321 (2016), 2356 (2017).

үзнэ үү). Ийм журам нь холбогдох үндэстэн дамнасан зарчмын дагуу жагсаалтад оруулах үндэслэл эсвэл хангалттай үндэслэл байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай.

(в) Эрх бүхий байгууллага нь хувь хүн, этгээдийг жагсаалтад оруулахаар тодорхойлохын тулд Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолуудын хориг арга хэмжээний жагсаалтад оруулах шаардлага хангасан гэж үзэх үндэслэлтэй, хангалттай үндэслэлтэй гэж тодорхойлохын тулд аль болох их мэдээлэл цуглуулах, гаргуулж авах хуулиар олгогдсон эрх, холбогдох журам, заавар, механизмтай байна;

(г) Хориг арга хэмжээний жагсаалтад оруулах санал гаргах эсэхийг тогтооходоо энэ тайлбар хэсгийн Е хэсэгт заасан тусгай шалгууруудыг харгалзах. Эрх бүхий байгууллага нь жагсаалтад оруулах санал гаргах явцад нь хүний эрх дээдлэх, хууль дээдлэх зарчмыг хүндэтгэн гэм зэмгүй гуравдагч этгээдийн эрхийг хүлээн зөвшөөрч өөрийн улсын хууль эрх зүйн стандартыг мөрдөнө.

(д) 1718 (2006) Хоригийн Хороонд 1718 (2006) тогтоол болон дагалдан гарсан тогтоол мөн Аюулгүйн Зөвлөлд 2231 (2015) тогтоол) тогтоол болон дагалдан гарсан тогтоолын дагуу нэр санал болгоходоо улс орнууд дараах мэдээллээр аль болох бүрэн дүүрэн хангах ёстой:

- i. жагсаалтад оруулахаар санал болгож буй этгээдийн нэр, тухайн хувь хүн, этгээдийг зөв, баталгаатай таньж мэдэхэд хангалттай мэдээлэл;
- ii. тухайн хувь хүн, этгээдийг жагсаалтад оруулах шаардлага хангасан гэдгийг нотлох тодорхой мэдээлэл (энэ тайлбарын Е хэсэгт заасан Аюулгүйн зөвлөлийн тусгай шалгууруудыг харгалзах үзэх);

(е) хориг арга хэмжээний жагсаалтад оруулахаар судлагдаж байгаа болон тодорхойлогдсон хувь хүн, этгээд талаар бие даасан хараат бусаар (ex parte) шийдвэр гаргах журамтай байна.

з. Улс орнууд нь хориг арга хэмжээний жагсаалтад оруулахаар судлагдаж байгаа болон тодорхойлогдсон хувь хүн, этгээд талаар бие даан хараат бусаар (ex parte) шийдвэр гаргах журамтай байна.

С. ЖАГСААЛТАД ОРСОН ХҮН БОЛОН ЭТГЭЭДИЙН МӨНГӨ БОЛОН БУСАД ХӨРӨНГИЙГ ЦАРЦААХ, ХОРИГЛОХ

5. Улс орнууд нь НҮБ-ын Дүрмийн 7 дугаар бүлгийн бүрэн эрхийн дагуу дараах хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн болон этгээдийн эсрэг зорилтот санхүүгийн хориг арга хэмжээнүүдийг хугацаа алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай:

(a) 1718 (2006) тогтоол болон дагалдан гарсан тогтоолын хувьд Аюулгүйн

Зөвлөлийн тогтоолын хавсралтаар болон Аюулгүйн Зөвлөлийн¹⁵ 1718 Хоригийн Хорооноос жагсаалтад оруулсан;

(б) Аюулгүйн Зөвлөлийн 2231 (2015) тогтоол болон дагалдан гарсан тогтоолуудын дагуу.

б. Дараах стандарт, журмын дагуу улс орнууд зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй, эрх бүхий байгууллагыг хуулийн хүрээнд байгуулж тодорхойлно. Үүнд:

- a. Улс орнууд¹⁶ нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн болон этгээдийн мөнгө болон бусад хөрөнгийг хугацаа алдалгүй, урьдчилан мэдэгдэлгүйгээр царцаахыг өөрийн улсын бүх хувь хүн, хуулийн этгээдээс шаардана. Энэ хөрөнгө царцаах үүрэг нь жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн эзэмшиж буй болон хяналтад байгаа бүх мөнгөн болон бусад хөрөнгө; эдгээр нь зөвхөн тодорхой нэгэн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх үйлдэл, завдал болон аюул заналхийлэлтэй холбоотой хөрөнгөөр хязгаарлагдахгүй; жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн бүтнээр нь буюу тодорхой хувийг шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хяналтад байгаа хөрөнгө; жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хяналтад байгаа хөрөнгөнөөс үүссэн хөрөнгө, жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн нэрийн өмнөөс эсвэл зааврын дагуу үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, этгээдийн хөрөнгө;
- b. Аюулгүйн Зөвлөлийн тогтоолуудын дагуу (Е хэсгийг харна уу) тусгай зөвшөөрөлтэй, тусгай эрх олгогдсон эсвэл өөр байдлаар мэдэгдсэнээс бусад нөхцөлд улс орнууд нь өөрсдийн харьяат эсвэл өөрсдийн хууль эрх зүйд захирагдаж байгаа этгээдэд жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн мөнгөн болон бусад хөрөнгөөр хангахыг хориглох шаардлагатай;
- c. Улс орнууд нь жагсаалтад орсон этгээдийн талаар санхүүгийн салбар болон СББМҮҮ нарт цаг алдалгүйгээр мэдээлэх, дамжуулах сувагтай байх, зааварчилгаа өгөх тухайлбал хоригт орсон мөнгө болон бусад хөрөнгийг хадгалж байж болзошгүй санхүүгийн байгууллага, хувь хүмүүс болон этгээд (СББМҮҮ нарыг оролцуулаад)-д хөрөнгө царцаах арга

¹⁵ 2270 (2016) тогтоолд тусгасны дагуу энэ нь улс орнууд БНАСАУ-ын Засгийн газар, Хөдөлмөрчдийн намд хамааралтай БНАСАУ-ын цөмийн болон балистик пуужингийн хөтөлбөр, үйл ажиллагааг хориглосон 1718 (2006) тогтоол болон дагалдан гарсан тогтоолоор хамааралтай гэж үзсэн этгээдүүд орно.

¹⁶ Европын холбооны хувьд үндэстэн дамнасан улс болох тул Зөвлөмж 7 дараах байдлаар хэрэгжинэ. Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн хөрөнгийг ЕХ-ны нэгдсэн аюулгүй байдал гадаад бодлогын хүрээнд Европын Зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу зохицуулна. ЕХ-ны гишүүн улс орнууд ЕХ-ны хууль эрх зүйд захирагдаж байгаа хувь хүн хуулийн этгээдэд царцаах, мөнгөн болон бусад хөрөнгөөр жагсаалтад орсон хувь хүн, этгээд хангахыг хориглох талаар нэмэлт арга хэмжээ авна.

хэмжээний дагуу хэрэгжүүлэх үүргийн талаар тодорхой зааварчилгаа өгөх шаардлагатай;

- d. Улс орнууд нь санхүүгийн байгууллага болон СББМҮҮ¹⁷ нарыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолын дагуу хоригийн шаардлагын дагуу авсан аливаа арга хэмжээ, гүйлгээ хийх оролдлого болон хөрөнгө царцаасан талаар эрх бүхий байгууллагад мэдээлэхийг, эрх бүхий байгууллагууд энэ мэдээллийг үр дүнтэй ашиглаж байхыг шаардана;
- e. Улс орнууд нь Зөвлөмж 7-г хэрэгжүүлэхдээ гэм зэмгүй гуравдагч этгээдийн эрх (bona fide)-ийг хамгаалах зохицуулалттай байх шаардлагатай.
- f. Улс орнууд нь Зөвлөмж 7-д тусгасан үүргээ санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар хэрхэн биелүүлж байгааг хянах, хэрэгжилтийг хангуулах холбогдох хууль болон бусад арга хэрэгсэлтэй байх шаардлагатай. Хууль журмын дагуу хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа тохолдолд иргэний, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байх шаардлагатай.

D. ЖАГСААЛТААС ГАРГАХ, ЦАРЦААСАН МӨНГӨ БОЛОН БУСАД ХӨРӨНГИЙГ ЧӨЛӨӨЛӨХ

7. Улс орнууд нь хориг арга хэмжээний жагсаалтад байх болон шалгуур нөхцөл хангахгүй болсон тохиолдолд АЗ-ийн тогтоолоор хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийг жагсаалтаас хасуулах талаар АЗ-д хүсэлт явуулах олон нийтэд ил тод журам хэрэгжүүлнэ. АЗ эсвэл Хорооны хувьд хувь хүн, этгээдийг хориг арга хэмжээний жагсаалтаас хассан тохиолдолд хөрөнгө царцаах үүрэг дуусна. Аюулгүйн Зөвлөлийн 1718 (2006) болон дагалдан гарсан тогтоолын хувьд жагсаалтаас гаргах журам, нөхцөл нь Аюулгүйн Зөвлөлийн 1730 (2006) тогтоол болон дагалдан гарсан тогтоолын дагуу гаргасан журмыг мөрдсөн байх шаардлагатай бөгөөд энэ журмын дагуу байгуулагдсан Хариуцах хэсэг /Focal Point mechanism/ мөн хамаарна. Жагсаалтад орсон хувь хүн, этгээд нь хүсэлт гаргасан тохиолдолд 1730 (2006) тогтоолын дагуу байгуулагдсан Хариуцах хэсэг /Focal Point/-т жагсаалтаас хасуулах хүсэлт гаргах эсвэл жагсаалтад оруулах шийдвэрийг Хариуцах хэсэг /Focal Point/-т шууд хандах талаар улс орнууд хоригт орсон хувь хүн, этгээдэд мэдээлэл өгөх хэрэгтэй.

8. Жагсаалтад орсон хувь хүн, этгээдтэй ижил, төстэй нэртэй хувь хүн, этгээдийн андуурагдан царцаагдсан мөнгө болон бусад хөрөнгийг тухайн хувь хүн, этгээд нь жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд биш гэдгийг шалгасны дараа хугацаа алдалгүй чөлөөлөх, олон нийтэд ил тод аргачлал хэрэгжүүлнэ.

¹⁷ АЗ-ийн тогтоол тухайн улсад байгаа бүх хүн, хуулийн этгээдэд хамаатай

9. Улс орнууд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1718 (2006) тогтоол болон 2231 (2015) тогтоолын нөхцөлийг хангасан тохиолдолд мөнгө болон бусад хөрөнгийг журмын дагуу зарцуулах эрх олгох шаардлагатай.

10. Улс орнууд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1718 (2006) эсвэл 1737 (2015) тогтоолын дагуу битүүмжилсэн дансанд хүү, бусад орлого болон хориг арга хэмжээ авах тогтоол гарахаас өмнө хийгдсэн гэрээ, хэлэлцээр, хүлээсэн үүргийн дагуу орлого орохыг зөвшөөрөх шаардлагатай бөгөөд эдгээр хүү, орлого болон төлбөр нь мөн тухайн дансны бусад хөрөнгөтэй адил нөхцөлтэй, царцаагдсан байх шаардлагатай.

11. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1737 (2006), 2231 (2015) тогтоолоор үргэлжлүүлсэн болон 2231 (2015) тогтоолын дагуу царцаасан данснаас санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах тогтоол гарахаас өмнө хийгдсэн гэрээ, хэлэлцээр, хүлээсэн үүргийн дагуу хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдэд дараах нөхцлүүд биелсэн тохиолдолд төлбөр хийхэд саад болохгүй:

- a. гэрээ, хэлэлцээр нь Аюулгүйн Зөвлөлийн 2231(2015) тогтоол болон дагалдан гарсан тогтоолд заасан хориглосон зүйлс, материал, тоног төхөөрөмж, бараа, технологи, туслалцаа, сургалт, санхүүгийн дэмжлэг, хөрөнгө оруулалт, брокерийн үйл ажиллагаа болон үйлчилгээтэй холбоогүй гэдгийг холбогдох улс орнууд нь тогтоосон;
- b. төлбөрийг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 2231(2015) тогтоолын хавсралт хэсгийн 6 дугаар хэсэгт тусгасан жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд шууд болон шууд бусаар хүлээн аваагүй гэдгийг холбогдох улс орнууд нь тогтоосон;
- c. холбогдох улс орнууд нь Аюулгүйн Зөвлөлд эдгээр төлбөрүүдийг хийх, хүлээн авах, эсвэл хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, санхүүгийн хөрөнгө чөлөөлөх зөвшөөрөл олгох талаар зөвшөөрөл¹⁸ олгохоос 10 ажлын өдрийн өмнө урьдчилан мэдэгдэл өгсөн.

12. Улс орнууд нь жагсаалтаас гаргах, царцаах арга хэмжээ хүчингүй болсон талаар санхүүгийн салбар болон СББМҮҮ нарт цаг алдалгүйгээр мэдээлэх, дамжуулах сувагтай байх, зааварчилгаа өгөх тухайлбал хоригт орсон мөнгө болон бусад хөрөнгийг хадгалж байгаа санхүүгийн байгууллага, хувь хүмүүс болон этгээд (СББМҮҮ нарыг оролцуулаад)-д хоригийн жагсаалтаас гаргах болон хөрөнгө царцаах арга хэмжээг хүчингүй болсны дагуу хэрэгжүүлэх үүргийн талаар тодорхой зааварчилгаа өгөх шаардлагатай.

¹⁸ Жагсаалтад орсон этгээд нь санхүүгийн байгууллага бол ФАТФ-аас гаргасан аргачлалыг мөрдөнө. НҮБ-ын АЗ-өөс Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх нь 2013 оны 6 дугаар сар.

Е. НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТАД ОРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

13. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолд хоригт оруулах дараах шалгуур үзүүлэлтүүд тусгагдсан болно:

(а) БНАСАУ-д Аюулгүйн Зөвлөлийн 1718 (2006), 2087 (2013), 2094 (2013) болон 2270 (2016) тогтоолоор :

- (i). Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын (БНАСАУ)-ын цөмийн, бусад үй олноор хөнөөх зэвсэг болон баллистик пуужингийн хөтөлбөрт оролцсон аливаа хүн, этгээд;
- (ii). БНАСАУ-ын цөмийн, бусад үй олноор хөнөөх зэвсэг болон баллистик пуужингийн хөтөлбөрт дэмжлэг үзүүлдэг (хууль бусаар дэмжих орно) аливаа хүн, этгээд;
- (iii). 13(a)(i) болон 13(a)(ii)¹⁹ дэд хэсэгт заасан аливаа хүн, этгээдийн нэрийн өмнөөс эсвэл удирдлагаар үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хүн, хуулийн этгээд;
- (iv). 13(a)(i) болон 13(a)(ii)²⁰ дэд хэсэгт заасан аливаа хүн, этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшдэг, хянадаг аливаа хүн, этгээд;
- (v). АЗ-ийн 1718 (2006), 1874 (2009) тогтоолуудын заалтыг зөрчсөн, хориг арга хэмжээнээс зайлсхийхэд туслалцаа үзүүлсэн аливаа хүн, этгээд;
- (vi). БНАСАУ-д хориглосон хөтөлбөр, БНАСАУ-тай холбоотой тогтоолоор хориглосон үйл ажиллагаанд эсвэл эдгээр заалтаас зайлсхийхэд туслалцаа үзүүлсэн аливаа хүн, этгээд;
- (vii). Улс орнууд 1718 (2006) тогтоол болон дагалдан гарсан тогтоолоор хориглосон БНАСАУ-ын цөмийн эсвэл баллистик пуужинтай холбоотой хөтөлбөр эсвэл бусад хориглосон үйл ажиллагаатай холбоотой БНАСАУ-ын Засгийн газар, БНАСАУ-ын Хөдөлмөрийн намын этгээд, тэдгээрийн нэрийн өмнөөс эсвэл удирдлагаар үйл ажиллагаа явуулж эсвэл тэдгээрийн шууд болон шууд бусаар эзэмшдэг, хянадаг аливаа хүн, этгээд;

(б) Иранд Аюулгүйн Зөвлөлийн 2231 (2015) тогтоолоор:

¹⁹ Эдгээр этгээдийн мөнгө болон бусад хөрөнгийг Хорооноос тусгайлан нэр зааж хориг тавьсан эсэхээс үл хамааран хэрэгжүүлнэ. АЗ-ийн 2270 (2016) тогтоолын Хавсралт 3 нь 1718 (2006) тогтоолын санхүүгийн хориг арга хэмжээг Далайн тээврийн удирдлагын компанийг хамруулахаар өргөжүүлсэн.

²⁰

- (i). Иран Улсын өргөн хэмжээний хамтрасан ажлын төлөвлөгөө (ӨХХАТ)-өөр хүлээсэн үүрэгт харшлах, 2232 (2015) тогтоолын Хавсралт Б-д заасан үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа эсвэл хориглосон зүйл, бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, техник технологи нийлүүлэх замаар цөмийн зэвсэг хүргэх системийг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцсон, шууд холбоотой эсвэл туслалцаа үзүүлдэг аливаа хувь хүн, хуулийн этгээд;
- (ii). хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдэд хоригоос зайлсхийх, ӨХХАТ-нд харшлах эсвэл 2231 (2015) тогтоолын эсрэг үйл ажиллагаа явуулахад нь туслалцаа үзүүлсэн аливаа хувь хүн, этгээд;
- (iii). 13(b)(i) дэд хэсэг, 13 (b)(ii) дэд хэсэг болон 13(b)(iii) дэд хэсэгт заасан аливаа хүн, этгээдийн нэрийн өмнөөс эсвэл удирдлагаар үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хүн, хуулийн этгээд тэдгээрийн эзэмшдэг эсвэл удирддаг аливаа этгээд.

ЗӨВЛӨМЖ 8-ЫН ТАЙЛБАР

(АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГА)

- 1) Улс орнуудын олон төрлийн хууль эрх зүйн хэлбэрийг харгалзан ашгийн бус байгууллага (АББ)-ыг ФАТФ-аас үйл ажиллагааны хэлбэрээр нь тодорхойлолтыг батлав. Энэ тодорхойлолт нь энгийн ашгийн бус үйл ажиллагаа явуулж байгаа үндэслэлээр бус харин терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй байгууллагын үйл ажиллагаа, шинж чанарт үндэслэсэн болно. Энэ зөвлөмжийн зорилгын үүднээс АББ нь буяны, шашны, соёлын, боловсролын, нийгмийн, нийгэмлэгийн зорилгоор эсвэл бусад төрлийн “сайн үйлс” -ийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор хөрөнгө босгох, зарцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, гэрээ хэлцэл болон байгууллагыг хэлнэ. Зөвлөмж 1-тэй зөрчилдөхгүйгээр энэ зөвлөмж нь зөвхөн ФАТФ-ын тодорхойлолтод багтдаг АББ-д хамаарна. Энэ тодорхойлолт нь бүх АББ-д хамаарахгүй.
- 2) АББ нь дэлхийн эдийн засаг болон улс орны эдийн засаг, нийгмийн тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний хүчин чармайлтын хүчинд дэлхийн хэмжээнд хэрэгцээтэй хүмүүст засгийн газар болон бизнесийн салбарын үйл ажиллагааг нөхөж үндсэн үйлчилгээ, тав тух, итгэл найдвараар хангах үйл ажиллагаа явуулдаг. ФАТФ нь эдгээр чухал буяны үйлчилгээг үзүүлэхэд АББ-ын амин чухал ач холбогдол, өндөр эрсдэлтэй бүс, зөрчилдөөний бүсэд байгаа хүмүүст тусламж үзүүлэхэд бэрхшээлтэй байдгийг хүлээн зөвшөөрч, ийм хэрэгцээг хангах чиглэлээр ажилладаг байгууллагуудын хүчин чармайлтыг өндрөөр үнэлдэг. Түүнчлэн ФАТФ нь үйл ажиллагааныхаа ил тод байдлыг дэмжих, радикалчлал, хүч хэргэлсэн экстремизмыг таслан зогсооход чиглэсэн хөтөлбөр боловсруулахад зэрэг терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх АББ-уудын зорилт, хүчин чармайлтыг үнэлж байгаа. Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын компани ажил нь террористууд ба террорист байгууллагууд хөрөнгө босгох, шилжүүлэх, логистикийн дэмжлэг үзүүлэх, террористуудыг элсүүлэхийг дэмжих эсвэл өөр аргаар террорист байгууллага, үйл ажиллагааг дэмжих зорилгоор энэ салбарын зарим АББ-ыг ашигладаг тохиолдлуудыг илрүүлсэн. Түүнчлэн террористууд луйврын буяны үйл ажиллагаа эрхэлдэг эсвэл эдгээр зорилгоор хуурамч хөрөнгө цуглуулсан тохиолдол ч гарч байсан. Энэ зүй бус хэрэглээ нь террорист үйл ажиллагааг идэвхжүүлээд зогсохгүй хандивлагчдын итгэлийг алдагдуулж, АББ-ын үнэнч шударга байдалд аюул учруулж байна. Иймээс АББ-ыг терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт буруугаар ашиглагдахаас хамгаалах нь дэлхийн терроризмтой тэмцэх чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд АББ-ууд болон хандивлагчдын шударга байдлыг хадгалахад зайлшгүй шаардлагатай алхам юм. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт урвуулан ашиглагдаж болзошгүй эрсдэлээс хамгаалах арга хэмжээг зорилтот түвшинд, эрсдэлд суурилсан арга барилд нийцүүлэх ёстой. НҮБ-ын дүрэм, хүний эрхийн олон улсын хууль тогтоомжийн

дагуу улс орнуудын хүлээсэн үүргийг хүндэтгэх үүднээс ийм арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал юм.

- 3) Зарим АББ нь янз бүрийн шалтгааны улмаас террорист этгээд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт урвуулан ашиглагдах эрсдэлтэй байдаг. АББ нь олон нийтийн итгэлийг хүлээсэн, их хэмжээний мөнгөний эх үүсвэр ашиглах зэрэг давуу талуудтай бөгөөд бэлэн мөнгөтэй байнга харьцдаг байгууллага юм. Цаашилбал, зарим АББ нь террорист үйл ажиллагаанд хамгийн их өртдөг бүс нутагт эсвэл ойр орчимд олон улсын болон үндэсний үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээ хийх боломжийг олгодог байна. Зарим тохиолдолд террорист байгууллагууд эдгээр болон бусад шинж чанаруудыг ашиглан зарим АББ-уудад нэвтэрч, террорист үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжих зорилгоор хөрөнгө, үйл ажиллагааг нь урвуулан ашигладаг.

Б. ЗОРИЛГО БОЛОН ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

4. Зөвлөмж 8-ын зорилго бол террорист байгууллага нь АББ-ыг дараах байдлаар хууль бус үйл ажиллагаанд урвуулан ашиглахаас сэргийлэхэд чиглэгдсэн: (i) хууль ёсны байгууллагын нэрийг ашиглах; (ii) хууль ёсны этгээдийг терроризмыг санхүүжүүлэхэд ашиглах (үүнд хөрөнгө царцаахаас зайлсхийх явдал мөн хамаарна); (iii) хуулийн дагуу зарцуулагдах хөрөнгө мөнгийг нуун далдалж, зориулалтыг нь өөрчлөх замаар террорист бүлэглэлд ашиглах. Энэ Тайлбар хэсэгт дээр дурдсан зорилгыг биелүүлэхийн тулд дараах ерөнхий зарчмууд дээр үндэслэсэн болно:

- (a) Үндэсний салбар болгоны өвөрмөц шинж чанар, терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглагдах байдал, салбар хооронд өөр байх, хууль ёсны буяны үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх хэрэгцээ, улс орон бүрт терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хязгаарлагдмал нөөц, бололцоо байгааг харгалзан АББ-ын терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт урвуулан ашиглагдах илэрсэн аюул заналхийлэлд тохирсон эрсдэлд суурилсан тодорхой арга хэмжээ авах нь чухал юм.
- (b) терроризмыг санхүүжүүлэх аюул заналхийлэл байнга хувьсан өөрчлөгдөж байдаг тул АББ-ыг терроризмын санхүүжүүлэхэд өртөхөөс сэргийлэх үндэсний арга хэмжээг боловсруулахад уян хатан байх шаардлагатай.
- (c) Өнгөрсөн болон одоогийн АББ-ыг терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашигласан байдал нь улс орнуудыг эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлж тодорхойлсон эрсдэлтэй уялдуулан үр дүнтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц арга хэмжээ авахыг шаарддаг.
- (d) АББ-ыг терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглагдахаас хамгаалах зорилгоор улс орнуудын авч хэрэгжүүлж байгаа чиглэсэн арга хэмжээ нь

хууль ёсны буяны үйл ажиллагаанд саад болохгүй, тасалдуулахгүй байх ёстой. Үүний оронд энэ арга хэмжээ нь хариуцлагатай бүртгэлтэй байх, АББ, хандивлагчдын нийгэмлэг, олон нийтийн дунд буяны сангууд болон буяны үйлчилгээ эрхлэгчид хууль ёсны зорилтот бүлэгтээ хүрдэг гэдэг итгэлийг бий болгох ёстой. АББ-ын удирдлага, үйл ажиллагаанд өндөр хариуцлага, шударга байдал, олон нийтийн итгэлийг олж авах үйл ажиллагааг дэмждэг систем нь терроризмыг санхүүжүүлэхэд АББ-ыг урвуулан ашиглагдахгүй байхад нэн чухал юм.

- (e) Улс орнууд тухайн хэргийн онцлогийг харгалзан терроризм эсвэл террорист байгууллагад урвуулан ашиглагдаж байгаа эсвэл тэдгээрийг санаатайгаар дэмжиж байгаа АББ-уудын эсрэг үр дүнтэй, дүйцэхүйц арга хэмжээ авах шаардлагатай байна. Улс орнууд терроризмыг санхүүжүүлэх болон терроризмыг дэмжих бусад хэлбэрээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгаж яллахыг зорих ёстой. АББ нь терроризмыг санхүүжүүлэх эсвэл терроризмыг дэмжих бусад хэлбэрийн гэмт хэрэгт сэжиглэгдсэн эсвэл хамааралтай болохыг тогтоосон тохиолдолд улс орнуудын нэн тэргүүний зорилт нь терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, таслан зогсоох явдал юм. Энэ зорилгоор авсан арга хэмжээг гэм буруугүй, АББ-ын хууль ёсны ашиг хүртэгчдэд аль болох бага сөрөг нөлөө үзүүлэхээр хэрэгжүүлэх ёстой. Гэсэн хэдий ч энэ ашиг сонирхол нь АББ-ын терроризмыг санхүүжүүлэх эсвэл терроризмын бусад хэлбэрийн дэмжлэгийг зогсоох яаралтай үр дүнтэй арга хэмжээ авахад саад болох ёсгүй.
- (f) Төр, хувийн хэвшлийн болон АББ-уудын хооронд хамтын ажиллагааны харилцаа холбоог хөгжүүлэх нь АББ-ын эрсдэлийг ойлгох, эрсдэлийг бууруулах стратеги, мэдлэгийг дээшлүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, АББ-уудын терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Улс орнууд терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд эрдэм шинжилгээний судалгааг хөгжүүлэх, АББ-уудад мэдээлэл солилцохыг дэмжиж ажиллах ёстой.

В. АРГА ХЭМЖЭЭ

5. АББ нь бүгд өндөр уламжлалт эрсдэлгүй (зарим АББ нь маш бага хэмжээний эсвэл ямар ч эрсдэлгүй) байдаг тул улс орнууд нь Зөвлөмж 1-тэй зөрчилдөхгүй байхаар ФАТФ-ын АББ-уудын тодорхойлолтод ямар байгууллагууд хамаарахыг тодорхойлох хэрэгтэй. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ улс орнууд нь терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд хамгийн ихээр урвуулан ашиглагдах магадлалтай АББ-ын шинж чанар, төрлийг тогтоохын тулд тэдгээрийн үйл ажиллагаа, төрөл, хэмжээ болон бусад

шаардлагатай шинж чанарын талаарх мэдээллийг²¹ бүх боломжит эх сурвалжаас ашиглах шаардлагатай. АББ-уудад заналхийлж байгаа террорист байгууллагуудын аюул заналхийлэлийн шинж чанар болон АББ-ууд хэрхэн урвуулан ашиглагдаж байгааг тодорхойлох нь мөн чухал юм. Улс орнууд нь АББ-ууд терроризмыг санхүүжүүлэхэд хэрхэн урвуулан ашигладахаас сэргийлсэн арга хэмжээ, хууль, журам зэргийн зохистой байдлыг үнэлж тодорхойлогдсон эрсдэлд суурилсан үр дүнтэй, дүйцэхүйц арга хэмжээ авах шаардлагатай. Эдгээр арга хэмжээ нь янз бүрийн хэлбэртэй байж болох бөгөөд заавал бичгээр үйлдсэн байх шаардлагагүй. Улс орнууд нь үр дүнтэй арга хэмжээний хэрэгжүүлэхийн тулд шинэ мэдээ, мэдээллийн үндсэн дээр салбарын террорист үйл ажиллагаанд өртөх эрсдэлийн үнэлгээг тогтмол шинэчилж байх нь чухал юм.

6. Терроризмыг санхүүжүүлэхэд АББ-ыг буруугаар ашиглах явдлыг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд олон янзын арга зам байдаг. Үр дүнтэй аргачлалд дараах 4 хүчин зүйлс орсон байх шаардлагатай: (а) олон нийтийг байнга соён гэгээрүүлэх, (б) эрсдэлд суурилсан зорилтот хяналт шалгалт (в) үр дүнтэй мөрдөн байцаах болон мэдээлэл цуглуулах, (г) үр дүнтэй олон улсын хамтын ажиллагааны тогтолцоо. Улс орнууд АББ-ыг терроризмыг санхүүжүүлэхэд буруугаар ашиглагдахаас хамгаалахын тулд дээрх хүчин зүйлсийг харгалзан үзсэн дараах тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж болно:

- (а) Олон нийтийг терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой асуудлаар байнга соён гэгээрүүлэх
 - (i). Улс орнууд нь АББ-ын удирдлага, менежмент нь хариуцлагатай, бүртгэлтэй байх, шударга байхыг дэмжиж, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх тодорхой бодлоготой байх шаардлагатай.
 - (ii). Улс орнууд АББ болон хандивлагчдын нийгэмлэгийн АББ-ын терроризмыг санхүүжүүлэхэд өртөх аюул, заналхийлэл болон АББ-ын энэ аюулаас сэргийлэх талаар авах арга хэмжээний мэдлэгийг дээшлүүлэх, гүнзгийрүүлэх, боловсролын хөтөлбөрийг дэмжиж, хэрэгжүүлэх ёстой.
 - (iii). Улс орнууд терроризмыг санхүүжүүлэх эрсдэл, аюул заналхийлэлийг арилгах шилдэг туршлагыг боловсруулж боловсронгуй болгох, улмаар терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглагдахаас хамгаалахын тулд АББ-уудтай хамтран ажиллах ёстой.
 - (iv). Улс орнууд аливаа бүс нутаг, улс орны санхүүгийн салбарын чадавхи, буяны болон хүмүүнлэгийн асуудлын хойшлуулашгүй байдал зэргийг

²¹ Жишээ нь, энэ төрлийн мэдээллийг татварын байгууллага, СМА, донор байгууллага, хууль сахиулах болон тагнуулын байгууллагаас авч болно.

харгалзан, АББ-ыг зохицуулалттай санхүүгийн салбараар гүйлгээ хийхийг дэмжих хэрэгтэй.

(b) АББ-ын эрсдэлд суурилсан зорилтот хяналт шалгалт

Улс орнууд үр дүнтэй хяналт, шалгалтыг дэмжих алхамуудыг хийх хэрэгтэй. ФАТФ-ын стандартын Зөвлөмж 1-т заасны дагуу эрсдэлд суурилсан хандлагыг "нэг арга хэмжээ бүгдэд таарна" хэлбэрээр хэрэгжүүлэх нь нийцэхгүй. Улс орнууд терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглагдах эрсдэлтэй АББ-уудад бодит байдал дээр эрсдэлд суурилсан арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлж байгааг харуулах ёстой. Одоо байгаа зохицуулалт болон бусад арга хэмжээ нь тухайн улсад АББ-уудын терроризмыг санхүүжүүлэхэд өртөх эрсдэлийг хангалттай хэмжээнд зохицуулж байх боломжтой боловч АББ-ын салбарын терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тогтмол үнэлж, шалгаж байх ёстой. Холбогдох эрх бүхий байгууллагууд энэ зөвлөмжийн шаардлагыг дагаж мөрдөх, үүнд тавих эрсдэлд суурилсан арга хэмжээнүүдийг АББ²² хэрхэн хэрэгжүүлж байгааг хянах шаардлагатай. Холбогдох эрх бүхий байгууллага нь АББ, түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж буй хүнд гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн хариуцлагын арга хэмжээ²³ авах хэрэгтэй. Эрсдэлээс нь хамааран бүрэн эсвэл хэсэгчилсэн байдлаар АББ-д хэрэгжүүлэх зарим арга хэмжээний жишээг доор харуулав:

- (i). АББ нь тусгай зөвшөөрөлтэй эсвэл бүртгэлтэй байх шаардлагатай. Энэ мэдээллийг эрх бүхий байгууллагад нээлттэй байх хэрэгтэй бөгөөд олон нийтэд нээлттэй байлгахыг уриалж байна²⁴.
- (ii). АББ-аас (i) өөрсдийн үйл ажиллагааны зорилго, зорилт, (ii) удирдах ажилтан, удирдах зөвлөлийн гишүүд гэх мэт өмчилж, хянаж үйл ажиллагааг нь чиглүүлж буй хувь хүмүүсийн талаарх мэдээллийг хадгалж байхыг шаардана. Энэ мэдээллийг АББ-аас өөрөөс эсвэл бусад холбогдох эрх бүхий байгууллагаас авах боломжтой байх шаардлагатай;
- (iii). Орлого, зарлагыг дэлгэрэнгүй байдлаар харуулах жилийн санхүүгийн тайлан гаргаж байхыг АББ-уудаас шаардаж болно.

²² Энэ тохиолдолд журам зохицуулалт нь Өөрийгөө зохицуулах байгууллагын гаргасан журам, стандартад орно

²³ Хариуцлагын арга хэмжээнд данс царцаах, траст төлөөлөгчийг болиулах, торгох, сертификатыг хүчингүй болгох, лицензийг хураах, бүртгэлээс хасах зэрэг байж болно. Энэ нь АББ, түүнийг төлөөлж байгаа хүнд давхар иргэний эсвэл захиргааны, эрүүгийн журмаар хариуцлага хүлээлгэхэд саад болох ёсгүй.

²⁴ Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой тусгай бүртгэл эсвэл лиценз авах шаардлага тавих шаардлагагүй. Жишээ нь: зарим улсад АББ нь татварын хөнгөлөлт эдлэхийн тулд татварын байгууллагад бүртгэлтэй, хяналтад хамрагдаж байдаг(татварын хөнгөлөлт, чөлөөлөлт авах зорилгоор).

- (iv). ААБ-д бүх хөрөнгө нь бүртгэлтэй бөгөөд зарцуулалт нь тодорхойлсон үйл ажиллагааных нь зорилго, зорилтод нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж байх шаардлагыг тавьж болно;
- (v). АББ-аас үр шим хүртэгчид²⁵ эсвэл хамаарал бүхий этгээдийн хэн болох, эрх үүрэг болон эерэг байдлыг тодорхойлсон арга хэмжээ авах, баталгаажуулах мөн тэдгээр нь террористууд эсвэл террорист байгууллагыг²⁶ дэмжих зорилгоор ААБ-тай холбоогүй ба/эсвэл ашигладаггүй гэдгийг баталгаажуулах холбогдох шаардлага хангасан арга хэмжээ авахыг шаардаж болно. Гэхдээ АББ-с харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа явуулахыг шаардаж болохгүй. АББ-уудаас хандивлагчийг нууцлах үүргээ биелүүлэхийн хажуугаар чухал, том хандивлагчийн мэдээллийг баримтжуулах зохистой арга хэмжээ авахыг шаардаж болно. Энэ шаардлагын эцсийн зорилго нь буяны санг террористууд болон террорист байгууллагыг санхүүжүүлэх, дэмжих зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх явдал юм.
- (vi). АББ-аас тухайн байгууллагын зорилго, зорилтын дагуу мөнгө хүлээн авсан, зарцуулсан эсэхийг нягтлахын тулд дотоод, гадаад гүйлгээний нарийвчилсан бүртгэлийг дор хаяж таван жил хадгалах, шаардлагатай бол түүнийг эрх бүхий байгууллагад хэрэгцээтэй үед гаргаж өгөхийг шаардаж болно. Энэ нь дээр дурдсан (ii) ба (iii) хэсэгт дурдсан мэдээлэлд мөн хамаарна. Шаардлагатай тохиолдолд АББ-ын буяны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгох боломжтой.
- (с) үр дүнтэй мөрдөн байцаах болон мэдээлэл цуглуулах
- (i). Улс орнууд АББ-уудын талаар холбогдох мэдээллийг хадгалдаг бүх шатны эрх бүхий байгууллагуудын хооронд үр дүнтэй хамтын ажиллагаа, уялдаа холбоо болон мэдээлэл солилцоог хангах ёстой.
- (ii). Улс орнууд террорист үйл ажиллагаа эсвэл террорист байгууллагад урвуулан ашиглагдаж эсвэл тэдгээрийг идэвхтэй дэмжиж байгаа гэж сэжиглэгдэж байгаа АББ-ыг мөрдөн шалгах мэрэгшил болон чадвартай байх ёстой.

²⁵ АББ-ын буяны, хүмүүнлэгийн эсхүл бусад төрлийн тусламж авдаг хувь хүн эсхүл бүлэг хувь хүнийг хэлнэ.

²⁶ АББ-ыг хүн болгоныг тодорхойлох шаардлага тавиагүй болно. Зарим тохиолдолд ийм шаардлага тавих нь АББ үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болгож болзошгүй.

- (iii). Улс орнууд мөрдөн шалгах явцад тодорхой АББ-ын удирдлага, менежментийн талаархи мэдээлэл (санхүүгийн болон төлөвлөгөөний мэдээлэл гэх мэт) олж авах бүрэн боломжтой байх ёстой.
- (iv). Улс орнууд АББ-ыг: (1) террорист байгууллагуудтай холбоотой эсхүл хөрөнгө цуглуулах үйл ажиллагаанд нь халхавч болж байгаа; (2) хөрөнгө царцаах арга хэмжээнээс зайлсхийх эсхүл терроризмыг бусад аргаар дэмжих зэрэг терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглагдах (3) хууль ёсны үйл ажиллагаанд зарцуулагдах байсан хөрөнгийг террористууд болон террорист байгууллагуудад шилжүүлсэн гэж сэжиглэх үндэслэлтэй тохиолдолд урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулахын тулд шаардлагатай мэдээллийг эрх бүхий байгууллагатай цаг алдалгүйгээр солилцох механизм бий болгох хэрэгтэй.
- d. Улс орнууд АББ-ын талаархи мэдээлэл авах олон улсын хүсэлтэд хариу өгөх чадамжтай байх ёстой. Улс орнууд олон улсын хамтын ажиллагааны Зөвлөмжийн заалтад нийцүүлэн терроризмыг санхүүжүүлэх болон терроризмыг дэмжиж байгаад сэжиглэгдсэн тодорхой АББ-ын талаар мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөх байгууллага болон зохицуулах журмыг тодорхойлох шаардлагатай.

Г. ХЯНАЛТ ШАЛГАЛТ, МӨРДӨН ШАЛГАХАД ЗОРИУЛСАН НӨӨЦ

7. Улс орнууд АББ-ын үйл ажиллагааг хянах, шалгах, мөрдөн шалгах үүрэгтэй холбогдох эрх бүхий байгууллагыг шаардлагатай санхүүгийн, хүний болон техникийн нөөцөөр хангах ёстой.

Энэ Зөвлөмжид ашигласан нэр томъёоны тайлбар

Холбогдох эрх бүхий байгууллага	Эрх бүхий дараах байгууллагуудыг хэлнэ: зохицуулагч байгууллага, татварын алба, СМА, хууль сахиулах байгууллага, тагнуулын байгууллага, магадлан итгэмжлэгдсэн байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллагыг хэлнэ.
Салбар АББ	Олон улсын АББ-ын гадаад улс орон дахь салбарууд болон түншлэлтэй АББ орно.
Үр шим хүртэгчид	АББ-ын буяны, хүмүүнлэгийн эсхүл бусад төрлийн тусламж авдаг хувь хүн эсхүл бүлэг хувь хүнийг хэлнэ.
Ашгийн байгууллага АББ	бус эсвэл Энэ нь буяны, шашин, соёл, боловсрол, нийгэм, сайн санааны зорилгоор эсвэл бусад төрлийн “сайн үйлс” үйлдэхэд голлон мөнгө, хөрөнгө цуглуулж, зарцуулдаг хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд,

байгууллага юм.

**Терроризмыг
санхүүжүүлэхэд
урвуулан ашиглагдах**

Террорист болон террорист байгууллага нь хөрөнгө босгох, шилжүүлэх, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, террористуудыг элсүүлэхийг дэмжих эсвэл бусад аргаар террорист байгууллага, түүний үйл ажиллагааг дэмжих зорилгоор АББ-ыг ашиглахыг хэлнэ.

ЗӨВЛӨМЖ 10-ЫН ТАЙЛБАР

(ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ)

А. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

1. Хэрэв санхүүгийн байгууллага нь бизнесийн харилцаа тогтоохоос өмнө, бизнес харилцаа тогтоох явцад болон нэг удаагийн гүйлгээ хийх үед тухайн гүйлгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэж байгаа бол дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой:

- (a) хамаарахгүй байх нөхцөл, гүйлгээний босго дүн, байнгын болон нэг удаагийн харилцагч гэдгээс үл хамааран харилцагч болон эцсийн өмчлөгчийг хэн болохыг тогтоож²⁷, баталгаажуулах арга хэмжээ авна;
- (b) Зөвлөмж 20 дагуу сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ)-г Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-нд хүргүүлнэ.

2. Зөвлөмж 21 нь санхүүгийн байгууллага, тэдгээрийн удирдлага, албан хаагчид болон ажилтнуудад СГТ эсвэл холбогдох мэдээллийг СМА-нд мэдээлсэн талаар нууцлалыг задруулахыг хориглодог. Санхүүгийн байгууллага нь харилцагчийг таньж мэдэх (ХТМ) үүргээ гүйцэтгэж байх үед санамсаргүйгээр харилцагчид мэдээллийг задруулах эрсдэл байдаг. Харилцагч нь болзошгүй СГТ эсвэл мөрдөн шалгах талаар мэдэх нь сэжиг бүхий мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг цаашид шалгах хүчин чармайлтад сөргөөр нөлөөлөх магадлалтай.

3. Иймд, хэрэв санхүүгийн байгууллага нь мөнгө угаах эсвэл терроризмыг санхүүжүүлэх сэжиглэх үндэслэл байгаа бол ХТМ үйл ажиллагаа явуулах үед сэжиг авхуулах эрсдэлийг тооцох хэрэгтэй. Хэрэв ХТМ үйл ажиллагаа явуулах нь харилцагч, боломжит харилцагчид сэжиг авахуулна гэж үзэх үндэслэл байгаа бол ХТМ үйл ажиллагаа явуулахгүй байхыг зөвшөөрөх шаардлагатай бөгөөд СГТ-аар мэдээлэх үүрэг хүлээнэ. Байгууллага нь ажилтнууддаа ХТМ үйл ажиллагаа явуулахад энэ эрсдэлийн талаар таниулж, болгоомжтой хандах арга хэмжээ авсан байх шаардлагатай.

Б. ХТМ – ХАРИЛЦАГЧИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ҮЙЛЧЛҮҮЛЭХ

4. Зөвлөмж 10-т заасан ХТМ арга хэмжээний (a) ба (б) элементүүдийг гүйцэтгэх үед санхүүгийн байгууллагууд нь харилцагчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа аливаа этгээдийг эрх бүхий эсэхийг шалгаж, тухайн хүнийг хэн болохыг тогтоож, баталгаажуулах шаардлагатай.

²⁷ “Хэн болохыг тогтоох мэдээлэл” гэж найдвартай, хараат бус мэдээллийн эх үүсвэр, өгөгдөл, мэдээллийг хэлнэ.

В. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ЭРХ ЗҮЙН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ХТМ

5. Харилцагч нь хуулийн этгээд эсвэл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд²⁸ байх тохиолдолд санхүүгийн байгууллага нь харилцагчаа хэн болохыг тогтоож, баталгаажуулах бөгөөд харилцагчийн бизнесийн мөн чанар, эзэмшил болон удирдлагын бүтцийг ойлгосон байх шаардлагатай. Харилцагч болон эцсийн өмчлөгчийг хэн болохыг тогтоох, баталгаажуулахтай холбоотой (а) ба (б) -д тавигдах шаардлагуудын зорилго нь хоёр талтай юм. Нэгдүгээрт, бизнесийн харилцаатай холбоотой мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх болзошгүй эрсдэлийг зохих ёсоор үнэлэх чадвартай байхын тулд харилцагчийг хангалттай таньж мэдсэнээр хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг хууль бусаар урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх; хоёрдугаарт, эрсдэлийг бууруулах талаар зохих арга хэмжээ авах. Энэ шаардлагууд нь нэг үйл явцын хоёр тал учраас харилцан бие биедээ нөлөөлж, нөхөх хандлагатай байдаг. Энэ хүрээнд, санхүүгийн байгууллагууд нь дараах үүрэгтэй байна:

(а) Харилцагчаа хэн болохыг тогтоож, мэдээллийг баталгаажуулах. Энэ үүргийг гүйцэтгэхэд дараах мэдээлэл шаардлагатай:

(i). Нэр, хуулийн этгээдийн төрөл, үүсгэн байгуулсан баримт бичиг - баталгаажуулалтыг жишээлбэл үүсгэн байгуулсаныг болон санхүүгийн тайланг гэрчлэх баримт бичиг, удирдах албан тушаал хашиж буй хувь хүмүүсийн нэр, хуулийн этгээдийн төрлийн бүртгэлийн гэрчилгээ, түншлэлийн гэрээ, трастын гэрээ болон найдвартай бие даасан эх сурвалжаас харилцагчийн нэр, хэлбэр, үүсгэн байгуулагдсан хууль ёсны хэлбэр, оршин тогтнож буйг баталсан нотолгоог баталгаажуулан авсан бусад баримт бичиг зэргээс авах боломжтой.

(ii). Хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг үүсгэн байгуулсан, зохицуулах үндсэн баримт бичиг (жишээлбэл, компанийг үүсгэн байгуулсан гэрээ, дүрэм) болон удирдах албан тушаал хашиж буй хувь хүмүүсийн нэр (жишээлбэл компанийн дээд удирдлага, захирал, трастийн трастий).

²⁸ Зөвлөмжид эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд гэж жишээ нь траст (бусад ижил төрлийн зохицуулалтууд) санхүүгийн байгууллага эсвэл СББМҮҮ-ийн харилцагч байх, гүйлгээ хийх, трастийн үүрэг хүлээгч хувь хүн хуулийн этгээд нь гэрээний үр шим хүртэгчийн өмнөөс эсвэл трастын нөхцлийн дагуу бизнес харилцаа тогтоох гүйлгээ хийхийг хамруулна. Хувь хүн хуулийн этгээдэд хамаарах ХТМ шаардлага жирийн шаардлага, 3.10-ийн Тайлбарын 4 хэсэг мөн хамаарна, гэхдээ траст болон трастын эцсийн өмчлөгчтэй холбоотой шаардлагыг нэмж хамруулах болно.

(iii). Бүртгэлтэй албан ёсны хаяг, хэрэв өөр бол бизнесийн үйл ажиллагаа явуулах хаяг.

(b) Санхүүгийн байгууллага нь эцсийн өмчлөгчийг хэн болохыг тогтоож, мэдээллийг баталгаажуулах дараах зохистой арга хэмжээ²⁹ авна:

(i) Хуулийн этгээдийн хувьд³⁰:

(i.i) Хуулийн этгээдийн хяналтын багцыг³¹ өмчилж байгаа хувь хүнийг хэн болохыг тогтоох мэдээлэл (хэрэв байгаа бол - өмчийн эрх нь маш олон төрөл байж болох тул хяналтын хувь нь олон хүнд тархсан ямар нэгэн тодорхой хувь хүн (дангаар эсвэл хамтарч) хяналтыг гүйцэтгэдэггүй байж болно).

(i.ii) Хэрэв (i.i) заалтын хувьд хяналтын багцыг эзэмшдэг хувь хүн/хүмүүс нь эцсийн өмчлөгч/өмчлөгчид мөн эсэх талаар эргэлзээ байгаа бол эсвэл тодорхой хувь хүн хяналтын хувийг эзэмшдэггүй бол бусад арга замаар хуулийн этгээд эсвэл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдэд хяналт тавьж буй хувь хүн/хүмүүсийн (хэрэв байгаа бол) хэн болохыг тогтоох мэдээлэл;

(i.iii) Хэрэв (i.i) эсвэл (i.ii) заалтын дагуу хувь хүн тогтоогдоогүй бол санхүүгийн байгууллага нь удирдах дээд албан тушаал хашиж байгаа хувь хүнийг хэн болохыг тогтоож, баталгаажуулах зохистой арга хэмжээ авна.

(ii) Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн хувьд:

(ii.i) Траст – Трастын гэрээний трастий, сетлор, хамгаалагч (хэрэв байгаа бол), үр шим хүртэгч эсвэл үр шим хүртэгчийн бүлэг³² болон тухайн гэрээг бодитоор хянадаг (хяналтын сүлжээ болон эзэмших хэлбэрээр дамжуулж) хувь хүний хэн болохыг тогтоож, мэдээллийг баталгаажуулах;

(ii.ii) Бусад хэлбэрийн эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн хувьд ижил төстэй, ойролцоо албан тушаалд байгаа хувь хүнийг хэн болохыг тогтоож, мэдээллийг баталгаажуулах боломжит арга хэмжээ авах.

²⁹ Баталгаажуулах боломжит арга хэмжээг тогтоохдоо тухайн харилцагч эсвэл бизнес харилцааны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг харгалзан үзнэ.

³⁰ (i.i)- (i.iii) тусгасан арга хэмжээ нь сонголттой хэрэглэх арга хэмжээ биш бөгөөд дараалан хэрэгжүүлж өмнөхийг хэрэглээд эцсийн өмчлөгчийг тогтоож чадаагүй бол дараагийнхийг хэрэглэх зарчимтай.

³¹ Хяналтын хувь нь компанийн хувь эзэмшлийн бүтцээс хамаарна. Энэ нь ямар нэгэн босго хэмжүүрээр хэмжигдэж болно, жишээ нь компанийн тодорхой хувиас (ж.нь 25%) дээш хувь эзэмшиж буй хувь хүн.

³² Санхүүгийн байгууллага нь трастын гэрээний үр шим хүртэгчийн хувьд төлбөр хийгдэх үед эсвэл хуулийн дагуу эрхээ хэрэгжүүлэх үед нь тухайн эцсийн өмчлөгчийг хэн болохыг тогтоох, баталгаажуулах мэдээлэл олж авах ёстой.

Хэрэв харилцагч нь эсвэл компанийн хяналтын хувь эзэмшигч нь хөрөнгийн биржид бүртгэлтэй, эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээдэг бол (хөрөнгийн биржийн журам, хууль эсвэл бусад биелүүлэх шаардлагатай журмын дагуу), эсвэл ийм төрлийн компани ихэнх хувийг эзэмшдэг компани бол эдгээр компанийн хувь эзэмшигч болон эцсийн өмчлөгчийг хэн болохыг тогтоох, баталгаажуулах шаардлагагүй.

Хэн болохыг тогтоох мэдээллийг олон нийтэд ил тод бүртгэлийн сан, харилцагчаас эсвэл бусад найдвартай эх сурвалжаас авч болно.

Г. АМЬ НАСНЫ ДААТГАЛЫН ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ

6. Санхүүгийн байгууллага нь харилцагч болон эцсийн өмчлөгч нартай холбоотой ХТМ үйл ажиллагаанаас гадна амь насны даатгалын үр шим хүртэгч болон бусад хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын үр шим хүртэгч нарын хувьд тэдгээр нь тодорхой болмогц дараах ХТМ үйл ажиллагаа явуулах шаардлагатай:

- (a) Хувь хүн, хуулийн этгээд эсвэл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд гэж тодорхойлогдсон үр шим хүртэгч(ид)-ийн хувьд нэрийг тодорхой болгож авах;
- (b) Төрлөөр нь эсвэл ангиллаар (жишээлбэл даатгуулагдсан үйл явдал тохиолдсон үед эхнэр, нөхөр эсвэл хүүхдүүд) эсвэл бусад арга замаар (жишээлбэл гэрээслэлийн дагуу) - санхүүгийн байгууллагын шаардлагыг хангасан мэдээллийг үр шим хүртэгчийн төлбөр хийгдэх үед хэн болохыг тогтоох хангалттай мэдээлэл олж авах.

Санхүүгийн байгууллага нь (a) болон (б) хэсэгт цуглуулсан мэдээллийг Зөвлөмж 11-ийн заалтын дагуу баримтжуулж, хадгална.

7. Дээрх (a) ба (б) хоёр тохиолдол бүрт нь төлбөр хийгдэх үед үр шим хүртэгчийн хэн болохыг баталгаажуулах үйл ажиллагааг явуулах шаардлагатай.

8. Санхүүгийн байгууллага нь ХТМ өргөжүүлсэн үйл ажиллагаа шаардлагатай эсэхийг тодорхойлоход амь насны даатгалын үр шим хүртэгч нарыг эрсдэлийн нэг нөхцөл гэж авч үзэх шаардлагатай. Хэрэв санхүүгийн байгууллага нь хуулийн этгээд эсвэл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд нь өндөр эрсдэлтэй гэж үзвэл үр шим хүртэгчийн эцсийн өмчлөгч хэн болохыг тогтоох, баталгаажуулах ХТМ өргөжүүлсэн зохистой арга хэмжээг төлбөр хийгдэх үед авах шаардлагатай.

9. Санхүүгийн байгууллага нь дээрх 6-8-р зүйлийг дагаж мөрдөх боломжгүй тохиолдолд сэжигтэй гүйлгээний тайлан хүргүүлэх арга хэмжээг авах талаар судална.

Д. ӨМНӨ ЦУГЛУУЛЖ, БАТАЛГААЖУУЛСАН ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ

10. Зөвлөмж 10-д тусгасан ХТМ арга хэмжээ нь санхүүгийн байгууллагаас харилцагчийг гүйлгээ хийх бүрт түүний хувийн мэдээллийг шалгаж, баталгаажуулах шаардлагатай гэсэн утга санааг илэрхийлээгүй. Байгууллага нь тухайн мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзээгүй л бол өмнө нь цуглуулж, баталгаажуулсан мэдээллийг ашиглаж болно. Жишээ нь харилцагч нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байж болзошгүй гэж сэжиг төрөх, эсвэл харилцагчийн дансыг удирдах арга хэлбэр нь түүний бизнесийн профайлтай нийцэхгүй болох, мэдэгдэхүйц өөрчлөгдөх тохиолдолд санхүүгийн байгууллага эргэлзээтэй байдал орж, өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзэж болно.

Е. БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ ЦАГ ХУГАЦАА

11. Бизнесийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах шаардлагатай бол санхүүгийн байгууллагад мэдээллийг баталгаажуулах үйл ажиллагааг харилцаа тогтоосны дараа, богино хугацаанд гүйцэтгэх боломжийг олгож болох нөхцөл байдлуудын жишээг дор дурдав (дээр дурьдсан амь насны даатгалын үр шим хүртэгчдэд зориулсан тохиолдлоос гадна):

- Зайнаас хийх бизнес
- Үнэт цаасны гүйлгээ. Үнэт цаасны салбарт компаниуд болон зуучлагч нар харилцагчидтай холбоо барьж байх үеийн зах зээлийн нөхцөлийн дагуу гүйлгээг маш хурдан хийх бөгөөд мэдээллийг баталгаажуулж дуусахаас өмнө гүйлгээ хийхийг шаардаж болно.

12. Санхүүгийн байгууллага нь харилцагчийн мэдээллийг баталгаажуулах арга хэмжээ авахаас өмнө харилцагч нь бизнес харилцаагаа ашиглахаас сэргийлсэн эрсдэлийн удирдлагын журам, заавартай байх хэрэгтэй. Энэ журам, зааварт хийж болох гүйлгээний тоо, төрөл болон хэмжээг хязгаарлах, тухайн төрлийн харилцаанд тооцоолж байсан хэмжээнээс гадуур хийж байгаа их хэмжээний эсвэл цогц гүйлгээнд хяналт тавих зэрэг олон арга хэмжээг багтаасан байх ёстой.

Ё. ХУУЧИН ХАРИЛЦАГЧИД

13. Санхүүгийн байгууллага нь хуучин харилцагч³³ нарын хувьд бодит байдал болон эрсдэлийн түвшингээс хамаарч ХТМ үйл ажиллагаанд тавих шаардлагаа тогтоох бөгөөд эдгээр тогтсон харилцаандаа ХТМ үйл ажиллагаа хэзээ хийгдсэн, байгаа мэдээлэл нь

³³ Үндэстний хэмжээнд шинэ шаардлага хүчин төгөлдөр болох үед бүртгэлтэй байгаа харилцагч нар.

хангалттай эсэх зэргээс хамаарч тохирсон цаг хугацаанд нь ХТМ үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.

Ж. ЭРСДЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛ³⁴

14. Доорх жишээ нь ФАТФ-ын стандартын заавал дагаж мөрдөх зүйл биш бөгөөд зөвхөн зааварчилгааны зориулалтаар орсон болно. Эдгээр жишээ зарим тохиолдолд хэрэг болох боловч өргөн хүрээг хамаарсан биш бөгөөд тохиолдол болгонд тустай байх албагүй юм.

Өндөр эрсдэл

15. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр байх нөхцөл байдаг бөгөөд ХТМ өргөтгөсөн арга хэмжээ авах шаардлагатай. Харилцагч, улс орон эсвэл газар зүйн бүс нутаг, тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ болон түгээх сувагтай холбоотой мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэхэд өндөр эрсдэлтэй нөхцөл байдлыг илэрхийлэх дараах хүчин зүйлсийг (Зөвлөмж 12-16-д заасан зүйлсээс гадна) анхаарна:

(а) Харилцагтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлс:

- Бизнесийн харилцаа нь ер бусын нөхцөлд явагддаг (жишээ нь санхүүгийн байгууллага болон харилцагч хоорондын тайлбарлахад хэцүү газар зүйн хол зай)
- Байнгын оршин суугч бус харилцагч
- Хувийн хөрөнгө хадгалах зориулалттай хэрэгсэл бүхий хуулийн этгээд эсвэл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд
- Номинал хувьцаа эзэмшигч эсвэл төлөөллийн хувьцаа эзэмшигчидтэй компаниуд.
- Их хэмжээний бэлэн мөнгөтэй харьцдаг бизнес.
- Компанийн өмчлөлийн бүтэц нь тухайн компанийн бизнесийн шинж чанарыг харгалзан ер бусын эсвэл хэт төвөгтэй байх.

(б) Улс орон эсвэл газар зүйн байрлалтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлс³⁵:

- Харилцан үнэлгээ, нарийвчилсан үнэлгээний тайлан болон дахин үнэлгээний тайлан зэрэг баталгаатай эх үүсвэрээр МУТСТ тогтолцоо нь доголдолтой хэмээн тодорхойлогдсон улс орнууд,
- НҮБ-аас гаргасан хориг арга хэмжээ, эмбарго болон үүнтэй төстэй арга хэмжээнд хамрагдсан улс орон,

³⁴ ЭСА-г ХТМ арга хэмжээ шаардаж байгаа тохиолдолд хэрэглэхгүй, гэхдээ тухайн арга хэмжээний хүрээг тогтооход ашиглаж болно.

³⁵ Зөвлөмж 19 дагуу ФАТФ-аас санхүүгийн байгуулагад ХТМ өргөтгөсөн арга хэмжээ ав гэж шаардсан тохиолдолд улс орнууд санхүүгийн байгуулагаас үүнийг шаардах ёстой.

- Авлига болон бусад гэмт хэрэг их хэмжээгээр гардаг нь баталгаатай эх үүсвэрээр тодорхойлогдсон улс орон,
- Терроризмыг санхүүжүүлдэг, дэмжлэг үзүүлдэг, эсвэл тус улсад террорист байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг гэдэг нь баталгаатай эх сурвалжаар тодорхойлогдсон улс орон эсвэл газар зүйн бүс нутаг.

(в) Бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ болон түгээх сувгатай холбоотой эрсдэлийн хүчин зүйлс:

- Хувийн банкны үйлчилгээ
- Тодорхой нэргүй нууц гүйлгээ (үүнд бэлэн мөнгийг оруулж болно).
- Зайнаас хийх бизнесийн харилцаа, гүйлгээ.
- Үл мэдэгдэх эсвэл хамааралгүй гуравдагч этгээдээс хүлээн авсан төлбөр.

Бага эрсдэл

16. Мөнгө угаах эсвэл терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бага байх нөхцөл байдал байж болно. Ийм нөхцөлд, тухайн улс эсвэл санхүүгийн байгууллага нь эрсдэлд хангалттай дүн шинжилгээ хийсэн бол тухайн улс өөрийн санхүүгийн байгууллагад ХТМ хялбаршуулсан үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг зөвшөөрч болно.

17. Харилцагч, улс орон эсвэл газар зүйн бүс нутаг, тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ болон түгээх сувагтай холбоотой мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэхэд бага эрсдэлтэй нөхцөл байдлыг илэрхийлэх дараах хүчин зүйлсийг анхаарна:

(а) Хэрэглэгчтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлс:

- Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нь ФАТФ-ийн зөвлөмжид нийцсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг хүлээдэг, энэ үүргээ үр дүнтэй хэрэгжүүлдэг, Зөвлөмжийн дагуу үүргээ хэрхэн биелүүлж байгааг үр дүнтэй хянаж, шалгадаг байх.
- Хөрөнгийн биржид бүртгэлтэй, эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээдэг (хөрөнгийн биржийн журам, хууль эсвэл бусад биелүүлэх шаардлагатай журмын дагуу) хувьцаат компани.
- Төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж.

(б) Бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ болон түгээх сувагтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлс:

- Хураамж багатай амь насны даатгалын гэрээ (жишээ нь жилийн хураамж нь 1,000 ам.доллар/евроогоос доош эсвэл нийт хураамж нь 2500 ам.доллар/евроогоос доош байх).

- Хэрэв хугацаанаас нь өмнө цуцлах боломжгүй бөгөөд уг гэрээг барьцаа болгон ашиглах боломжгүй тэтгэврийн даатгалын гэрээ.
- Тэтгэвэр, хуримтлалын тэтгэвэр эсвэл тэтгэвэрт гарсны дараа төлбөр төлөх ижил төстэй тогтолцоо нь цалингаас суутгал хийх зарчмаар хэрэгждэг, төлбөрийг урьдчилан хуваарилахыг зөвшөөрдөггүй байх.
- Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой төрлийн харилцагчдад зориулсан, хязгаарлагдмал үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ.

(в) Улс оронтой холбоотой эрсдэлийн хүчин зүйлс:

- Харилцан үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээний тайлан зэрэг баталгаатай эх үүсвэрээр МУТСТ тогтолцоо нь үр дүнтэй хэмээн тодорхойлогдсон улс орнууд,
- Авлига болон бусад гэмт хэрэг бага гардаг нь баталгаатай эх үүсвэрээр тодорхойлогдсон улс орон.

Эрсдэлийн үнэлгээ хийхдээ шаардлагатай бол улс орон, санхүүгийн байгууллага нь тухайн улсын дотоод бүс нутгийн хооронд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн түвшиний зөрүүг харгалзан үзэж болно.

18. Хэн болохыг тогтоох, баталгаажуулахад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх ХТМ-ын бага эрсдэлтэй байх нь тухайн харилцагч бүх төрлийн ХТМ арга хэмжээ, ялангуяа гүйлгээнд нь тогтмол хяналт тавигдахад бага эрсдэлтэй байна гэсэн үг биш юм.

ЭРСДЭЛИЙН ХУВЬСАГЧИД

19. Санхүүгийн байгууллага нь харилцагчдийн төрөл, улс орон, газар зүйн бүс нутаг мөн тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ эсвэл түгээх сувагтай холбоотой мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэхдээ эдгээр эрсдэлийн төрөлтэй холбоотой эрсдэлийн хувьсагчдыг анхаарна. Эдгээр хувьсагчууд дангаар эсвэл хосолсон байдлаар үүсч болзошгүй эрсдэлийг нэмэгдүүлж эсвэл бууруулж болзошгүй тул ХТМ арга хэмжээнд зохих түвшинд нөлөөлнө. Ийм хувьсагчдын жишээнд дараах зүйлс орно:

- Данс эсвэл бизнесийн харилцааны зорилго,
- Харилцагчийн дансанд байршуулах хөрөнгө эсвэл хийсэн гүйлгээний хэмжээ,
- Бизнесийн харилцааны тогтмол байдал эсвэл үргэлжлэх хугацаа.

ХТМ өргөтгөсөн арга хэмжээ

20. Санхүүгийн байгууллага нь аливаа цогц, их хэмжээний гүйлгээний эх үүсвэрийн мэдээлэл болон зорилгыг, түүнчлэн тодорхой эдийн засаг, хууль зүйн үндэслэлгүй хэвийн бус гүйлгээний шинжийг боломжийнхоо хирээр шалгах шаардлагатай. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр байгаа тохиолдолд санхүүгийн байгууллага нь тодорхойлогдсон эрсдэлтэй уялдуулан ХТМ өргөтгөсөн арга хэмжээ авах шаардлагатай. Ялангуяа эдгээр гүйлгээ, үйл ажиллагаа нь ер бусын эсвэл сэжигтэй эсэхийг тодорхойлохын тулд бизнесийн харилцааны хяналтын түвшин, төрлөө нэмэгдүүлэх шаардлагатай. Өндөр эрсдэлтэй бизнесийн харилцаанд дараах ХТМ өргөтгөсөн арга хэмжээг хэрэгжүүлж болно:

- Харилцагчийн талаар нэмэлт мэдээлэл авах (жишээ нь ажлын байрны тодорхойлолт, хөрөнгийн хэмжээ, олон нийтэд нээлттэй мэдээллийн сангаас мэдээлэл авах, интернет г.м) болон харилцагч, эцсийн өмчлөгчийг тодорхойлох мэдээллийг тогтмол шинэчлэх.
- Бизнесийн харилцааны зорилгын талаар нэмэлт мэдээлэл авах.
- Санхүүгийн эх үүсвэр эсвэл харилцагчийн хөрөнгийн эх үүсвэрийн талаар мэдээлэл авах.
- Төлөвлөсөн эсвэл хийсэн гүйлгээний зорилго, шалтгааны талаар мэдээлэл авах.
- Бизнесийн харилцааг эхлүүлэх эсвэл үргэлжлүүлэхэд дээд удирдлагын зөвшөөрөл авах.
- Хяналтын тоо, хийх хугацааг нэмэгдүүлж, цаашид судлах шаардлагатай гүйлгээний төрлийг сонгох замаар бизнесийн харилцаанд нэмэлт хяналт тавих.
- Эхний төлбөрийг ижил төстэй ХТМ стандарттай банкин дахь харилцагчийн дансаар дамжуулан хийхийг шаардах.

ХТМ хялбаршуулсан арга хэмжээ

21. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бага байгаа тохиолдолд санхүүгийн байгууллага нь ХТМ хялбаршуулсан арга хэмжээ авахыг бага эрсдэлийн шинж чанарыг харгалзан зөвшөөрч болно. Хялбаршуулсан арга хэмжээ нь бага эрсдэлийн хүчин зүйлстэй (жишээлбэл хялбаршуулсан арга хэмжээ нь зөвхөн харилцагчийг хүлээн зөвшөөрөх эсвэл тогтмол хяналт тавихад зөвшөөрөгдөж болно) хамааралтай байх ёстой. Үүнд:

- Бизнесийн харилцаа тогтоосны дараа харилцагч болон эцсийн өмчлөгчийн хэн болох мэдээллийг баталгаажуулах (жишээ нь дансны гүйлгээ нь тодорхой мөнгөн дүнгийн босгыг давсан тохиолдолд).
- Харилцагчаа хэн болохыг тогтоох мэдээллийг шинэчлэх давтамжийг багасгах.
- Тогтмол хянах болон тохиромжтой мөнгөн дүнгийн босгоос хамаарсан гүйлгээнд дүн шинжилгээ хийх давтамжийг бууруулах.

- Бизнесийн харилцааны зорилго, шинж чанарыг ойлгохын тулд тодорхой мэдээлэл цуглуулахгүй, тодорхой арга хэмжээ авахгүйгээр тэдгээрийг гүйлгээний төрөл эсвэл байгуулсан бизнесийн харилцаанаас ойлгох.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой сэжигтэй эсвэл тодорхой өндөр эрсдэлтэй хувилбарууд гарах тохиолдолд ХТМ хялбаршуулсан арга хэмжээг хүлээн зөвшөөрч болохгүй.

Босго мөнгөн дүн

22. Зөвлөмж 10-т заасны дагуу тохиолдлын гүйлгээ хийх тогтоосон босго нь 15,000 ам.доллар/евро болно. Тогтоосон босго хэмжээнээс давсан санхүүгийн гүйлгээнд нэг удаагийн гүйлгээ эсвэл хоорондоо холбоотой хэд хэдэн гүйлгээ багтана.

ХТМ үйл ажиллагааг тогмол хийх

23. Санхүүгийн байгууллага нь ХТМ үйл ажиллагааны явцад цуглуулсан баримт бичиг, өгөгдөл болон мэдээлэл нь ач холбогдолтой бөгөөд сүүлийн үеийнх байх үүрэг хүлээх бөгөөд байгаа мэдээлэлдээ үнэлгээ хийнэ, өндөр эрсдэлтэй харилцагчийн ангиллыг онцгой анхаарна.

ЗӨВЛӨМЖ 12-ЫН ТАЙЛБАР

(УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭД)

Санхүүгийн байгууллага нь амь насны даатгалын гэрээтэй холбоотойгоор үр шим хүртэгч, шаардлагатай бол үр шим хүртэгчийн эцсийн өмчлөгч нь УТНБЭ эсэхийг тогтоох зорилгоор зохистой арга хэмжээг авах шаардлагатай. Энэ арга хэмжээг даатгалын нөхөн төлбөр олгоход эцсийн байдлаар хэрэгжүүлсэн байна. Хэрвээ өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон бол санхүүгийн байгууллага нь жирийн ХТМ үйл ажиллагаа хэрэгжүүлэхээс гадна дараах зүйлсийг хэрэгжүүлэх шаардлагатай:

- а) даатгалын нөхөн төлбөр төлөхөөс өмнө дээд шатны удирдлагад мэдэгдэх;
- б) даатгуулагчтай тогтоосон бизнесийн харилцааг бүхэлд нь тусгайлан нягтлах болон сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэхийг харгалзан үзэх.

ЗӨВЛӨМЖ 13-ЫН ТАЙЛБАР

(КОРРЕСПОНДЕНТ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА)

Санхүүгийн байгууллага нь ижил зарчмаар (a) - (e) шалгуурыг жишээ нь үнэт цаасны гүйлгээнд зориулсан болон мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх харилцаанд хил дамнасан корреспондент банкны харилцааг үндсэн эсвэл харилцагчийн нэрийн өмнөөс хийж байгаагаас үл хамааран хэрэгжүүлэх шаардлагатай.

"Дамжин өнгөрөх данс" нэр томъёо нь гуравдагч этгээд өөрийн нэрийн өмнөөс бизнес эрхлэхэд ашигладаг корреспондент дансыг хэлнэ.

ЗӨВЛӨМЖ 14-ИЙН ТАЙЛБАР

МӨНГӨ, ҮНЭ БҮХИЙ ЗҮЙЛ ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ (МҮБЗШҮ)

Тухайн улсад өмнө нь санхүүгийн байгууллагаар (ФАТФ-ийн зөвлөмжид тодорхойлсны дагуу) бүртгэгдсэн болон тусгай зөвшөөрөл авсан, энэ тусгай зөвшөөрөл, бүртгэлээр мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ эрхлэх эрхтэй бөгөөд ФАТФ-ийн Зөвлөмжид хамаарах үүргийг хэрэгжүүлдэг хувь хүн, хуулийн этгээдийг дахин тусдаа бүртгэл хийлгэх, тусгай зөвшөөрөл авах шаардлага тавьж болохгүй.

ЗӨВЛӨМЖ 15-ЫН ТАЙЛБАР

1. ФАТФ-ын Зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд виртуал хөрөнгийг “хөрөнгө”, “мөнгөн хөрөнгө”, “ мөнгөн болон бусад хөрөнгө” болон “харгалзах үнэ бүхий” бусад гэж тодорхойлно. Улс орнууд ФАТФ-ын Зөвлөмжийн холбогдох арга хэмжээнд виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч - ВХҮҮ (virtual asset service providers- VASPs) нарыг хамруулна.

2. Улс орнууд Зөвлөмж 1-ийн дагуу виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарын үйл ажиллагааны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлох, ойлгох, үнэлэх шаардлагатай. Улс орнууд үнэлгээгээр тогтоосон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх эрсдэлд суурилсан арга хэмжээ авна. Улс орнууд виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нараас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ тодорхойлох, үнэлэх болон эрсдэлээ бууруулах үр дүнтэй арга хэмжээ авахыг шаардана.

3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарыг бүртгэлтэй эсвэл тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардана. Доод тал нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарыг үүсгэн байгуулсан³⁶ улс орондоо бүртгэлтэй эсвэл тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардана. Хэрвээ виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь хувь хүн бол бизнес үйл ажиллагаа явуулж байгаа улс орондоо бүртгэлтэй эсвэл тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардана. Улс орнууд харилцагчид бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлж байгаа болон тухайн улсаас үйл ажиллагаагаа явуулж байгаа виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарыг мөн бүртгэлтэй эсвэл тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардаж болно. Эрх бүхий байгууллага нь гэмт хэрэгтэн болон тэдний хамсаатнууд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч байх, эцсийн өмчлөгч, хувьцааны дийлэнхийг болон хяналтын багцыг эзэмших, удирдах албан тушаал хашихаас сэргийлсэн хууль, эрх зүйн болон зохицуулалтын шаардлагатай арга хэмжээ авна. Улс орнууд виртуал хөрөнгийн үйлчилгээг бүртгэлгүй эсвэл тусгай зөвшөөрөлгүй эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, холбогдох шийтгэлийн арга хэмжээ авна.

4. Улс орнууд виртуал хөрөнгийн үйлчилгээг санхүүгийн байгууллагын (ФАТФ-ын Зөвлөмжийн тодорхойлолтын дагуу) бүртгэл эсвэл тусгай зөвшөөрөлтэй эрхэлж байгаа, энэ бүртгэл эсвэл тусгай зөвшөөрөл нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсөн бөгөөд ФАТФ-ын Зөвлөмжийн дагуу олон төрлийн үүргийг хүлээж байгаа бол ийм хувь хүн, хуулийн этгээдэд нэмэлт бүртгэл, тусгай зөвшөөрөл авах үүрэгт хүлээлгэх хэрэггүй.

5. Улс орнууд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарыг МУТСТ холбогдох зохицуулалттай, виртуал хөрөнгөөс улбаатай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах болон ФАТФ-ын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа талаар хяналт шалгалтад хамруулахад анхаарна. Мөн үндэсний хэмжээний МУТСТ шаардлагыг биелүүлж байгаа эсэхийг хянах үр дүнтэй системтэй байх шаардлагатай. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нар нь эрх бүхий байгууллагын эрсдэлд суурилсан хяналт шалгалтад (ӨЗБ байж болохгүй) хамрагддаг байх шаардлагатай. Хянан шалгагч нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийн биелэлтэд хяналт шалгалт хийх,

³⁶ Үүсгэн байгуулах гэж компани байгуулахыг батлах, зарлах болон бусад арга хэмжээг хэлнэ.

холбогдох баримт бичгийг гаргуулан авах, хариуцлага хүлээлгэх холбогдох эрхтэй байх шаардлагатай. Хянан шалгагч нь олон төрлийн захиргааны болон санхүүгийн хариуцлагын арга хэмжээ авах эрхтэй байх шаардлагатай бөгөөд шаардлагатай тохиолдолд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарын тусгай зөвшөөрөл, бүртгэлийг буцаах, цуцлах, хүчингүй болгох эрхтэй байна.

6. Улс орнууд МУТСТ үүргээ биелүүлэхгүй байгаа виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарт зөрчилд нь дүйцэхүйц, зөрчил дахин үйлдэхээс сэргийлэхүйц, эрүүгийн, иргэний, захиргааны шийтгэл ФАТФ-ын Зөвлөмж 35-ын дагуу оногдуулна. Хариуцлагыг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарт төдийгүй захирал, дээд шатны удирдлагад хүлээлгэнэ

7. Зөвлөмж 10-21 тусгасан урвдчилан сэргийлэх арга хэмжээний тухайд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нар дараах үүрэг хүлээнэ:

(а) 3.10 – виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн ХТМ хэрэгжүүлэх байнгын бус гүйлгээний босго дүн 1,000 ам.доллар/евроогоос дээш бол;

(б) 3.16 – Улс орнууд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нар нь виртуал хөрөнгийн шилжүүлэгт холбогдох шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээллийг³⁷ бүрэн дүүрэн, үнэн зөв авч, хадгалах бөгөөд хүлээн авагч виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон санхүүгийн байгууллагад (байгаа бол) шууд нууцлалыг ханган дамжуулна³⁸ мөн эрх бүхий байгууллага шаардсан тохиолдолд гаргаж өгч байгааг баталгаажуулна. Улс орнууд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хүлээн авагч тал нь виртуал хөрөнгийн шилжүүлэгт холбогдох шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв авч, хадгалах мөн эрх бүхий байгууллага шаардсан тохиолдолд гаргаж өгч байгааг баталгаажуулна. Зөвлөмж 16-ын бусад шаардлагыг (мэдээллийг бэлэн байлгах, хөрөнгө царцаах, хоригт орсон хувь хүн, этгээдийн гүйлгээ хийхгүй байх) мөн биелүүлнэ.

8. Улс орнууд нь Зөвлөмж 38, 40-ийн дагуу олон улсын хамтын ажиллагааны хүрээнд виртуал хөрөнгө холбогдсон мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотойгоор бүхий л төрлийн туслалцааг түргэн шуурхай, үр дүнтэй үзүүлвэл зохино. Ялангуяа виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарын хянан шалгагч нар гадаадын хянан шалгагч нартай, хянан шалгагчийн төрөл, статус болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нарын бүтэц өөр байх зэргээс үл хамааран цаг алдалгүй хэрэгтэй мэдээлэл солилцоно

³⁷ Тайлбарын 16-ын 6 хэсэгт тусгаснаар виртуал хөрөнгийн хувьд байж болох бусад мэдээлэл.

³⁸ Мэдээллийг шууд болон шууд бусаар дамжуулж болно. Виртуал хөрөнгө шилжүүлэхэд энэ мэдээллийг шууд хавсаргах шаардлагагүй.

ЗӨВЛӨМЖ 16-ЫН ТАЙЛБАР

(ЦАХИМ ШИЛЖҮҮЛЭГ)

А. ЗОРИЛГО

1. Зөвлөмж 16-г террорист этгээдүүд болон бусад гэмт хэрэгтнүүд хөрөнгө мөнгөө цахим шилжүүлэг ашиглан саадгүй шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, ийм хууль бусаар ашигласныг илрүүлэх зорилгоор боловсруулсан. Цахим шилжүүлгийн шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаарх үндсэн мэдээллийг дараах тохиолдолд бэлэн байлгах зорилготой. Үүнд:

- (a) Террорист этгээд болон бусад гэмт хэрэгтнүүдийг тодорхойлох, мөрдөн шалгах, яллах, тэдгээрийн хөрөнгийг мөшгихөд холбогдох эрх бүхий хууль сахиулах байгууллага болон прокурорын байгууллагад туслалцаа үзүүлэхэд;
- (b) Санхүүгийн мэдээллийн албыг сэжигтэй эсвэл хэвийн бус үйл ажиллагаанд шинжилгээ хийхэд, шаардлагатай тохиолдолд мэдээлэл дамжуулахад;
- (c) Шилжүүлэгч, зуучлагч болон хүлээн авагч санхүүгийн байгууллагуудад харилцагчийг тодорхойлох, сэжигтэй гүйлгээг мэдүүлэх, хөрөнгө царцаах арга хэмжээ авах, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс терроризм, терроризмын санхүүжилтээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай 1267-р тогтоол (1999) болон дагалдан гарсан тогтоол, 1373-р (2001) тогтоолоор жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн гүйлгээг хийхээс татгалзах үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

2. Эдгээр зорилгыг биелүүлэхийн тулд улс орнууд бүх цахим шилжүүлгийг мөшгих чадвартай байх шаардлагатай. Бага дүнтэй цахим шилжүүлгээр терроризмыг санхүүжүүлж болзошгүй тул улс орнууд албан бус мөнгөн гүйлгээ хийх эрсдэл, санхүүгийн хүртээмжийн ач холбогдлыг харгалзан босго дүнг багасгах нь зүйтэй. ФАТФ нь маш хатуу стандарт тогтоох эсвэл төлбөрийн системд сөргөөр нөлөөлөх ганцхан үйл ажиллагааны процессийг мөрдөх ёстой гэсэн шалгуур тавихыг зориогүй болно.

В. ХАМРАХ ХҮРЭЭ

3. Зөвлөмж 16 нь сериал төлбөр тооцоо, нэгтгэсэн төлбөр тооцоо зэрэг гадаад болон дотоод цахим шилжүүлгийн хоёуланд нь хамаарна.

4. Зөвлөмж 16 нь дараах төрлийн төлбөр тооцоог хамрахгүй. Үүнд:

- (a) Бараа бүтээгдэхүүн худалдан авах эсвэл үйлчлүүлэхдээ кредит, дебит, урьдчилсан төлбөрт карт ашиглан хийх, тухайн картны дугаар нь хийсэн бүх гүйлгээнд нь дагалдах төрлийн гүйлгээнүүд. Гэхдээ хэрэв кредит, дебит,

урьдчилсан төлбөрт картыг хувь хүнээс хувь хүн руу хийгдэх цахим шилжүүлэгт ашиглаж байгаа бол энэ нь Зөвлөмж 16-д хамаарагдах төдийгүй шаардлагатай мэдээллийг хавсаргах хэрэгтэй.

(b) Шилжүүлэгч болон хүлээн авагч нь өөрсдийн нэрийн өмнөөс гүйлгээ хийж байгаа санхүүгийн байгууллагууд бол тэдгээрийн хоорондох шилжүүлэг, төлбөр тооцоо.

5. Улс орнууд нь дараах тохиолдолд гадаад цахим шилжүүлэг (1,000 ам.доллар/еврогаос ихгүй)-т доод босго ашиглаж болно. Үүнд:

(a) Санхүүгийн байгууллага нь дараах мэдээллийг шилжүүлэгтэй хамт явуулж байгаа эсэхэд улс орон хяналт тавих шаардлагатай: (i) шилжүүлэгчийн нэр; (ii) хүлээн авагчийн нэр; (iii) аль аль талын дансны дугаар эсвэл гүйлгээний тодруулгын онцгой дугаар. Дээрх мэдээллийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэх үндэслэл байхгүй тохиолдолд баталгаажуулах шаардлагагүй, энэ тохиолдолд санхүүгийн байгууллага нь өөрийн харилцагчтай холбоотой мэдээллийг нягтлах шаардлагатай.

(b) Гэсэн хэдий ч улс орнууд гадаад улсаас ирж байгаа босго дүнгээс доогуур дүнтэй цахим шилжүүлгийн үед шилжүүлэгчийн үнэн зөв мэдээллийг авна гэж шаардаж болно.

С. ХИЛ ДАМНАСАН ХАМААРАХ ЦАХИМ ШИЛЖҮҮЛЭГ

6. Хамаарах цахим шилжүүлэгтэй холбоотой мэдээлэл нь дараах мэдээллийг агуулсан байх шаардлагатай. Үүнд:

(a) Шилжүүлэгчийн нэр;

(b) Гүйлгээнд оролцож буй шилжүүлэгчийн дансны дугаар;

(c) Шилжүүлэгчийн хаяг эсвэл иргэний үнэмлэхний дугаар эсвэл харилцагчийн дугаар³⁹, төрсөн огноо, газар;

(d) Хүлээн авагчийн нэр;

(e) Гүйлгээг хүлээн авагчийн дансны дугаар.

³⁹ Харилцагчийн дугаар гэж шилжүүлэгч санхүүгийн байгууллага шилжүүлэгчийг тодорхойлох тусгай дугаар бөгөөд 7 хэсэгт дурдсан гүйлгээний тодруулгын онцгой дугаараас тусдаа зүйл. Харилцагчийн дугаар нь шилжүүлэгч санхүүгийн байгууллагын хадгалж байгаа дараах мэдээллийн аль нэгтэй холбоотой байна: харилцагчийн хаяг, иргэний үнэмлэхний дугаар, төрсөн газар, төрсөн огноо.

7. Данс байхгүй тохиолдолд гүйлгээг хянах боломжтой гүйлгээний тодруулгын онцгой дугаарыг хавсаргах шаардлагатай.

8. Нэг шилжүүлэгчээс хүлээн авагч руу дамжуулах хэд хэдэн хил дамнасан цахим шилжүүлгийг багцалсан тохиолдолд, багц файл нь шилжүүлэгчийн болон хүлээн авагчийн үнэн зөв мэдээллийг агуулсан, хүлээн авагчийн улсад гүйлгээг мөшгих бүрэн боломжтой үед, 6 дах хэсэгт заасан шилжүүлэгчийн тухай мэдээллийн шалгуурыг шилжүүлэгчийн дансны мэдээллийг эсвэл гүйлгээний тодруулгын онцгой дугаарын (7 дах хэсэгт тусгасан) шаардлагыг заавал биелүүлэх шаардлагагүй.

D. ДОТООДЫН ЦАХИМ ШИЛЖҮҮЛЭГ

9. Дотоодын цахим шилжүүлгийн гүйлгээний мэдээлэлд хил дамнасан цахим шилжүүлгийн адил шилжүүлэгчийн мэдээллийг энэ мэдээллийг өөр арга замаар хүлээн авагч санхүүгийн байгууллага болон эрх бүхий байгууллагад хүргэдэггүй бол хавсаргах ёстой. Өөр аргаар хүргэдэг бол санхүүгийн байгууллага нь шилжүүлэгч эсвэл хүлээн авагчийн дансны дугаар эсвэл гүйлгээний тодруулгын онцгой дугаарыг хавсаргах хэрэгтэй (энэ мэдээлэл нь шилжүүлэгч болон хүлээн авагчийг мөшгихөд хангалттай бол).

10. Шилжүүлэгч санхүүгийн байгууллага нь мэдээллийг хүлээн авагчийн санхүүгийн байгууллага эсвэл эрх бүхий байгууллага хүсэлт гаргаснаас хойш ажлын 3 хоногийн дотор гаргаж өгнө. Хууль сахиулах байгууллагууд нь мөн дээрх мэдээллийг хугацаа алдалгүй авах эрхтэй байх нь зүйтэй.

E. ШИЛЖҮҮЛЭГЧ, ДАМЖУУЛАГЧ БОЛОН ХҮЛЭЭН АВАГЧ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

Шилжүүлэгч санхүүгийн байгууллага

11. Шилжүүлэгч санхүүгийн байгууллага нь цахим шилжүүлэг хийж байгаа шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаарх үнэн зөв мэдээллийг агуулж байгаад хяналт тавина.

12. Шилжүүлэгч санхүүгийн байгууллага нь босго дүнгээс доогуур дүнтэй хил дамнасан цахим шилжүүлгийн үед шилжүүлэгч болон хүлээн авагчийн нэр, дансны дугаар, дансны дугаар эсвэл гүйлгээний тодруулгын онцгой дугаарыг агуулж байгаад хяналт тавина.

13. Шилжүүлэгч санхүүгийн байгууллага нь Зөвлөмж 11-ийн дагуу хүлээн авагч болон шилжүүлэгчийн талаарх бүх мэдээллийг хадгалах шаардлагатай.

14. Хэрэв цахим шилжүүлэг нь дээр дурдсан шаардлагыг хангаагүй бол шилжүүлэгч санхүүгийн байгууллагад гүйлгээг хийхийг хориглоно.

Дамжуулагч санхүүгийн байгууллага

15. Хил дамнасан цахим шилжүүлгийн хувьд дамжуулагчийн үүрэг гүйцэтгэх санхүүгийн байгууллага нь гүйлгээтэй холбоотой шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар бүх мэдээлэл орсон эсэхэд хяналт тавина.

16. Хил дамнасан цахим шилжүүлэгт тусгасан шилжүүлэгч эсвэл хүлээн авагчийн талаарх шаардлагатай мэдээллийг холбогдох дотоодын цахим гүйлгээнд хадгалагдахаас сэргийлсэн техникийн хязгаарлалт байгаа тохиолдолд шилжүүлэгч санхүүгийн байгууллага эсвэл бусад дамжуулагч санхүүгийн байгууллагаас ирүүлсэн бүх мэдээллийг хүлээн авагч дамжуулагч санхүүгийн байгууллага хамгийн багадаа 5 жил хадгалах ёстой.

17. Дамжуулагч санхүүгийн байгууллага нь шилжүүлэгч эсвэл хүлээн авагчийн мэдээлэл дутуу гадаад цахим шилжүүлгийг илрүүлэх зохистой арга хэмжээ авна. Тус арга хэмжээ нь мэдээллийг шууд дамжуулан боловсруулах үе шаттай нийцсэн байх шаардлагатай.

18. Дамжуулагч санхүүгийн байгууллага нь дараах зүйлсийг тусгасан эрсдэлд суурилсан үр дүнтэй бодлого, журамтай байх шаардлагатай: (i) шилжүүлэгчийн эсвэл хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээлэл дутмаг цахим шилжүүлгийг хэзээ хийх, түдгэлзүүлэх эсвэл татгалзах; (ii) цаашид авах зохистой арга хэмжээ.

Хүлээн авагч санхүүгийн байгууллага

19. Хүлээн авагч санхүүгийн байгууллага нь шилжүүлэгч эсвэл хүлээн авагчийн талаар мэдээлэл дутуу хил дамнасан цахим шилжүүлгийг илрүүлэх зохистой арга хэмжээ авна. Боломжтой бол гүйлгээг бодит-цагт нь шалгах эсвэл хийгдэсний дараа шалгах арга хэмжээний тохирохыг авах шаардлагатай.

20. Шаардлага хангасан цахим шилжүүлгийн хувьд хүлээн авагч санхүүгийн байгууллага нь хүлээн авагчийн мэдээллийг баталгаажуулах шаардлагатай бөгөөд тухайн мэдээллийг Зөвлөмж 11-ийн дагуу хадгална.

21. Хүлээн авагч санхүүгийн байгууллага нь дараах зүйлсийг тусгасан эрсдэлд суурилсан үр дүнтэй бодлого, журамтай байх шаардлагатай: (i) шилжүүлэгчийн эсвэл хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээлэл дутуу цахим шилжүүлгийг хэзээ хийх, түдгэлзүүлэх эсвэл татгалзах; (ii) цаашид авах зохистой арга хэмжээ.

F. МӨНГӨ, ҮНЭ БҮХИЙ ЗҮЙЛ ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

22. Шууд болон агентаар дамжуулан үйл ажиллагаа эрхэлдэг МҮБЗШҮҮ-чид нь Зөвлөмж 16-д заасан холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаа явуулж байгаа улс оронд биелүүлэх шаардлагатай. Цахим мөнгөн шилжүүлгийн шилжүүлэгч болон хүлээн авагч аль аль талыг удирддаг МҮБЗШҮҮ нь:

(a) СГТ-г тайлагнах шаардлагатай эсэхийг тодорхойлоход шилжүүлэгч эсвэл хүлээн авагч талуудын бүх мэдээллийг харгалзаж үзэх шаардлагатай;

(b) Сэжигтэй цахим шилжүүлэгтэй холбоотой ямар ч улсад СГТ тайлагнаж, СМА-нд гүйлгээтэй холбоотой мэдээллийг гаргаж өгөх шаардлагатай:

Зөвлөмжид ашиглагдсан нэр томъёоны тайлбар толь

Үнэн зөв	Үнэн зөв эсэхийг шалгаж баталгаажуулсан мэдээллийг хэлнэ.
Багц шилжүүлэг	Санхүүгийн нэг байгууллага руу шилжүүлж буй олон тооны бие даасан гуйвуулгуудаас бүрдсэн багц гуйвуулгыг хэлнэ. Энэ шилжүүлэг нь эцсийн дүнд өөр өөр хүн рүү шилжүүлсэн/шилжүүлээгүй байж болно.
Хүлээн авагч	Шилжүүлэгчээс цахим шилжүүлгийг хүлээн авагч гэж тодорхойлсон хувь хүн, хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд
Хүлээн авагч санхүүгийн байгууллага	Шилжүүлэгч санхүүгийн байгууллагаас шууд буюу дамжуулагч санхүүгийн байгууллагаар дамжуулан цахим шилжүүлэг хүлээн авч, хүлээн авагч/харилцагчид мөнгө/хөрөнгийг олгодог санхүүгийн байгууллагыг хэлнэ.
Нэгтгэсэн төлбөр тооцоо	Нэгтгэсэн төлбөр тооцоо гэж захиалагч санхүүгийн байгууллага нь төлбөрийн зааварчилгааг (мессеж) мөнгөн гуйвуулгын хамт хүлээн авагч санхүүгийн байгууллага руу шууд илгээхийг хэлэх бөгөөд ингэхдээ төлбөр тооцооны роутингийн зааварчилгааг нэг буюу түүнээс дээш дамжуулагч санхүүгийн байгууллагаар дамжуулж болдог.
Хил дамнасан цахим шилжүүлэг	Гуйвуулгын шилжүүлэгч болон хүлээн авагч санхүүгийн байгууллагууд нь өөр өөр улс орнуудад байрлах үед цахим шилжүүлэг хийхийг хэлнэ. Энэ нэр томъёог хэлхээ холбоо бүхий цахим шилжүүлэг хийхэд оролцогч санхүүгийн байгууллагын аль нэг нь өөр улсад байрлаж байх үед ашигладаг.

Дотоод цахим шилжүүлэг	Шилжүүлэгч болон хүлээн авагч санхүүгийн байгууллагууд нь нэг улсад оршиж байхад хийх цахим мөнгөн гуйвуулгыг хэлнэ. Энэ нэр томъёогоор төлбөр тооцооны мэдээлэл шилжүүлэх систем нь өөр өөр улсад байрлахаас үл хамааран зөвхөн нэг улсын газар нутагт хийгдэж буй хэлхээ холбоо бүхий мөнгөн гуйвуулгыг мөн хэлнэ. Европын Эдийн Засгийн Бүсийн ⁴⁰ хил дотор хийгдэж буй хэлхээ холбоо бүхий мөнгөн гуйвуулгыг дотоодын цахим шилжүүлэг гэж үзнэ.
Дамжуулагч санхүүгийн байгууллага	Шилжүүлэгч, хүлээн авагч эсвэл бусад дамжуулагч санхүүгийн байгууллагын нэрийн өмнөөс хэлхээ холбоо бүхий үргэлжилсэн эсвэл нэгтгэсэн төлбөр тооцооны гүйлгээг хүлээн авч, шилжүүлдэг санхүүгийн байгууллага юм.
Шилжүүлэгч санхүүгийн байгууллага	Шилжүүлэгчийн нэрийн өмнөөс хүлээн авсаны дараа цахим мөнгөн шилжүүлгийг хийдэг санхүүгийн байгууллагыг хэлнэ.
Шилжүүлэгч	Тухайн данснаас мөнгө шилжүүлэхийг зөвшөөрч буй данс эзэмшигч эсвэл данс байхгүй үед цахим мөнгөн шилжүүлгийг хийлгэхээр шилжүүлэгч санхүүгийн байгууллагад захиалга үйлдэж буй хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
Хамаарах цахим шилжүүлэг	Зөвлөмж 16-ын Тайлбарын 5 дах хэсэгт дурдсан тохирох босго дүнгээс дээш дүнтэй гадаад цахим мөнгөн шилжүүлгийг хэлнэ.
Шаардлагатай	Шаардлагатай мэдээллийн бүх элементүүд нь бүрэн бүтэн байх нөхцөл байдлыг илэрхийлнэ. Дэд зүйл 6(a), 6(b), 6(c)-д шилжүүлэгч /originator/ шаардлагатай мэдээллийг дурдсан. Дэд зүйл 6(d), 6(e) хүлээн авагчийн шаардлагатай мэдээллийг дурдсан байгаа.
Сериал төлбөр тооцоо	Шилжүүлэгч санхүүгийн байгууллагын хүлээн авагч байгууллага руу шууд эсвэл нэг буюу түүнээс дээш дамжуулагч санхүүгийн байгууллагаар (жн: корреспондент банк) дамжуулан цахим шилжүүлэг болон төлбөрийн мэдээлэл нь дэс дараалал бүхий гинжин төлбөр тооцоогоор явагдахыг сериал төлбөр тооцоо гэнэ.
Төлбөр тооцоог шууд хийх	Цахим хэлбэрээр гар ажиллагаа шаардагдахгүйгээр төлбөр тооцооны гүйлгээг шууд хийхийг хэлнэ.

⁴⁰ Аливаа этгээд нь Зөвлөмж №16-ын хэрэгжилтийг тодорхойлох ажлын хүрээнд ФАТФ-ыг үндэсний юрисдикцээс илүү (supra-national) гэж тодорхойлуулж болно.

Гүйлгээний тодруулгын
онцгой дугаар

Энэ нь тухайн цахим шилжүүлэгт ашиглагддаг төлбөр тооцооны систем эсвэл мэдээллийн системийн протоколын дагуу төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгчийн тодорхойлсон үсэг, цифр эсвэл ялгах тэмдэгийн нийлбэр юм.

Цахим шилжүүлэг

Шилжүүлэгч эсвэл хүлээн авагч нь ижил хүн⁴¹ байхаас үл хамааран шилжүүлэгчийн нэрийн өмнөөс санхүүгийн байгууллагаар дамжуулан электрон хэлбэрээр хүлээн авагч санхүүгийн байгууллага руу буюу хүлээн авагч руу хийгдэж буй гүйлгээ.

⁴¹ Цахим шилжүүлгийн төлбөр тооцоог нийт дүнгийн цэвэр зөрүүгээр хийж болно. Энэ тайлбар хэсэгт шилжүүлэгч санхүүгийн байгууллагаас хүлээн авагч санхүүгийн байгууллагад, дундын дамжуулах санхүүгийн байгууллагыг оруулаад явуулах мэдээлэлд хүлээн авагчид хөрөнгө шилжүүлэх зааварчилгаа мэдээлэлд юуг тусгасан байхыг зааж өгч байгаа болно. Төлбөр тооцоог нийт дүнгийн цэвэр зөрүүгээр хийх асуудал 4(б) хэсэгт хамаарахгүй байж болно.

ЗӨВЛӨМЖ 17-ЫН ТАЙЛБАР

(ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ)

1. Энэхүү зөвлөмж нь аутсорсинг эсвэл агентлагийн харилцаанд хамаарахгүй. Гуравдагч этгээд нь Зөвлөмж 10, 11-ийн дагуу ХТМ, баримт материал хадгалах шаардлагыг биелүүлэх бөгөөд аливаа зохицуулалт, хянан шалгалтад хамрагдах ёстой. Ихэнх тохиолдолд гуравдагч этгээд нь харилцагчийн итгэмжлэгдсэн байгууллагатай байгуулсан харилцаанаас үл хамааран харилцагчтай бизнесийн харилцаа үүсгэсэн байдаг бөгөөд ХТМ арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ өөрийн зохицуулалтыг баримтална. Аутсорсинг авч буй этгээд нь төлөөлж буй санхүүгийн байгууллагын нэрийн өмнөөс ХТМ арга хэмжээ авах бөгөөд тухайн байгууллагын зохицуулалтын дагуу аутсорсинг хийдэг байгууллага нь аутсорсинг авч буй байгууллагад хяналт тавьдгаараа ялгаатай юм.

2. Зөвлөмж 17-ын хүрээнд *эрх бүхий байгууллага* гэдэгт (i) группын түвшинд хяналт хэрэгжүүлж, группын бодлогыг ойлгож ухамсарлаж буй төв байгууллага болон (ii) охин компаниуд, салбаруудыг хариуцаж буй бусад байгууллагуудыг ойлгоно.

3. *Гуравдагч этгээд* гэдэг нь Зөвлөмж 17-д заасан шаардлагыг хангах санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-г хэлнэ.

ЗӨВЛӨМЖ 18-ЫН ТАЙЛБАР

(ДОТООД ХЯНАЛТ БОЛОН ГАДААД ДАХЬ САЛБАР, ОХИН КОМПАНИ)

1. Санхүүгийн байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр нь дараахыг хамарсан байх шаардлагатай. Үүнд:

(a) Удирдлагын түвшинд хэрэгжилтийг хангах тогтолцоо, дотоод бодлого, журам, хяналтыг бий болгох, мөн шинэ ажилтан сонгон шалгаруулах өндөр стандарт бүхий шалгаруулж авах процедур,

(b) Ажилтныг давтан сургах хөтөлбөр,

(c) Системийг тестлэх хөндлөнгийн аудитын чиг үүрэг.

2. Хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, цар хүрээ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл болон бизнесийн цар хүрээг харгалзан үзсэн байх шаардлагатай.

3. Комплаенсын менежментийн тогтолцоонд комплаенсын ажилтанг удирдлагын түвшинд томилохтой холбоотой зохицуулалтыг тусгах.

4. Санхүүгийн группын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр нь санхүүгийн группын бүх салбар болон дийлэнх хувийг эзэмшдэг охин компаниудад хэрэгждэг байна. Энэ хөтөлбөр нь санхүүгийн группын бүх салбар болон дийлэнх хувийг эзэмшдэг охин компаниудын бизнест тохирсон бөгөөд дээрх (a)-(b) тусгасан арга хэмжээг хамарсан байна. Тус хөтөлбөрт ХТМ болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн удирдлагын шаардлагын дагуу мэдээлэл солилцох бодлого, журмыг багтаасан байна. МУТСТ зорилгын үүднээс группын түвшиний комплаенс, аудит болон МУТСТ чиг үүрэг бүхий албыг харилцагч, данс, гүйлгээний мэдээллээр хангаж байх шаардлагатай. Энэ мэдээлэлд хэвийн бус гүйлгээ болон үйл ажиллагааны талаарх анализ (хийдэг бол), СГТ болон холбогдох дагалдах мэдээлэл, СГТ мэдээлсэн тухай баримтыг хамруулна. Үүнтэй төстэйгөөр салбар болон охин компаниуд дээрх мэдээллийг эрсдэлийн удирдлагад холбоотой бол авах шаардлагатай. Мэдээллийг бусдад задруулахаас сэргийлэхийн тулд солилцсон мэдээллийн нууцлал болон ашиглалтын талаар зохих шаардлагыг тусгах нь зүйтэй. Улс орнууд мэдээлэл солилцох зорилго, хүрээг МУТСТ эрсдэлийн менежменттэй холбоотой байдал, мэдээллийн ач холбогдлоос хамааруулан тогтоож болно.

5. Үйл ажиллагаа явуулж буй гадаадын улс орны МУТСТ шаардлага нь өөрийн улсаас сул тохиолдолд салбар болон дийлэнх хувийг эзэмшдэг охин компаниуд нь тухайн улсын хууль тогтоомжийн зөвшөөрөгдсөн хэмжээнд өөрийн улсад тавигдах шаардлагыг хангах хэрэгтэй. Хэрэв үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын улсад дээр дурдсан шаардлагыг зохих хэмжээнд хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй тохиолдолд

санхүүгийн групп нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг удирдах нэмэлт арга хэмжээг авах шаардлагатай бөгөөд энэ талаар өөрийн улсын хяналт шалгалтын байгууллагад мэдэгдэнэ. Хэрэв нэмэлт арга хэмжээ нь хангалтгүй бол өөрийн нутаг дахь эрх бүхий байгууллага нь санхүүгийн группд нэмэлт хяналт тогтоох байдлаар хяналтын тогтолцоог өөрчлөх эсвэл тухайн улсад үйл ажиллагаа явуулахыг зогсоох талаар хүсэлт гаргаж болно.

ЗӨВЛӨМЖ 19-ЫН ТАЙЛБАР

(ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ УЛС ОРНУУД)

1. Санхүүгийн байгууллагын өргөтгөсөн таних үйл ажиллагаа гэж Зөвлөмж 10-ын тайлбарын 20 дах хэсэгт заасан болон эрсдэлийг бууруулахад ижил нөлөө үзүүлэх бусад арга хэмжээ байж болно.

2. Улс орнууд дараах хариу арга хэмжээнүүдийг авах боломжтой бөгөөд эрсдэлийг бууруулахад ижил нөлөө үзүүлэх бусад арга хэмжээ байж болно. Жишээлбэл:

(a) Санхүүгийн байгууллагаас өргөтгөсөн арга хэмжээний тодорхой заалтыг хэрэгжүүлэхийг шаардах.

(b) Санхүүгийн гүйлгээг тайлагнах өргөтгөсөн механизмтай болох эсвэл системтэй мэдээлдэг болгох.

(c) Эрсдэлтэй улс, орны санхүүгийн байгууллагын салбар, охин компани эсвэл төлөөлөгчийн газрыг байгуулахаас татгалзах эсвэл МУТСТ тогтолцоо сул улс орны санхүүгийн байгууллага гэдгийг анхааралдаа авах шаардлагатай.

(d) Санхүүгийн байгууллагад эрсдэлтэй улс, оронд салбар, төлөөлөгчийн газрыг байгуулахыг хориглох эсвэл МУТСТ тогтолцоо сул улс оронд салбар, төлөөлөгчийн газар нээсэн гэдгийн анхааралдаа авах шаардлагатай.

(e) Тухайн улс эсвэл тухайн улсын иргэнтэй холбоотой санхүүгийн гүйлгээ хийх эсвэл бизнесийн харилцааг хязгаарлах,

(f) Санхүүгийн байгууллагад эрсдэлтэй улс орны гуравдагч этгээдээр ХТМ үйл ажиллагааны аль нэг хэсгийг гүйцэтгүүлэхийг хориглох,

(g) Санхүүгийн байгууллагаас эрсдэлтэй улс орны санхүүгийн байгууллагатай тогтоосон корреспондент харилцааг нягтлах, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд цуцлахыг шаардах,

(h) Тухайн улс оронд үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллагын салбар, охин компаниудад тавих хөндлөнгийн аудитын шаардлага болон хяналт шалгалтыг нэмэгдүүлэхийг шаардах,

(i) Тухайн улс оронд үйл ажиллагаа явуулдаг салбар, охин компанитай санхүүгийн группд тавигдах хөндлөнгийн аудитын шаардлагыг нэмэгдүүлэх,

МУТСТ тогтолцоо сул улс орнуудын талаар санхүүгийн байгууллагуудад мэдээлэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 20-ЫН ТАЙЛБАР

(СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ)

1. Зөвлөмж 20-д тодорхойлсон гэмт үйлдэл гэдэгт тухайн улсын мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт тооцогддог бүх гэмт хэрэг эсвэл наад зах нь Зөвлөмж 3-т шаардсан суурь гэмт хэрэг гэж тодорхойлсон үйлдлүүд хамаарна.

2. Зөвлөмж 20-д тодорхойлсон терроризмыг санхүүжүүлэх гэдэгт тодорхой террорист үйлдэл(үүд)тэй холбогдох хамаарал байхгүй байсан ч террорист үйлдэл болон террорист байгууллага, хувь хүнийг санхүүжүүлэхийг ойлгоно.

3. Гүйлгээний дүнгээс үл хамааран хийгдсэн болон хийхийг завдсан бүх сэжигтэй гүйлгээг мэдээлэх шаардлагатай.

4. Сэжигтэй гүйлгээг мэдээлэх шаардлага нь шууд бөгөөд үл маргах үүрэг байна. Харин мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотойгоор эрүүгийн хэрэг үүсгэж магадгүй гэсэн шалтгаанаар буюу бусад шалтгаанаар (шууд бусаар мэдээлэх) сэжигтэй гүйлгээг мэдээлэх шууд бус буюу илт бус үүргийг хүлээн зөвшөөрөхгүй.

ЗӨВЛӨМЖ 22, 23-ЫН ТАЙЛБАР

(СББМҮҮ)

1. Гүйлгээ хийхэд тогтоосон босго дүн нь дараах байдалтай байна:

- Казино (Зөвлөмж 22-ын дагуу) –3,000 ам.доллар/евро
- Үнэт металл, үнэт чулуу арилжаалагчид (Зөвлөмж 22, 23-ын дагуу) 3,000 ам.доллар/еврогоос дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн үед.

Босго дүнг давсан санхүүгийн гүйлгээ гэдэгт гүйлгээг нэг эсвэл хоорондоо холбоотой хэд хэдэн гүйлгээгээр хийх нөхцөл байдлыг ойлгоно.

2. Санхүүгийн байгууллагад холбоотой Тайлбар хэсэг нь СББМҮҮ-д хэрэгжүүлж болох бол мөн хамаарна. Зөвлөмж 22, 23-ыг хэрэгжүүлэхийн тулд хуульч, нотариатч, нягтлан бодогч болон бусад санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийн үндсэн үйл ажиллагааг хамарсан хууль, тогтоомж байгаа бөгөөд хэрэгжүүлэх хариуцлагын арга хэмжээ авах боломжтой тохиолдолд зөвхөн тухайн салбарт зориулсан тусдаа хууль, тогтоомж гаргах шаардлагагүй.

ЗӨВЛӨМЖ 22-ЫН ТАЙЛБАР

(СББМҮҮ – ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ)

1. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйлчилгээ үзүүлэгчид нь эд хөрөнгө худалдан авагч болон борлуулагчдын хувьд Зөвлөмж 10-т заасан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

2. Зөвлөмж 10-ын дагуу казино нь 3,000 ам.доллар/евроос дээш дүнтэй санхүүгийн гүйлгээ хийсэн харилцагчийн хэн болохыг тогтоож, баталгаажуулах шаардлагатай. Казинод нэвтэрч орох үед харилцагчийг хэн гэдгийг тогтоох үйл ажиллагаа явуулж болох ч энэ нь хангалтгүй байж болох юм. Улс орнууд казино нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд авсан мэдээллийг хийсэн гүйлгээтэй холбож чадаж байгаа эсэхэд хяналт тавих шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 23-ЫН ТАЙЛБАР

(СББМҮҮ – БУСАД АРГА ХЭМЖЭЭ)

1. Хуульч, нотариатч, бусад хараат бус хуулийн мэргэжилтэн, хараат бус мэргэжилийн үйлчилгээ үзүүлж байгаа нягтлан бодогчид нь аливаа мэдээллийг мэргэжлийн нууцлал болон албан үүргийнхээ дагуу эдлэх эрхийн зохицуулалтын хүрээнд олж авсан бол уг холбогдох мэдээллийг сэжигтэй гүйлгээгээр заавал тайлагнах шаардлагагүй.

2. Улс орон бүр өөрсдөө хууль, эрх зүйн мэргэжлийн нууцлал болон албан үүргийн дагуу эдлэх эрхэд ямар асуудал хамаарахыг тогтооно. Энэ нь ерөнхийдөө өмгөөлөгч, нотариатч, бусад хараат бус мэргэжлийн үйлчилгээ эрхлэгч нар харилцагчаас болон тэдгээрээр дамжуулан (а) тухайн харилцагчийн хууль, эрх зүйн байдлыг тогтоох явцад; (б) тухайн харилцагчийг шүүх, захиргааны, арбитрайн болон зуучлалын үйл явцад төлөөлөх болон өмгөөлөх явцад олж авсан мэдээлэл ордог.

3. Хэрвээ улс орнууд нь хуульч, нотариатч, бусад хараат бус хуулийн мэргэжилтэн, нягтлан бодогч сэжигтэй гүйлгээний мэдээллийг өөрийгөө зохицуулах байгууллагад мэдэгдэхийг зөвшөөрдөг тохиолдолд уг байгууллага болон Санхүүгийн мэдээллийн албаны хооронд хамтын ажиллагааны хэлбэр тогтсон байх шаардлагатай.

4. Хуульч, нотариатч, бусад хараат бус хуулийн мэргэжилтэн, хараат бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа нягтлан бодогчид нь харилцагчийг хууль бус үйлдэл хийхээс зогсоох арга хэмжээ авах нь мэдээллийн нууцлалыг задруулсанд тооцогдохүй.

ЗӨВЛӨМЖ 24-ИЙН ТАЙЛБАР

(ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ БОЛОН ИЛ ТОД БАЙДАЛ)

1. Эрх бүхий байгууллагууд нь тухайн улсад үүсгэн байгуулагдсан⁴² компани болон хуулийн этгээд (эцсийн өмчлөгчийн мэдээлэл)⁴³ болон компанийн удирдлага, эцсийн өмчлөгчийн талаар үнэн зөв, тодорхой мэдээллийг цаг алдалгүй авах/ мэдээлэлд хандах боломжтой байх шаардлагатай. Улс орнууд дээр дурдсан шаардлагыг хэрэгжүүлэх механизмыг сонгох боломжтой бөгөөд эсвэл дор дурдсан шаардлагуудыг дагаж мөрдөх ёстой. Зарим улс орнууд дээрх шаардлагыг биелүүлэхийн тулд хосолсон механизм ашиглах тохиолдол ч байдаг.

2. Улс орнууд хуулийн этгээдийн ил тод байдлыг хангахын тулд дараах механизмтай байх шаардлагатай. Үүнд:

- (a) Тухайн улсын хуулийн этгээдийн онцлог, төрөл, хэлбэрийг тодорхойлж, тайлбарлах,
- (b) (i) хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, (ii) хуулийн этгээдийн талаар анхан шатны болон эцсийн өмчлөгчийн талаар мэдээллийг олж авах, бүртгэх үйл явцыг тодорхойлох,
- (c) Дээр дурдсан мэдээллийг олон нийтэд ил тод байлгах,
- (d) Тухайн улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн төрлөөс хамаарч үүсч болох мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх.

А. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3. Компанийн эцсийн өмчлөгчийг тодорхойлохын тулд эрх бүхий байгууллага нь компанийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, хууль ёсны өмчлөл зэрэг үндсэн мэдээллийг олж авах шаардлагатай. Үүнд компанийн хэлбэр болон хувь эзэмшигч, захирлуудын бүрэн эрхийн талаарх мэдээллийг мөн хамааруулна.

4. Тухайн улсад үүсгэн байгуулагдсан бүх компани нь компанийн бүртгэлд⁴⁴ бүртгүүлсэн байх шаардлагатай. Эцсийн өмчлөгчийн (Б хэсгийг үзнэ үү) талаар

⁴² Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах гэдэгт компанийг байгуулах болон бусад механизмыг хамруулж ойлгоно.

⁴³ Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаар мэдээлэл гэдэг нь Зөвлөмж 10-ын 5(b)(i) хэсэгт дурдсаныг хэлнэ. Хяналтын хувь гэдэг нь Зөвлөмж 10-ын 5(b)(i) хэсэгт дурдсанаар эзэмшиж буй босго хувиас хамаарч болно. Жнь: Компанийн тодорхой хувиас дээш хувийг эзэмшиж байгаа хүн (Жнь 25%).

⁴⁴ “Компанийн бүртгэл” гэж тухайн улсад үүсгэн байгуулсан, лицензтэй компанийг бүртгэх бүртгэл эсвэл эрх бүхий үүсгэн байгуулах байгууллагыг хэлнэ. Энэ тухайн компани өөрөө хадгалж байгаа мэдээллийг хэлээгүй болно.

мэдээллийг ямар ч механизмаар олж авч, бүртгэж байсан ч гэсэн тухайн компанид өөрөө олж авах, эсвэл хадгалах⁴⁵ шаардлагатай үндсэн мэдээлэл гэж байдаг. Үүнд:

(a) Компанийн нэр, үүсгэн байгуулсныг нотлох баримт, хуулийн этгээдийн төрөл болон статус, бүртгэгдсэн хаяг, үндсэн үйл ажиллагааг зохицуулах эрх (дүрэм, гэрээ), удирдлагуудын жагсаалт,

(b) Хувьцаа эзэмшигч, гишүүдийн нэр болон тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны хэмжээ⁴⁶ зэргийн талаар бүртгэл, хувьцааны төрөл (саналын эрхтэй эсэх).

5. Компанийн бүртгэлд 4(a) хэсэгт дурдсан бүх үндсэн мэдээллийг хадгалж байх шаардлагатай.

6. Компани нь 4(b) хэсэгт дурдсан мэдээллийг тухайн улс дахь бүртгэлтэй хаяг эсвэл компанийн бүртгэлд бүртгэгдсэн өөр байршилд хадгалах ёстой. Хэрвээ компани эсвэл компанийн бүртгэл нь эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг тухайн улсад хадгалдаг бол хувьцаа эзэмшигчдийн бүртгэл энэ мэдээллийг компани шаардсан үед цаг алдалгүй гаргаж өгч чадах бол тухайн улсад хадгалахгүй байж болно.

В. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

7. Улс орнууд дараахь шаардлагыг биелүүлэхийг шаардана: (a) компаниуд эцсийн өмчлөгчийн мэдээллийг олж эрхтэй байна, энэ мэдээлэл нь тухайн улсад, тодорхой байршилд хадгална, эсвэл (b) эрх бүхий байгууллага эцсийн өмчлөгчийг цаг алдалгүй тогтоох боломжийг олгосон механизмууд байна.

8. Улс орнууд 7 дах хэсэгт заасан шаардлагыг хангахын тулд дор дурдсан механизмуудаас ашиглах нь зүйтэй. Үүнд:

(a) Компани эсвэл компанийн бүртгэлийг компанийн эцсийн өмчлөгчийн талаарх сүүлийн үеийн мэдээллийг олж авах, хадгалахыг шаардах,

(b) Компаниас эцсийн өмчлөгчийн талаар сүүлийн үеийн мэдээллийг олж авах, хадгалах зохистой⁴⁷ арга хэмжээ авахыг шаардах,

⁴⁵ Энэ мэдээллийг компани өөрөө эсвэл компанийн хариуцлага дор гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж болно.

⁴⁶ Бүртгэгдсэн бүх хувьцааны нэрлэсэн хувьцаа эзэмжигчид хамааралтай.

⁴⁷ Боломжит арга хэмжээ нь эрсдэлийн түвшин, компанийн эзэмшлийн бүтцийн төвөгтэй байдал, хяналт тавьж байгаа өмчлөгчийн төрөлтэй хамааралтай байна.

(с) Байгаа мэдээллийг ашиглах: (i) Зөвлөмж 10, 22-ын⁴⁸ дагуу санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-дийн олж авсан мэдээлэл, (ii) эрх бүхий байгууллага (компанийн бүртгэл, татварын байгууллага эсвэл санхүүгийн эсвэл бусад хянан шалгах байгууллага)-ын олж авсан компанийн хууль ёсны болон эцсийн өмчлөгчийн талаар мэдээлэл, (iii) А хэсэгт дурдсан компанийн олж авсан мэдээлэл, (iv) хөрөнгийн биржид бүртгэлтэй эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээдэг (хөрөнгийн биржийн журам, хууль эсвэл бусад биелүүлэх шаардлагатай журмын дагуу) хувьцаат компани.

9. Дээр дурдсан аль ч механизмыг ашигласан, эцсийн өмчлөгчийг тодорхойлоход компани нь эрх бүхий байгууллагатай бүрэн хэмжээгээр хамтран ажиллах шаардлагатай. Үүний тулд:

(а) Компани⁴⁹ нь тухайн улсад оршин суудаг нэг эсвэл түүнээс дээш хувь хүмүүсийг эрх бүхий байгууллагад анхан шатны болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг өгөх, хариуцлага хүлээх мөн холбогдох байгууллагад цаашид дэмжлэг үзүүлэх эрхтэйгээр томилсон байх,

(b) Компани нь тухайн улсын СББМҮҮ-ийг эрх бүхий байгууллагад анхан шатны болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг өгөх, хариуцлага хүлээх мөн холбогдох байгууллагад цаашид дэмжлэг үзүүлэх эрхтэйгээр томилсон байх,

(с) Хамтын ажиллагааг үр дүнтэй хангах боломжтой тухайн улсын тодорхойлсон бусад арга хэмжээ.

10. Дээр дурдсан хувь хүн, этгээд, компани өөрөө (эсвэл компанийг татан буулгах үйл ажиллагаанд оролцож буй удирлага, комисс, бусад хүмүүс) болон бусад этгээд нь оршин тогтнохоо больсон эсвэл татан буугдсан өдрөөс хойш хамгийн багадаа 5 жил, эсвэл мэргэжлийн зуучлагч эсвэл санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч байхаа больсон өдрөөс хойш 5 жил тус мэдээллийг хадгалах шаардлагатай.

С. ҮНЭН ЗӨВ МЭДЭЭЛЭЛД ЦАГ ТУХАЙД НЬ ХАНДАХ

11. Улс орнууд компанийн бүртгэлд хадгалагдаж байгаа анхан шатны мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналт тавьж, цаг тухайд нь шинэчилж байх механизмтай байна. Мөн 7 дах хэсэгт дурдсан боломжит мэдээлэл нь үнэн зөв, сүүлийн үеийн мэдээлэл байгаа эсэхэд хяналт тавьж, аливаа өөрчлөлт орсон тохиолдолд тодорхой хугацаанд шинэчилж байх шаардлагатай.

⁴⁸ Улс орнууд компанийг өөрийн улсын санхүүгийн байгууллагад данстай эсэх талаар цаг алдалгүй тодорхойлж чадах шаардлагатай.

⁴⁹ Компанийн удирдах зөвлөлийн гишүүд болон дээд удирдлага тусгай зөвшөөрөл шаардахгүй байж болно.

12. Хууль сахиулах эрх бүхий байгууллагууд холбогдох байгууллагаас компанийн анхан шатны болон эцсийн өмчлөгчийн талаар мэдээллийг цаг алдалгүй авах эрхтэй байх шаардлагатай.

13. Улс орнууд компанийн бүртгэл дэх нийтэд нээлттэй мэдээлэлд санхүүгийн байгууллага, СББМҮҮ болон бусад эрх бүхий байгууллагыг цаг алдалгүй нэвтрэх бололцоогоор хангах шаардлагатай бөгөөд хамгийн багадаа 4(а) хэсэгт заасан мэдээлэлд нэвтрэдэг байх хэрэгтэй. Мөн 4(б) хэсэгт заасан мэдээлэлд санхүүгийн байгууллага, СББМҮҮ-ийг нэвтрэх боломжийг хангах хэрэгтэй.

Д. ИЛ ТОД БАЙДАЛД ТУЛГАРЧ БУЙ СААД, БЭРХШЭЭЛ

14. Төлөөлөгчийн хувьцаа (bearer share) эсвэл түүнийг худалдан авах эрхийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх нөхцлийг хангах үүднээс дараах арга хэрэгслийг ашиглах шаардлагатай. Үүнд: (а) төлөөлөгчийн хувьцаа эсвэл түүнийг худалдан авах эрх гаргахыг хориглох, (b) төлөөлөгчийн хувьцаа эсвэл түүнийг худалдан авах эрхийг бүртгүүлсэн хувьцаа, хувьцаа худалдан авах эрхэд хөрвүүлэх (жн.: dematerialization замаар), (c) төлөөлөгчийн хувьцаа эсвэл түүнийг худалдан авах эрхийг зохицуулалттай санхүүгийн байгууллага болон мэргэжлийн зуучлагчийн эзэмшилд байхыг шаардах замаар тэдгээрийн шилжүүлгийг хязгаарлах, (d) хувьцааны хяналтын багцыг эзэмшигч нь компанид мэдэгдэх болон компани тэдгээр этгээдийн мэдээллийг хадгалдаг байхыг шаардах.

15. Хуулийн этгээд нэрлэсэн хувьцаа, нэрлэсэн захирлуудтай байх боломжтой улс орнуудын хувьд тэдгээрийг урвуулан ашиглахаас сэргийлсэн дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай: (а) нэрлэсэн хувьцаа эзэмшигч, захирлуудад тэдгээрийг нэр дэвшүүлсэн этгээдийн талаарх мэдээллийг компанид болон бүртгэлийн байгууллагад гаргаж өгөхийг шаардах бөгөөд энэхүү мэдээлэл нь бүртгэлд байх шаардлагатай, (b) компанийн бүртгэлд нэрлэсэн гэх статусыг тусгах, нэр дэвшүүлэгчийг тодорхойлох мэдээллийг хадгалахын тулд нэрлэсэн хувьцаа эзэмшигч болон захирлууд бүртгүүлдэг байх, тэрхүү мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр гаргаж өгөхөд бэлэн байлгахыг шаардах.

Е. БУСАД ХУУЛИЙН ЭТГЭЭД

16. Сан, Ансталт, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл – Улс орнууд тэдгээрийн ялгаатай хэлбэр, бүтцийг анхаарч компанид тавигддаг ижил шалгууруудын тавих шаардлагатай.

17. Бусад хэлбэрийн хуулийн этгээдийн хувьд улс орнууд тодорхой хэмжээний ил тод байдлыг хангах зорилгоор бусад хэлбэрийн хуулийн этгээд, тэдгээрийн ялгаатай

бүтэц болон хэлбэр тус бүрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тооцож үзэх шаардлагатай. Хамгийн багадаа бүх хуулийн этгээд нь ижил төрлийн үнэн зөв, сүүлийн үеийн анхан шатны мэдээллийг хадгалан, эрх бүхий байгууллагуудад мэдээллийг цаг тухайд нь авах боломжийг олгодог байх шаардлагатай. Улс орнууд хуулийн этгээдэд хамаарах МУТС эрсдэлийг хянах шаардлагатай бөгөөд эрсдэлийн түвшинг үндэслэн эрх бүхий байгууллагууд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаар зохих, үнэн зөв, сүүлийн үеийн мэдээлэлд цаг алдалгүй хандах боломжийг бий болгох шаардлагатай.

F. ХАРИУЦЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

18. Тайлбар хэсэгт дурдсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх үр дүнтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцсэн, дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэхүйц хариуцлага хүлээлгэдэг байх шаардлагатай.

G. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

19. Улс орнууд нь гадаад хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөмж 37 ба 40-д тусгасны дагуу анхан шатны болон эцсийн өмчлөгчийн талаар дараах мэдээллийг агуулсан мэдээллийг хугацаа алдахгүй гаргаж өгнө: (а) компанийн бүртгэлд байгаа анхан шатны мэдээллийг гадаадын эрх бүхий байгууллагад гаргаж өгөх боломжоор хангах, (b) хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг солилцох, (c) гадаадын эрх бүхий байгууллагын нэрийн өмнөөс эцсийн өмчлөгчийн мэдээллийг олж авахын тулд дотоодын хууль тогтоомжийн эрх хэмжээг ашиглах. Улс орнууд нь анхан шатны болон эцсийн өмчлөгчийн мэдээллийг олж авах хүсэлтийн хариу, гадаадад оршин суугаа эцсийн өмчлөгчийн байршлыг тогтоох талаар бусад улс орнуудын хүссэн хүсэлтийн дагуу үзүүлж байгаа туслалцааны чанарыг хянаж байх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 25-ЫН ТАЙЛБАР

(ЭРХ ЗҮЙН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БОЛОН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ)

1. Улс орнууд экспресс трастын гэрээний дагуу трастий нь хуулийн дагуу трастын эцсийн өмчлөгчийн тухай үнэн, зөв мэдээлийг авч хадгалах үүрэгтэй. Энэ мэдээлэл нь сетлор, трастий, трастын хамгаалагч (байгаа бол), үр шим хүртэгч эсвэл үр шим хүртэгчдийн бүлэг болон трастад эцсийн үр нөлөө бүхий удирдлагыг хэрэгжүүлж буй бусад хувь этгээдийг хамруулна. Мөн хөрөнгө оруулалтын зөвлөгч, менежер, нягтлан бодогчид, татварын зөвлөгч зэрэг трастад үйлчилгээ үзүүлэгч бусад зохицуулалттай төлөөлөгчийн талаарх анхан шатны мэдээллийг тухайн улсын хуулиар зохицуулагддаг трастий нь хадгалдаг байх шаардлагатай.

2. Тогтоосон босгоос дээш үнийн дүн бүхий тохиолдлын гүйлгээ болон бизнесийн харилцаа тогтоохдоо трастий нь өөрийн статусыг санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-д мэдэгдэж байх арга хэмжээг авах шаардлагатай. Трастий нь трасттай холбоотой⁵⁰ аливаа мэдээллийг эрх бүхий байгууллагад дамжуулах эсвэл эцсийн өмчлөгчийн болон бизнес харилцааны нөхцлийн дагуу эзэмшин захирч байгаа трастын хөрөнгийн талаарх мэдээллийг бизнесийн байгууллага СББМҮҮ-ийн хүсэлтээр дамжуулахыг хууль болон албадлагын арга хэмжээгээр хязгаарлах ёсгүй.

3. Улс орнууд нь холбогдох байгууллага, хувь хүн, хуулийн этгээдийг харилцаа холбоотой ажилладаг бүх трасттай холбоотой мэдээллийг авч байхыг шаардах хэрэгтэй. Трастий, сетлор, трастын хөрөнгийн талаар дараах байж болох эх үүсвэрээс мэдээлэл авах боломжтой. Үүнд:

- (a) Газар, хөрөнгө, машин, хувьцаа болон бусад эд хөрөнгийн бүртгэл эсвэл бусад бүртгэл (Траст болон трастын хөрөнгийн нэгдсэн бүртгэл),
- (b) Траст болон трастийтай холбогдох мэдээллийг хадгалах бусад эрх бүхий байгууллага (трасттай холбоотой орлого, хөрөнгийн мэдээллийг татварын байгууллагаас авч болно г.м),
- (c) Бусад агент болон трастад үйлчилгээ үзүүлэгч хөрөнгө оруулалтын зөвлөх, менежер, хуульч эсвэл траст, компанийн үйлчилгээ үзүүлэгчид.

4. Эрх бүхий байгууллага, ялангуяа хууль сахиулах байгууллагад (a) эцсийн өмчлөгчийн мэдээлэл, (b) трастий оршин байгаа газрын мэдээлэл, (c) санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарын хадгалж удирддаг аливаа хөрөнгийг эзэмшиж байгаа

⁵⁰ Эрх бүхий дотоодын байгууллага эсвэл бусад улсын эрх бүхий байгууллага холбогдох эрх зүйн туслалцааны хүсэлтийн дагуу

бизнес харилцаатай трастий, тохиолдлын чанартай гүйлгээ хийсэн бол цаг тухайд нь мэдээлэл гаргуулж авах бүрэн эрхийг олгосон байх шаардлагатай.

5. Мэргэжлийн трастий нь 1 дэх хэсэгт дурдсан мэдээллийг траст дууссанаас хойш хамгийн багадаа 5 жил хадгална. Мөн 3 дах хэсэгт дурдсан мэргэжлийн бус трастий болон бусад байгууллага, хувь хүн, хуулийн этгээд нь холбогдох мэдээллийг хамгийн багадаа 5 жил хадгалах шаардлагатай.

6. Улс орнууд нь 1 дэх хэсэг заасны дагуу авсан мэдээлэл нь үнэн зөв, цаг тухайд нь шинэчилэгдэж байгаа эсэхэд хяналт тавих шаардлагатай бөгөөд өөрчлөлт орсон даруйд тодорхой хугацаанд шинэчилэх хэрэгтэй.

7. Улс орнууд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-дэд Зөвлөмж 10 болон 22-т заасныг хэрэгжүүлэхэд 3 дах хэсэгт заасан трасттай холбоотой бусад байгууллага, хувь хүн, хуулийн этгээдийн эзэмшиж буй аливаа мэдээллийг авах боломжийг судлана.

8. Энэхүү зөвлөмжийн хүрээнд, улс орнуудыг трастыг хуулиар хүлээн зөвшөөрсөн байхыг шаардахгүй. Нийтлэг болон жишиг эрх зүйгээр ижилхэн нөлөөлөл агуулсан зохистой үүрэг трастад оногддог бол 1, 2, 6 дах хэсэгт заасан шалгуурыг хуульд тусгах шаардлагагүй.

Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд

9. Ижил төстэй бүтэц, чиг үүрэг бүхий эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн тухайд ижил түвшиний ил тод байдлыг хангахын тулд трастад тавигдах шаардлагатай ижил төрлийн арга хэмжээг авдаг байх нь зүйтэй. Наад зах нь улс орнууд дээр дурдсан трасттай холбоотой ижил төстэй мэдээллийг бүртгэх, үнэн зөв, цаг тухайд нь шинэчилэгдэж байхаар байлгах, тус мэдээлэлд эрх бүхий байгууллагууд цаг тухайд нь хандах боломжоор хангах ёстой.

Олон улсын хамтын ажиллагаа

10. Улс орнууд нь гадаад хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөмж 37 ба 40-д тусгасны дагуу траст болон бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн эцсийн өмчлөгчийн дараах мэдээллийг агуулсан мэдээллийг хугацаа алдахгүй гаргаж өгнө: (a) бүртгэгч эсвэл дотоодын бусад эрх бүхий байгууллагын мэдэлд байгаа бүх мэдээллийг гадаадын эрх бүхий байгууллагад гаргаж өгөх боломжоор хангах, (b) траст болон бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдтэй холбоотой дотоод мэдээллийг солилцох, (c) гадаадын эрх бүхий байгууллагын нэрийн өмнөөс эцсийн өмчлөгчийн мэдээллийг олж авахын тулд дотоодын хууль тогтоомжийн эрх хэмжээг ашиглах.

Хариуцлагын арга хэмжээ

11. Улс орнууд энэхүү тайлбар хэсэгт заасан шаардлагыг дагаж мөрдөх тодорхой үүрэг хариуцлагатай байх ёстой. Мөн трастийд нь 1, 2, 6, 5(хэрэв боломжтой бол)-д заасан үүргээ биелүүлээгүй⁵¹ тохиолдолд хуулийн дагуу эрүүгийн, иргэний эсхүл захиргааны үр дүнтэй, үйлдсэн зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц хариуцлагын арга хэмжээг авдаг байх шаардлагатай. Трасттай холбоотой 1, 5 дах хэсэгт дурдсан шалгуурын дагуу эрх бүхий байгууллагад мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй бол үйлдэлтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн эрүүгийн, иргэний, захиргааны шийтгэлийн арга хэмжээ авдаг байхыг улс орнуудаас шаардана.

⁵¹ Зөвлөмжийн бусад хэсэгт тусгасан үүргээ биелүүлээгүй бол гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн үр дүнтэй арга хэмжээ авахыг хөндөхгүй.

ЗӨВЛӨМЖ 26-ЫН ТАЙЛБАР

(САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ)

Эрсдэлд суурилсан хяналт шалгалт

1. Эрсдэлд суурилсан хяналт, шалгалт нь: (а) хянан шалгагчийн эрсдэлийн ойлголтын дагуу байгаа нөөцөө МУТСТ чиглэлээр хийх хяналт шалгалтад хуваарилах ерөнхий үйл явц; (b) МУТСТ чиглэлээр эрсдэлд суурилсан аргачлалыг ашигладаг байгууллагуудыг хянан шалгах тусгай үйл явц.

2. Санхүүгийн байгууллагуулын МУТСТ тогтолцоо, хяналтыг шалгахдаа эрсдэлд суурилсан аргачлалыг ашиглах нь хяналт тавих байгууллагуудад нөөцөө эрсдэл өндөртэй хэсэгт төвлөрүүлэх боломжийг олгодог. Үүний үр дүнд хяналт тавих байгууллагуудад өөрсдийн нөөцөө үр өгөөжтэй ашиглах боломж олгоно. Энэ нь хянан шалгагчид: (а) улсынхаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаар тодорхой ойлголттой байх, (b) шалгагдаж буй байгууллагын харилцагч, бүтээгдэхүүн, харилцагчтай холбоотой дотоодын болон олон улсын эрсдэлийн талаар болон санхүүгийн байгууллага, группын комплаенсын үйл ажиллагааны чанар зэрэг мэдээллийг зайнаас болон газар дээрээс нь авах боломжтой байх шаардлагатай. Санхүүгийн байгууллага, группын МУТСТ-тэй холбоотой газар дээрх болон зайнаас тавих хяналт шалгалтын давтамж, хамрах хүрээг хянан шалгагч нь улсынхаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй уялдуулсан санхүүгийн байгууллага, группын МУТСТ үнэлгээ, эрсдэлийн төлөв, эрсдэл, бодлого, дотоод хяналт болон дүрэм журамд суурилж хийнэ.

3. Хянан шалгагч нь санхүүгийн байгууллага, группын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн төлөв, хэрэгжүүлэхгүй байх эрсдэлийн үнэлгээг тогтмол эсвэл хяналт шалгалтын тогтсон практикийн дагуу удирдлагын, үйл ажиллагааны түвшинд томоохон өөрчлөлт, ахиц дэвшил гарсан даруйд дахин тухайн улсын газар дээрх хянан шалгалт хийдэг практикийн дагуу хийнэ. Үнэлгээ нь өөрчлөгддөггүй нэг хэвийн байж болохгүй бөгөөд нөхцөл байдал, заналхийлэлийн өөрчлөлтөөс хамааран өөрчлөгдөж байх шаардлагатай.

4. Санхүүгийн байгууллага/группын МУТСТ эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ санхүүгийн байгууллага/группд эрсдэлд суурилсан аргачлалын хүрээнд өөрийн сонголтоор шийдэх зэргийг харгалзан үзэх бөгөөд эрсдэлийн үнэлгээ хийхдээ энэ өөрийн сонголтоор шийдэхэд нөлөөлсөн дотоод бодлого, хяналтын арга хэрэгсэл, процедур болон хэрэгжилтийн тоймыг хамруулсан байвал зохино.

5. Дээрх зарчмыг бүх санхүүгийн байгууллага/группд хэрэгжүүлэх нь зүйтэй. Үр дүнтэй МУТСТ хяналт шалгалт хийхийн тулд хянан шалгагчид нь санхүүгийн

байгууллага/группын онцлог шинж, ялангуяа санхүүгийн байгууллагын ялгаатай байдал, тоо болон бусад ЭСА зөвшөөрсөн өөрийн сонголтоор шийдэх зэргийг харгалзаж үзэх шаардлагатай.

Хянан шалгагчдад зориулсан нөөц

6. Улс орнууд санхүүгийн хянан шалгагчийг шаардлагатай санхүүгийн, хүний болон техникийн нөөцөөр хангах ёстой. Эдгээр хянан шалгагчид нь хөндлөнгийн оролцоо, нөлөөллөөс ангид, үйл ажиллагааны хувьд бие даасан, хараат бус байх шаардлагатай. Мөн улс орнууд нь эдгээр эрх бүхий байгууллагын ажилтнууд нь мэргэжлийн өндөр ур чадвартай, ялангуяа нууцлалын стандартыг чандлан сахиж, үнэнч шударга, зохих ур чадвартай байх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

ЗӨВЛӨМЖ 28-ЫН ТАЙЛБАР

(СББМҮҮ-ИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ)

1. Эрсдэлд суурилсан хяналт, шалгалт нь: (а) хянан шалгагч болон ӨЗБ нь эрсдэлийн ойлголтын дагуу байгаа нөөцөө МУТСТ чиглэлээр хийх хяналт шалгалтад хуваарилах ерөнхий үйл явц; (b) МУТСТ чиглэлээр эрсдэлд суурилсан аргачлалыг ашигладаг СББМҮҮ-ийг хянан шалгах, хянах тусгай үйл явц.

2. Хянан шалгагч болон ӨЗБ нь өөрсдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголт дээр үндэслэн СББМҮҮ-дэд хийх хяналт шалгалтын давтамж болон хүрээг тодорхойлох шаардлагатай бөгөөд үр дүнтэй МУТСТ хяналт шалгалт хийхийн тулд СББМҮҮ-дийн ялгаатай байдал, тоо зэргийг харгалзаж үзэх шаардлагатай. Энэ нь (а) улс орны одоогийн болон (b) СББМҮҮ-ийн төрөл, түүний харилцагч, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой МУТС эрсдэлийн талаар маш тодорхой ойлголттой байхыг шаардана.

3. СББМҮҮ-дийн МУТСТ дотоод хяналтын хөтөлбөр, бодлого, журмын зохистой байдлыг үнэлж буй хянан шалгагч болон ӨЗБ нь СББМҮҮ-дийн МУТС эрсдэлийн төлөв болон бусад ЭСА зөвшөөрсөн эсвэл өөрийн сонголтоор шийдэх зэргийг харгалзаж үзэх шаардлагатай.

4. Хянан шалгагч болон ӨЗБ нь үйл ажиллагаагаа гүйцэтгэх хангалттай эрх мэдэл (хянах болон арга хэмжээ авах орно) санхүүгийн, хүний болон техникийн нөөцөөр хангагдах ёстой. Хэрэгжилтийн биелэлтийг хянаж шалгах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэх хангалттай эрх мэдэл, санхүүгийн, хүний болон техникийн нөөцтэй байх шаардлагатай. Мөн улс орнууд нь эдгээр эрх бүхий байгууллагын ажилтнууд нь мэргэжлийн өндөр ур чадвартай, ялангуяа нууцлалын стандартыг чандлан сахиж, үнэнч шударга, зохих ур чадвартай байх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

ЗӨВЛӨМЖ 29-ЫН ТАЙЛБАР

(САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА)

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Энэхүү тайлбар хэсэгт санхүүгийн мэдээллийн алба (СМА)-ны зорилго, чиг үүргийн талаар болон стандартад тусгагдсан шаардлагын талаар тодруулах болно. СМА нь улс, орнын МУТСТ үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэгч бөгөөд бусад эрх бүхий байгууллагын ажилд дэмжлэг үзүүлдэг байгууллага юм. Зөвлөмж 29-г тусгасан заалтууд нь улс орны сонгосон СМА-ны төрлөөс үл хамааран бүгдэд нь нийтлэг байдлаар үйлчилнэ.

В. ЧИГ ҮҮРЭГ

(а) Хүлээн авах

2. СМА нь мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс ирүүлсэн мэдээллийг хүлээн авах төв байгууллага юм. Зөвлөмж 20, 23-ын шаардлагын дагуу хамгийн багадаа СГТ хүлээн авах бөгөөд үндэсний хууль тогтоомжид (жишээ нь: бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, цахим шилжүүлгийн тайлан, бусад босго дүнгээс хамаарсан мэдүүлэг/мэдээлэл) заасан бусад мэдээллийг хүлээж авах шаардлагатай.

(б) Дүн шинжилгээ

3. СМА-ны дүн шинжилгээ нь СМА-ны хүлээн авсан болон байгаа мэдээллийг баяжуулах ёстой. Бүх ирсэн мэдээллийг анхаарч үзэх шаардлагатай боловч дүн шинжилгээ нь ирүүлсэн мэдээллийн төрөл, хэмжээ болон мэдээллийг шилжүүлсний дараа ашиглах байдлаас хамаарч хүлээн авсан мэдээлэл тус бүр дээр эсвэл сонгогдсон тодорхой мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлж болно. СМА нь мэдээллийг илүү үр дүнтэй боловсруулах, холбогдох холбоосыг тогтоох дүн шинжилгээний програм хангамжийг ашиглахыг дэмжих хэрэгтэй. Гэхдээ эдгээр хэрэгсэл нь хүний хийх дүгнэлтийг бүрэн орлож чадахгүй. СМА нь дараах төрлийн дүн шинжилгээ хийдэг байх шаардлагатай. Үүнд:

- Өөрт байгаа болон авч болох мэдээллийг ашиглан тодорхой этгээдүүд (ж.н: хувь хүн, хөрөнгө, гэмт хэргийн сүлжээ, холбоос)-ийг тодорхойлох, тэдгээрийн явуулж байгаа үйл ажиллагаа, хийж байгаа гүйлгээний түүхийг тодорхойлох, тухайн этгээд болон холбоотой байж болох гэмт хэргийн орлого, мөнгө угаах, холбоотой суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой эсэхийг тодорхойлох “Үйл ажиллагааны дүн шинжилгээ” хийнэ;
- Өөрт байгаа болон бусад эрх бүхий байгууллагуудаас авч болох мэдээ мэдээллийг ашиглан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиг хандлага, төлөв байдлыг тодорхойлох “Стратегийн дүн шинжилгээ”-г хийнэ. Энэ мэдээллийг цааш

нь МУТС аюул заналхийлэл, эмзэг сул талыг илрүүлэх зорилгоор СМА болон бусад төрийн байгууллагууд ашиглана. Стратегийн дүн шинжилгээ нь СМА-ны болон илүү өргөн хүрээнд МУТСТ тогтолцоон дах бусад байгууллагуудад бодлого, зорилгыг тодорхойлоход ашиглагдаж болно.

(с) Мэдээлэл шилжүүлэх

4. СМА нь мэдээлэл, дүн шинжилгээний үр дүнг хүсэлтийн дагуу болон өөрийн санаачлагаар холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх боломжтой байх шаардлагатай. Тухайн мэдээллийг шилжүүлэхдээ зориулалтын, нууцлалын шаардлага хангасан найдвартай, хамгаалагдсан сувгуудыг ашиглах хэрэгтэй.

■ **СМА-наас өөрийн санаачлагаар шилжүүлэх:** СМА нь мөнгө угаах, суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэх үндэслэлтэй гэж үзвэл эрх бүхий байгууллагуудад мэдээлэл болон дүн шинжилгээний үр дүнг шилжүүлж болно. СМА-ны шилжүүлэх мэдээлэл нь хүлээн авагч байгууллагуудыг холбогдох хэрэг/мэдээлэлд анхаарлаа хандуулах боломжийг олгох, шинжилгээнд суурилсан сонголт байх хэрэгтэй.

■ **Хүсэлтийн дагуу шилжүүлэх:** СМА нь Зөвлөмж 31-ийн дагуу эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтэд хариу өгөх боломжтой байх шаардлагатай. СМА нь эрх бүхий байгууллагаас хүсэлт ирүүлмэгц дүн шинжилгээ хийх, хүсэлт гаргасан байгууллагад мэдээлэл шилжүүлэх шийдвэрийг СМА өөрөө гаргана.

С. МЭДЭЭЛЭЛ АВАХ

(а) Мэдээлэх үүрэгтэй этгээдээс нэмэлт мэдээлэл авах

5. СМА-д тайлагнадаг мэдээллээс гадна СМА нь дүн шинжилгээг зохих ёсоор хийхийн тулд мэдээлэх үүрэгтэй этгээдээс нэмэлт мэдээллийг олж авах, ашиглах боломжтой байх ёстой. ФАТФ-ын Зөвлөмж (Зөвлөмж 10, 11, 22)-ийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс хадгалахыг шаардсан мэдээлэл нь СМА-ны авах эрхтэй мэдээлэл байж болно.

(b) Бусад эх сурвалжаас мэдээлэл авах

6. СМА нь зохих ёсны дүн шинжилгээ хийхийн тулд боломжит бүх өргөн хүрээний санхүүгийн, захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын мэдээллийг авах боломжтой байх хэрэгтэй. Үүнд нээлттэй эсвэл олон нийтийн эх сурвалжаас авах мэдээлэл, түүнчлэн бусад эрх бүхий байгууллагын цуглуулсан/хадгалдаг мэдээлэл, шаардлагатай тохиолдолд арилжааны байгууллагуудын хадгалж байгаа мэдээлэл орно.

D. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

7. СМА-ны хүлээн авсан, боловсруулсан, шилжүүлсэн болон хадгалдаг мэдээллийг журам, бодлого, холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцлал, аюулгүй

байдлыг ханган хадгалж, шилжүүлж ашиглана. Ийм учраас СМА нь мэдээллийг ашиглах, хадгалах, шилжүүлэх, хамгаалах, нэвтэрч танилцахад мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллахыг зохицуулах дүрэм, журамтай байх шаардлагатай. СМА-ны ажилтан, албан хаагчид нууцын зэрэглэлтэй мэдээлэлтэй ажиллах шаардлагыг хангасан, ийм мэдээлэлтэй харилцах, шилжүүлэхтэй холбоотой өөрсдийн үүрэг хариуцлагыг ухамсарласан байх шаардлагыг биелүүлэх арга хэмжээ авна. Мөн СМА-ны мэдээллийн технологийн систем, мэдээллийн сан, албан байр руу нэвтэрч ороход хязгаарлалттай байх шаардлагатай.

Е. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕ ДААСАН БАЙДАЛ

8. СМА нь мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээллийг шаардах, дамжуулах, шилжүүлэх зэрэг үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах бүрэн эрх, боломжтой байж үйл ажиллагааны хувьд хараат бус, бие даасан байх шаардлагатай. Энэ нь СМА эрх бүхий байгууллагад мэдээлэл дамжуулах, түгээх бие даасан эрхтэй гэсэн үг юм.

9. СМА-ыг аливаа байгууллагын бүрэлдэхүүн болгон байгуулж болно. СМА нь өөр байгууллагын бүтцэд хамаарч байгаа тохиолдолд СМА-ны үндсэн чиг үүрэг нь тухайн байгууллагын үндсэн чиг үүргээс тусдаа байх ёстой.

10. СМА нь бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа бие даасан хараат бусаар явуулахын тулд шаардлагатай санхүүгийн, хүний болон техникийн нөөцөөр хангагдсан байх шаардлагатай. Мөн улс орнууд нь эдгээр эрх бүхий байгууллагын ажилтнууд нь мэргэжлийн өндөр ур чадвартай, ялангуяа нууцлалын стандартыг чандлан сахиж, үнэнч шударга, зохих ур чадвартай байх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

11. СМА нь дотоодын бусад эрх бүхий байгууллага болон гадаадын байгууллагатай мэдээлэл солилцоходоо бие даан оролцох, гэрээ байгуулах боломжтой байх шаардлагатай.

Г. ГАДНЫ ХЭТ НӨЛӨӨ БОЛОН ОРОЛЦОО

12. СМА-ны үйл ажиллагааны бие даасан, тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх улс төр, засгийн газар болон салбарын хэт нөлөөлөл, хөндлөнгийн оролцооноос ангид байдлаар үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах эх үүсвэр, нөөцөөр хангагдах боломжтой, түүнийгээ захиран зарцуулдаг байх хэрэгтэй.

Г. ЭГМОНТ БҮЛЭГ

13. СМА нь Эгмонт бүлгийн зорилго болон Санхүүгийн мэдээллийн албадын хооронд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдлийн холбоотой мэдээлэл солилцох зарчмыг харгалзан үзэх хэрэгтэй (эдгээр бичиг баримт нь СМА-ны эрх, үүрэг болон СМА-дын дунд мэдээлэл солилцох үйл явцтай холбоотой чухал зааврыг дурдсан байдаг). СМА нь Эгмонт бүлгийн гишүүн болох хүсэлт гаргах шаардлагатай.

Н. ӨНДӨР ДҮНТЭЙ БЭЛЭН МӨНГӨНИЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ

14. Улс орнууд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-ийг тогтоосон босго дүнгээс дээш дүнтэй дотоод болон гадаадын төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэх системийн бололцоотой болон хэрэгцээтэй байдлыг судалж үзэх хэрэгтэй.

ЗӨВЛӨМЖ 30-ЫН ТАЙЛБАР

(ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОН МӨРДӨН ШАЛГАХ БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ)

1. Санхүүгийн мөрдөн шалгалт явуулж мөнгө угаах, суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг зохих ёсоор мөрдөн шалгах үүрэгтэй хууль сахиулах байгууллагатай байх шаардлагатай. Мөн хураан авах болон хураан авбал зохих өмч, хөрөнгийг цаг алдалгүй тодорхойлох, мөшгих, царцаах болон битүүмжлэх үйл ажиллагааг эхлүүлэх эрх бүхий нэг буюу түүнээс дээш эрх бүхий байгууллагатай байх шаардлагатай.

2. “Санхүүгийн мөрдөн шалгалт” гэдэг нь:

- гэмт хэрэг, сүлжээний цар хүрээ, хэмжээг тодорхойлох,
- гэмт хэргээс олсон орлого, террористуудын хөрөнгө болон бусад хураан авбал зохих хөрөнгө мөнгийг тодорхойлох, мөшгих,
- гэмт хэргийн яллах ажиллагаанд хэрэглэх баримт, нотолгоог боловсруулах зэрэг гэмт хэрэгтэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагааг мөрдөн шалгахыг хэлнэ.

3. “Санхүүгийн зэрэгцээ мөрдөн шалгалт” гэж мөнгө угаах, терроризмын санхүүжүүлэх, гэмт хэрэгт эрүүгийн мөрдөн шалгалт (уламжлалт) хийхийн зэрэгцээ мөн санхүүгийн мөрдөн шалгалт хийхийг хэлнэ. Суурь гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой аливаа хэргийг санхүүгийн зэрэгцээ мөрдөн шалгалт явуулах замаар мөрдөн шалгах эрхтэй байх эсвэл тухайн мөрдөн шалгалтыг хийдэг өөр байгууллага руу шилжүүлэн шалгуулах эрхтэй байна.

4. Улс орнууд шаардлагатай бол үндэсний хэмжээний хууль, тогтоомжийн дагуу мөнгө угаах, терроризмын санхүүжүүлэх, гэмт хэрэгт мөрдөн шалгалт хийх эрх бүхий байгууллагад тухайн үйл ажиллагаатай холбоотой хувь хүнийг тодорхойлох, нотлох баримт цуглуулах зорилгоор сэжигтэй этгээдийг баривчлахыг хойшлуулах болон баривчлахгүй байх, холбогдох хөрөнгийг хураахгүй байх болон хураахаас татгалзах боломжийг олгодог байх хэрэгтэй. Ийм арга хэмжээг хэрэгжүүлэхгүй бол хяналттай хүргэлт болон гүйцэтгэх ажиллагаа үр дүнгүй болно.

5. Зөвлөмж 30-д заасан хүрээнд эрх бүхий байгууллага нь үйл ажиллагаагаа явуулж байгаа нөхцөлд Зөвлөмж 30 нь хууль сахиулах байгууллага биш боловч суурь гэмт хэргийн санхүүгийн мөрдөн шалгалтад оролцдог эрх бүхий байгууллагуудад хамааралтай.

6. Авлигатай тэмцэх эрх бүхий байгууллага нь Зөвлөмж 30-ын дагуу авлигын гэмт хэрэгтэй холбоотой түүнээс үүдэн гарсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй тохиолдолд мөн эд хөрөнгийг тодорхойлох, мөшгих, царцаах болон битүүмжлэх үйл ажиллагааг эхлүүлэх эрх мэдэлтэй байх шаардлагатай.

7. Улс орнууд нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаанд олон байгууллагыг хамарсан ажлын хэсгийг байгуулахдаа дээр дурдсан хууль сахиулах байгууллага болон бусад эрх бүхий байгууллагын хүрээг харгалзан үзэх хэрэгтэй.

8. Хууль сахиулах болон прокурорын байгууллага нь санхүүгийн, хүний болон техникийн нөөцөөр хангагдах ёстой. Мөн улс орнууд нь эдгээр эрх бүхий байгууллагын ажилтнууд нь мэргэжлийн өндөр ур чадвартай, ялангуяа нууцлалын стандартыг чандлан сахиж, үнэнч шударга, зохих ур чадвартай байх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

ЗӨВЛӨМЖ 32-ЫН ТАЙЛБАР

(БЭЛЭН МӨНГӨ ЗӨӨВӨРЛӨГЧИД)

А. ЗОРИЛГО

1. Зөвлөмж 32-ыг террорист этгээд болон бусад гэмт хэрэгтэн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх болон гэмт хэргийн орлогоо мөнгөн тэмдэгт эсвэл шилжих төлбөрийн хэрэгсэл ашиглан хил дамнуулан тээвэрлэх боломжийг олгохгүй байх зорилгоор боловсруулсан. Тухайлбал улс орнууд нь дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай: (a) хил дамнуулан тээвэрлэж байгаа мөнгөн тэмдэгт болон шилжих төлбөрийн хэрэгсэл, (b) МУТС-д сэжиглэгдэж байгаа мөнгөн тэмдэгт болон төлбөрийн хэрэгсэлийг зогсоох, саатуулах, (c) буруу мэдүүлсэн, мэдэгдсэн мөнгөн тэмдэгт болон шилжих төлбөрийн хэрэгсэлийг зогсоох, саатуулах, (d) буруу мэдүүлсэн, мэдэгдсэн тохиолдолд зохих шийтгэлийг ногдуулах, (e) МУТС-тэй холбоотой мөнгөн тэмдэгт болон шилжих төлбөрийн хэрэгсэлийг хураан авах.

В. БЭЛЭН МӨНГӨ ЗӨӨВӨРЛӨГЧТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ АСУУДЛЫГ ИЛРҮҮЛЭХ СИСТЕМИЙН ТӨРЛҮҮД

2. Улс орнууд Зөвлөмж 32 болон энэ Тайлбар хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлэхдээ дараах системүүдээс аль нэгийг нь ашиглаж болох хэдий ч, хилээр орж байгаа болон гарч байгаа мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэлд заавал ижил төрлийн систем ашиглах шаардлагагүй.

Мэдүүлгийн систем

3. Мэдүүлгийн системд дээд хязгаар давсан буюу хамгийн ихдээ 15,000 ам.доллар/еврогийн үнийн дүнгээс хэтэрсэн мөнгөн тэмдэгт болон шилжих төлбөрийн хэрэгслийг хил давуулан биедээ авч явж байгаа бүх хүмүүс эрх бүхий байгууллагуудад үнэн зөв мэдүүлэг өгөх шаардлагатай. Улс орнууд дараах гурван төрлийн мэдүүлгийн системээс сонголт хийж болно: (i) бүх зорчигчдод зориулсан бичгээр мэдүүлэх систем, (ii) дээд хязгаараас давсан үнийн дүн бүхий мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэл авч явж байгаа зорчигчдод зориулсан бичгээр мэдүүлэх систем, эсвэл (iii) бүх зорчигчдод зориулсан аман мэдүүлгийн систем. Энэ гурван мэдүүлгийн системүүдийг доор дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд нь улс орнууд холимог системийг тэр бүр сонгож ашигладаггүй.

(a) *Бүх зорчигчдод зориулсан бичгээр мэдүүлэх систем:* Энэ системд бүх аялагчид улс руу нэвтрэхээс өмнө бичгээр мэдүүлэг бөглөх шаардлагатай. Үүнд нийтлэг асуултууд эсвэл гаалийн мэдүүлгийн маягтууд дээрх асуултууд орно. Бодит байдал дээр аялагчид мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэлтэй эсэхээ мэдүүлдэг (тийм эсвэл үгүй гэсэн сонголтыг зурж).

(b) Дээд хязгаараас давсан үнийн дүн бүхий мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэл авч явж байгаа зорчигчдод зориулсан бичгээр мэдүүлэх систем: Энэ системд урьдчилан тогтоосон босго хэмжээнээс дээш дүнтэй мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэл биедээ авч явж байгаа бүх аялагчид мэдүүлгийн маягтыг бөглөх шаардлагатай. Бодит байдал дээр аялагч нь тогтоосон босго дүнгээс хэтрэхгүй мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэл авч яваагүй тохиолдолд маягт бөглөх шаардлагагүй байдаг.

(c) Бүх зорчигчдод зориулсан аман мэдүүлгийн систем: Энэхүү системд бүх аялагчид тогтоосон босго дүнгээс давсан дүнтэй мөнгөн тэмдэгт эсвэл төлбөрийн хэрэгсэл биедээ авч явж байгаа тохиолдолд амаар мэдүүлэг өгөх шаардлагатай. Ихэнх тохиолдолд гаалийн нэвтрүүлэх цэг дээр аялагчид “улаан гарц” (мэдүүлэх бараа, бүтээгдэхүүнтэй) ба “ногоон гарц” (мэдүүлэх зүйл байхгүй) гэсэн сонголтуудаас сонгож нэвтэрдэг. Аялагчдын хийж байгаа энэ сонголтын үйл явцийг аман мэдүүлгийг нэгэн адил авч үздэг. Бодит байдал дээр аялагчид бичгээр мэдүүлдэггүй боловч гаалийн байцаагчид идэвхтэйгээр мэдээлэхийг шаарддаг.

Мэдээлэх систем

4. Улс орнууд аялагчдыг эрх бүхий байгууллагын шаардлагаар зохистой мэдээллийг гаргаж өгөх системийг ашиглах боломжтой. Тус системийн хувьд аялагчид нь аман болон бичгэн мэдүүлэг урьдчилан өгөх шаардлагагүй. Бодит байдал дээр мэдээлэх системийн хувьд зорчигчид нь эрх бүхий байгууллагын шаардсаны дагуу үнэн зөв хариулт өгөх, зохих мэдээллээр хангах шаардлагатай.

С. ДЭЭРХ ХОЁР СИСТЕМД ТОХИРОМЖТОЙ НЭМЭЛТ ЭЛЕМЕНТҮҮД

5. Дээрх системээс алийг нь ч хэрэгжүүлж байсан улс орнууд дараах элементүүдийг системдээ багтаасан байх ёстой. Үүнд:

(a) Мэдүүлгийн/мэдээлэх систем нь хилээр нэвтэрч байгаа орох болон гарах мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэлд хамаарна.

(b) Хэрэв буруу мэдүүлсэн эсвэл мэдүүлээгүй, мэдээлэл өгөөгүй мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэл илрүүлсэн бол холбогдох эрх бүхий байгууллага нь зөөвөрлөгчөөс мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгсэлийн эх үүсвэр, зориулалтын талаар нэмэлт мэдээлэл авах эрхтэй байна.

(c) Мэдүүлэх/мэдээлэх системээр цуглуулсан мэдээллийг хил давуулсан сэжигтэй үйлдлийн талаар мэдэгдэх систем эсвэл өөр бусад арга замаар мэдүүлэг/мэдэгдлийг шууд СМА-нд өгөх арга замын аль нэгийг сонгон СМА-нд мэдээлж болно.

(d) Дотооддоо Зөвлөмж 32-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар гааль, цагаачлал болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудын дунд хамтын ажиллагаа, харилцан уялдаа холбоог бий болгох шаардлагатай.

(e) Эрх бүхий байгууллагууд нь (i) мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх сэжиг байгаа тохиолдолд болон (ii) худал мэдүүлэг, мэдээлэл өгсөн тохиолдолд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлсэн гэх баталгаа нотолгоо байгаа эсэхийг баталгаажуулахын тулд тухайн мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгслийг тодорхой хугацаанд зогсоох, саатуулах эрхтэй байна.

(f) Улс орнууд 36-аас 40 дүгээр зөвлөмжийн дагуу мэдүүлэх/мэдээлэх систем нь олон улсын хамтын ажиллагаа болон туслалцаа үзүүлэх өргөн боломжийг хангасан байх шаардлагатай. Дээрх хамтын ажиллагааг дэмжихийн тулд доорх мэдээллийг хуримтлуулна. Үүнд: (i) тогтсон үнийн дээд босго 15,000 ам.доллар/еврогийн үнийн дүнгээс хэтэрсэн мөнгөн тэмдэгт болон шилжих төлбөрийн хэрэгслийн мэдүүлэг, мэдээлэл; (ii) худал мэдүүлэг, мэдээлэл өгсөн; (iii) мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх сэжиг байгаа зэрэг болно. Мэдээлэлд доод тал нь (i) мэдүүлсэн, мэдээлсэн болон бусад байдлаар мэдэгдсэн мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгслийн үнийн дүн, (ii) уг этгээдийг тодорхойлох мэдээллийг багтаасан байх шаардлагатай.

(g) Мэдүүлэх/мэдээлэх системээр дамжуулж цуглуулсан мэдээллийг зохих ёсоор ашиглахад (i) улс орнуудын хоорондох бараа, үйлчилгээний худалдааны төлбөр, (ii) хөрөнгийн урсгал, хөдөлгөөний байдалд саад учруулахгүйгээр найдвартай, аюулгүй байдлаар зохион байгуулах шаардлагатай.

D. ШИЙТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭ

6. Буруу мэдүүлсэн эсвэл мэдүүлээгүй, мэдээлэл өгөөгүй хувь хүнд гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн үр дүнтэй эрүүгийн, иргэний болон захиргааны шийтгэлийн арга хэмжээ авна. Терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэгтэй холбоотой мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгслийг хил давуулан зөөвөрлөж байгаа хувь хүнд мөн гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн үр дүнтэй эрүүгийн, иргэний болон захиргааны шийтгэлийн арга хэмжээ авч, Зөвлөмж 4-ийн дагуу тухайн мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгслүүдийг хураан авна.

7. Зөвлөмж 32-ыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй эрх бүхий этгээд нь зохих санхүүгийн, хүний болон техникийн нөөцөөр хангагдсан байх шаардлагатай. Мөн улс орнууд нь эдгээр байгууллагуудын ажилтнууд нь мэргэжлийн өндөр ур чадвартай, ялангуяа нууцлалын стандартыг чандлан сахиж, үнэнч шударга, зохих ур чадвартай байх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Е. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУ

8. Алт, үнэт металл, үнэт чулуу зэрэг хөрвөх чадвар сайтай, үнэ өртөг дамжуулах солилцох хэрэгсэл болох чадвартай хэдий ч Зөвлөмж 32-т хамруулдаггүй болно. Үүнийг гаалийн хууль, журмын дагуу зохицуулах боломжтой. Хэрэв улс орнууд алт, үнэт металл эсвэл үнэт чулууг хилээр нэвтрүүлж байгаа хэвийн бус үзэгдэл илрүүлбэл тухайн эд зүйлс зориулагдсан эсвэл чиглэж байгаа улсын холбогдох эрх бүхий байгууллага эсвэл гаалийн байгууллагад мэдэгдэж тээвэрлэлтийн зориулалт, очих газар болон эх үүсвэрийг тодорхойлон холбогдох арга хэмжээг авах шаардлагатай.

Зөвлөмжид ашиглагдсан нэр томъёоны тайлбар толь

Буруу мэдүүлэх	Тээвэрлэж байгаа мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгслийн (BNIs) хэмжээг буруу мэдүүлэх эсвэл эрх бүхий байгууллагаас шаардсан бусад холбогдох тоон мэдээллийг мэдүүлэгт буруу мэдүүлснийг хэлнэ. Үүнд шаардлагатай нөхцөлд мэдүүлэг гаргаж өгөөгүй байх орно.
Буруу мэдээлэх	Тээвэрлэж байгаа мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгслийн (BNI) хэмжээ/өртгийг буруу мэдээлэх эсвэл эрх бүхий байгууллагаас асуухад холбогдох тоон мэдээллийг буруу мэдээлэхийг хэлнэ. Үүнд шаардлагатай нөхцөлд мэдээлээгүй байх орно.
Хил дамнансан биет тээвэрлэлт	Нэг улсаас нөгөө улс руу мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгслийг (BNIs) биетээр тээвэрлэхийг хэлнэ. Энэхүү нэр томъёонд дараах төрлийн тээвэрлэлтийн хэлбэр багтана: 1. Хувь хүн эсвэл тухайн хүний тээвэрлэж байгаа ачаа тээш, тээврийн хэрэгсэлд зөөвөрлөх, 2. Контейнерт каргогоор мөнгөн тэмдэгт шилжих төлбөрийн хэрэгслийг (BNIs) тээвэрлэх, 3. хувь хүн эсвэл хуулийн этгээдээр дамжуулан мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгслийг (BNIs) шуудангаар тээвэрлэх.
Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой	Мөнгөн тэмдэгт, шилжих төлбөрийн хэрэгслийг /BNIs/-тэй холбоотой хэрэглэглэхдээ: (i) терроризм, террорист үйл ажиллагаа, террорист байгууллагыг санхүүжүүлэхэд ашиглагдах, ашиглахаар завдсан, ашиглахаар төсөвлөсөн болон орлогыг, эсвэл (ii) мөнгө угаах болон суурь гэмт хэргээс угаасан ашиг орлого эсвэл эдгээр гэмт хэргийг үйлдэхэд ашигласан эсвэл ашиглах зорилготой арга хэрэгслүүд орно.

ЗӨВЛӨМЖ 38-ЫН ТАЙЛБАР

(ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА: ЦАРЦААХ, ХУРААХ)

1. Улс орнууд хураан авсан эд хөрөнгийн бүгдийг эсвэл тодорхой хувийг хууль сахиулах, эрүүл мэнд, боловсрол болон бусад шаардлагатай зорилгоор зарцуулах хураасан хөрөнгийн сан байгуулах нь зүйтэй. Мөн улс орнууд нь хураан авсан эд хөрөнгийг, ялангуяа хууль сахиулах хамтын ажиллагааны үр дүнд хураан авсан тохиолдолд бусад улсуудтай хуваалцах боломжийг олгох шаардлагатай арга хэмжээг авах хэрэгтэй.

2. Эрүүгийн шийтгэлгүй хөрөнгө хураахтай холбоотой хамтын ажиллагааны хувьд улс орнууд энэ хүсэлтийг биелүүлэх үүрэггүй боловч гэмт этгээд нас барсан, оргон зайлсан, алга болсон болон танигдахгүй байгаа тохиолдолд хамтын ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ 40-ИЙН ТАЙЛБАР

(ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БУСАД ХЭЛБЭР)

А. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛАГААНЫ БҮХ ХЭЛБЭРТ ХЭРЭГЛЭХ ЗАРЧИМ

Хүсэлт гаргагч байгууллагын үүрэг

1. Эрх бүхий байгууллага нь хамтран ажиллах хүсэлт гаргахдаа тодорхой, бүрэн, бодит холбогдох хууль эрх зүйн мэдээлэл өгөх, яаралтай асуудал байгаа эсэхийг дурдах, хариуг хугацаанд нь өгөхөд шаардлагатай мэдээлэл болон хариу мэдээллийг яаж ашиглах талаар мэдээлэл өгөх хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Хүсэлт гаргасан эрх бүхий байгууллага нь мэдээлэл өгсөн байгууллагын хүсэлтээр хариу авсан мэдээллийн ашиглалт болон хэрэгцээтэй байдлын талаар хариу мэдээлэл өгөх нь зүйтэй.

Хэт хязгаарлалтын арга хэмжээ

2. Улс орнууд нь туслалцаа болон мэдээлэл солилцох тал дээр үндэслэлгүй, хэт хязгаарлах нөхцөл тавих ёсгүй. Тодруулбал эрх бүхий байгууллагууд нь дараах үндэслэлээр туслалцаа хүссэн хүсэлтийг буцаах ёсгүй. Үүнд:

- (a) Хүсэлт нь татварын асуудлыг давхар хамарсан гэж үзсэн;
- (b) Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь харилцагчийн нууцлалыг хамгаалахыг хуулиар шаардсан (холбогдох мэдээлэл нь хууль, эрх зүйн мэргэжлийн эрх, нууцлалд хамаарах нөхцөлд байгаа тохиолдол);
- (c) Хүсэлт авсан улс оронд шалгалт, мөрдөн байцаалт болон шүүх ажиллагаа явагдаж байгаа (туслалцаа нь тухайн шалгалт, мөрдөн байцаалт болон шүүх ажиллагаанд саад болно гэж үзэж байгаа);
- (d) Хүсэлт гаргаж буй эрх бүхий байгууллагын төрөл болон статус (иргэний, захиргааны, хууль сахиулах г.м) нь гадны ижил төстэй эрх бүхий байгууллагын төрлөөс өөр байх.

Солилцсон мэдээллийн аюулгүй байдал

3. Солилцсон мэдээллийг зөвхөн хүсэлтэд дурдсан зориулалтын дагуу эсвэл ирсэн хариуны дагуу ашиглах шаардлагатай. Мэдээллийг бусад эрх бүхий байгууллага эсвэл гуравдагч этгээдэд дамжуулах, эсвэл мэдээллийг захиргааны, мөрдөн байцаах, прокурорын болон шүүхийн үйл ажиллагаанд ашиглах бол мэдээлэл өгсөн байгууллагын урьдчилсан зөвшөөрлийг авсан байх ёстой.

4. Эрх бүхий байгууллагууд нь нууцлал, мэдээллийг хамгаалахтай⁵² холбоотой хоёр талын үүрэг хариуцлагыг ухамсарлаж, солилцсон мэдээлэл, хамтын ажиллагааны аливаа хүсэлтийн зохих нууцлалыг хангаж хадгалах шаардлагатай. Эрх бүхий байгууллага нь гадаад улстай солилцсон мэдээллийн нууцлал нь хамгийн багадаа дотоодын эх сурвалжаас хүлээн авсан ижил төстэй мэдээллийн нууцлалыг хамгаалах түвшинтэй ижил байх шаардлагатай. Улс орнууд эрх бүхий байгууллагуудын солилцсон мэдээллийг зөвхөн зөвшөөрсөн журмын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах, хамгаалалтыг бий болгох ёстой. Мэдээлэл солилцоо нь нууцлалыг хангасан найдвартай, мэдээлэл дамжуулах хамгаалаттай суваг, механизмаар дамжиж байх ёстой. Хүсэлт хүлээн авсан эрх бүхий байгууллага нь хүсэлт гаргаж буй эрх бүхий байгууллагыг мэдээллийн нууцлалыг хамгаалж чадахгүй гэж үзвэл мэдээллээр хангахаас татгалзах эрхтэй.

Мэдээллийг хайх эрх мэдэл

5. Эрх бүхий байгууллага нь гадны байгууллагын нэрийн өмнөөс дотооддоо байцаалт хийх үед дотоодын ижил түвшний шалгалтаар олж авах боломжтой бүх мэдээллийг гадны эрх байгууллагуудтай солилцох шаардлагатай.

В. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТОДОРХОЙ ХЭЛБЭРТ ТОХИРСОН ЗАРЧИМ

6. Дээрх ерөнхий зарчмуудыг дор дурдсан заалтуудыг харгалзан хамтран ажиллагч болон хамтран ажиллагч бус талуудын хооронд мэдээлэл солилцох бүх хэлбэрт ашиглана.

Санхүүгийн мэдээллийн алба хоорондын мэдээлэл солилцоо

7. СМА нь тухайн улсын СМА-ны статус (захиргааны, хууль сахиулахын, шүүхийн эсвэл бусад төрлийнх байх)-аас үл хамааран гадаадын СМА-тай мэдээлэл солилцон хамтран ажиллах хэрэгтэй. СМА-нд нь мөнгө угаах, холбоотой суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар хамтран ажиллах зохистой хууль, эрх зүйн үндэслэл байх шаардлагатай.

8. СМА нь хамтран ажиллах хүсэлт гаргахдаа шинжилгээ хийгдэж байгаа кейс болон хүсэлт гаргаж буй улстай холбогдох мэдээллийг бүрэн, тодорхой бодит холбогдох хууль эрх зүйн мэдээллийн хамт өгөх боломжит арга хэмжээ авах. СМА нь хүсэлтийн дагуу болон боломжтой үедээ гадны СМА-даас өгсөн мэдээллийн ашиглалт, өгсөн мэдээлэлд үндэслэж хийж гүйцэтгэсэн дүн шинжилгээний үр дүнгийн талаар хариу мэдэгдэж, эргэх холбоогоор хангах шаардлагатай.

9. СМА-д нь дараах мэдээллийг солилцох эрхтэй байна. Үүнд:

⁵² Хамтын ажиллагаа шаардлагатай хүсэлт бол ийм мэдээллийг хуваалцах хэрэгтэй байж болзошгүй.

(a) ФАТФ-ын Зөвлөмж болон ялангуяа Зөвлөмж 29-ийн дагуу СМА-дын шууд болон шууд бус байдлаар хүлээн авдаг, авах боломжтой аливаа мэдээлэл;

(b) Харилцан мэдээлэл солилцох зарчмын дагуу хамтын ажиллагаатай дотоодын байгууллагуудаас шууд болон шууд бус байдлаар хүлээн авдаг, авах боломжтой аливаа мэдээлэл.

Санхүүгийн хянан шалгагчдын⁵³ хоорондох мэдээлэл солилцоо

10. Санхүүгийн хянан шалгагч нар нь гаднын байгууллагатай тэдгээрийн төрөл, статусаас үл хамааран хамтран ажиллана. Санхүүгийн хянан шалгагчдын үр дүнтэй хамтын ажиллагаа нь санхүүгийн байгууллагыг үр дүнтэй МУТСТ хяналт шалгалтад хамруулах зорилготой. Санхүүгийн хянан шалгагч нар нь олон улсын стандартын дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлийн хяналт шалгалтын мэдээллийг солилцох хууль, эрх зүйн үндэслэлтэй байх шаардлагатай.

11. Санхүүгийн хянан шалгагч нар нь тус тусын хэрэгцээ шаардлагад нийцүүлж гадны ижил төстэй санхүүгийн хянан шалгагч нартай дотоод гаргах боломжтой мэдээлэл болон санхүүгийн байгууллагуудын эзэмшиж буй мэдээллийг солилцох боломжтой байх шаардлагатай. Санхүүгийн хянан шалгагч нар нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор нэг ижил группд хамаарч байгаа санхүүгийн байгууллагуудыг хариуцаж байгаа бусад хянан шалгагч нартай дараах төрлийн мэдээлэл солилцох боломжтой байх шаардлагатай. Үүнд:

(a) Дотоодын зохицуулалтын тогтолцоо болон санхүүгийн салбарын ерөнхий мэдээлэл зэрэг зохицуулалтын мэдээлэл;

(b) Үндсэн зарчмуудыг хэрэгжүүлж буй хянан шалгагч нарт зориулсан санхүүгийн байгууллагын бизнесийн үйл ажиллагаа, эцсийн өмчлөгч, удирдлага, шалгуур үзүүлэлт зэрэг мэдээлэл;

(c) Санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод дүрэм журам, бодлого, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, харилцагчийн хувийн хэрэг, данс болон гүйлгээний хуулга зэрэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэдээлэл;

12. Санхүүгийн хянан шалгагч нар нь группт хамаарч байгаа санхүүгийн байгууллагад үр дүнтэй хяналт шалгалт хийхийн тулд гадны санхүүгийн хянан шалгагч нарын өмнөөс шалгалт хийх, тохиромжтой гэж үзвэл тухайн улс оронд өөрсдөө хяналт, шалгалт хийх боломжоор хангах хэрэгтэй.

⁵³ Эрх бүхий санхүүгийн хянан шалгах байгууллагыг хэлж байна

13. Хүсэлт гаргаж буй санхүүгийн хянан шалгагч нь мэдээллийг задруулах, тайлагнах хуулийн үүрэг хариуцлага хүлээгээгүй бол хүсэлтэд хариулсан санхүүгийн хянан шалгагч нарын урьдчилсан зөвшөөрөлд үндэслэж мэдээллийг цааш нь дамжуулах, хяналт шалгалтын болон хяналт шалгалтын бус зорилгоор тухайн мэдээллийг ашиглана. Дээрх тохиолдолд хүсэлт гаргасан санхүүгийн хянан шалгагч нь ийм үүрэг хариуцлагыг биелүүлэх болсоноо нэн даруй нөгөө талдаа мэдэгдэх шаардлагатай. Урьдчилсан зөвшөөрөлд Хамтын ажиллагааны санамж бичиг, үндсэн зарчмыг боловсруулсан газрын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд солилцох мэдээллийг зохицуулах Олон талт хамтын ажиллагааны санамж бичгийн дагуу зөвшөөрөлд тооцсон бүх арга хэлбэрүүд орно.

Хууль сахиулах байгууллагуудын хоорондох мэдээлэл солилцоо

14. Хууль сахиулах эрх бүхий байгууллага нь мэдээллийн болон мөрдөн шалгах үйл ажиллагааны зорилгоор мөнгө угаах, холбоотой суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн орлого, арга хэрэгслүүдийг тодорхойлох болон мөшгих дотооддоо байгаа мэдээллээр гадны ижил төстэй байгууллагуудыг хангах, хоорондоо мэдээлэл солилцох боломжтой байна.

15. Түүнчлэн хууль сахиулах эрх бүхий байгууллага нь гадаадын ижил төстэй байгууллагын өмнөөс мэдээлэл олж авах, мөрдөн шалгалт явуулахын тулд хууль тогтоомжийн хүрээнд олгосон эрх мэдэл, мөрдөн шалгах арга техник зэргийг ашиглах боломжтой байх шаардлагатай. Интерпол, Европол, болон Еврожаст болон улс орнуудын хоорондох гэрээ хэлэлцээр зэрэг хууль сахиулах үйл ажиллагаа, хамтын ажиллагааны дүрэм журам болон хэвшсэн практик нь хүсэлт гаргасан хууль сахиулах байгууллагын зүгээс шаардах аливаа хязгаарлалт, хоригийг зохицуулах шаардлагатай.

16. Хууль сахиулах байгууллагууд нь хамтарсан мөрдөн шалгалтын баг байгуулан ажиллах боломжтой байх бөгөөд шаардлагатай бол хамтарсан мөрдөн шалгалт явуулах хоёр талт болон олон талт гэрээ хэлэлцээрийг байгуулах шаардлагатай. Улс орнуудыг цаг тухайд нь үр дүнтэй хамтран ажиллах зорилгоор МУТСТ хууль сахиулах байгууллагын сүлжээнд элсэх болон идэвхтэй оролцох, хоёр талт гэрээ байгуулан харилцаа хариуцсан албан хаагчдыг гадаадын улсад байршуулан ажиллуулахыг сайшаан дэмжинэ.

Ижил төстэй бус байгууллагуудын хоорондох мэдээлэл солилцоо

17. Улс орнууд нь дээр дурдсан холбогдох зарчмуудын хүрээнд ижил төстэй бус эрх бүхий байгууллагуудын хооронд шууд бусаар мэдээлэл солилцохыг зөвшөөрөх хэрэгтэй. Шууд бусаар мэдээлэл солилцох гэж мэдээлэл хүссэн байгууллагаас мэдээллийн хүсэлт гадаад болон дотоодын хэд хэдэн эрх бүхий байгууллагаар дамжиж байж мэдээлэл хүссэн байгууллагад хариу очих тохиолдыг хэлнэ. Энэ мэдээлэл солилцох ажиллагаа нь мэдээлэл хүсч байгаа улсын хэд хэдэн байгууллагаас зөвшөөрөл

авах шаардлагатай байж болзошгүй. Мэдээлэл хүсч байгаа холбогдох эрх бүхий байгууллага нь ямар зорилгоор, хүсэлтийг хэний өмнөөс гаргаж байгаа тухай тодорхой тайлбарлах шаардлагатай.

18. Түүнчлэн улс орнууд нь ижил төстэй бус үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай шууд, шуурхай байдлаар мэдээлэл солилцох боломж олгох талаар судлах шаардлагатай.

САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, СББМҮҮ НАРТ ШААРДЛАГА ТАВИХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

1. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт тавигдах шаардлагыг а) хуульд тусгах (ФАТФ-ын Зөвлөмж 10, 11, 20-ын тусгай шаардлагуудыг үзнэ үү) болон б) тухайн улс нь өөрийн нөхцөл байдалд тохируулан хууль эсвэл бусад хэрэгжилтийг хангах арга хэрэгслээр зохицуулж болно.

2. ФАТФ-ын Зөвлөмж 10, 11, 20-д дурдсан “хууль” гэж тухайн улсын Үндсэн хуулийн хүрээнд парламентийн үйл явц эсвэл түүнтэй адилтгах арга хэлбэрээр боловсруулж, баталсан заавал мөрдөх шаардлагатай, зөрчигсдөд шийтгэл оногдуулдаг эрх зүйн актыг хэлнэ. Хууль зөрчигсдөд оногдуулах шийтгэл нь үр дүнтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байх шаардлагатай (Зөвлөмж 35). Хууль гэдэг тодорхойлтод холбогдох шаардлагыг тавьж, тухайн улсын бүх газар нутагт заавал мөрдөх шаардлагатай шүүхийн шийдвэр орно.

3. “Хэрэгжилтийг хангах арга хэрэгсэл” гэж эрх бүхий байгууллагаас боловсруулсан эсвэл баталсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх заавал биелүүлэхийг шаардсан үг хэллэгтэй, зөрчигсдөд хариуцлага оногдуулах журам, заавар, удирдамж, зааварчилгаа, бусад баримт бичиг бусад арга хэрэгслийг хэлнэ. Зөрчигсдөд оногдуулах шийтгэл нь үр дүнтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц байх шаардлагатай (Зөвлөмж 35).

4. Баримт бичиг, арга хэрэгслийн шаардлага нь “Хэрэгжилтийг хангах арга хэрэгсэл” гэж үзэхэд доорх хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:

(а) ФАТФ-ын Зөвлөмжтэй холбоотой шаардлагуудыг тодорхойлсон эсвэл тэдгээрийг бататгасан баримт бичиг, арга хэрэгсэл байх шаардлагатай бөгөөд шаардлагуудыг ойлгомжтой, тодорхой илэрхийлсэн байх хэрэгтэй. Тухайлбал:

(i) Аливаа үйл ажиллагаа нь гүйцэтгэвэл зохих эсвэл шаардлагатай гэдэг үг хэллэгийг ашигласан байвал үүнийг заавал биелүүлэх шаардлагатай гэж ойлгоно.

(ii) Зохицуулагч эсвэл зохицуулагдаж байгаа байгууллагын үйл ажиллагаанд шууд болон шууд бус хэлбэрээр шаардлага тавигдаж, уг шаардлагыг хэрэгжүүлж байвал энэхүү нөхцөлд “хэрэгтэй” /should/ гэсэн үг хэллэгийг заавал мөрдөх шаардлагатай гэж ойлгоно. “Ямарваа зүйлийг хийвэл зохимжтой, зөвлөж байна, харгалзан үзэх” /are encouraged, are recommended or should consider/ гэсэн хэллэгийг заавал мөрдвөл зохих гэж үзэхгүй байж болно. Бусад нөхцөлд сулавтар үг хэллэг ашиглавал энэ нь заавал мөрдөх

шаардлагагүй гэсэн утга санаа илэрхийлнэ (тухайн улс нь өөрөөр гэдгийг нотлоогүй бол).

(b) Эрх бүхий байгууллага нь баримт бичиг/арга хэрэгслүүдийг боловсруулсан эсвэл баталсан байх шаардлагатай.

(c) Зөрчигсдөд үр дүнтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц шийтгэл оногдуулах шаардлагатай (шийтгэлийн арга хэмжээ нь шаардлага тавьж, бататгаж байгаа баримт бичигт заавал хамт байх шаардлагагүй бөгөөд шаардлага болон шийтгэлийн хооронд тодорхой холбоо үүсгэж байгаа өөр баримт бичигт байж болно). Эдгээрт доорх зүйлсийг харгалзан үзнэ:

(i) Заавал мөрдөх шаардлагатай үүрэг хариуцлагаа биелүүлээгүй тохиолдолд үр дүнтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц олон төрлийн шийтгэлийн арга хэмжээ байх хэрэгтэй.

(ii) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагыг дагаж мөрдөөгүй тохиолдолд оногдуулах шийтгэлийг шууд эсвэл шууд бусаар ногдуулах боломжтой байх хэрэгтэй. Хэрэв мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зөрчилтэй холбоотой шийтгэлийг шууд тодорхойлоогүй бол зохистой тогтолцоо, хяналт, аюулгүй болон тохиромжтой хэлбэрээр үйл ажиллагаа явуулаагүй зэрэг илүү өргөн цар хүрээний, шаардлагатай холбоотой зөрчлийн шийтгэлийг ашиглаж болно. Ингэхдээ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд МУТСТ-тэй холбоогүй бусад хяналтын дутагдлыг батлах шаардлагагүйгээр зохих шийтгэлийг шууд оногдуулах боломжтой байх шаардлагатай.

(iii) Үр дүнтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэхүйц шийтгэлийн арга хэмжээнүүдийг практикт ашигласан хангалттай нотолгоо байгаа эсэх.

5. Ямарч нөхцөлд санхүүгийн байгууллага, СББМҮҮ нар нь шаардлагуудыг биелүүлээгүй тохиолдолд ногдуулах шийтгэл болон шийтгэлийн хэлбэрийн талаар ойлгосон нь тодорхой байх хэрэгтэй.

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Данс	“Данс” гэж санхүүгийн байгууллага болон харилцагч хоорондын бусад бизнесийн харилцааг хамааруулан ойлгоно.
Accounts	
Алдаагүй	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Accurate	
Төлөөлөгч	Зөвлөмж 14, 16-ын хүрээнд мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгчийн нэрийн өмнөөс,
Agent	гэрээний дагуу эсвэл уг үйлчилгээ үзүүлэгчийн зааварчилгаагаар үйлчилгээ үзүүлж буй хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөгч гэнэ.
Холбогдох эрх бүхий байгууллага	Зөвлөмж 8-ын тайлбарыг харна уу.
Appropriate authorities	
Салбар ТББ-ууд	Зөвлөмж 8-ын тайлбарыг харна уу.
Associate NPOs	
Багц шилжүүлэг	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Batch transfer	
Шилжих төлбөрийн хэрэгсэл	Шилжих төлбөрийн хэрэгсэлд (BNIs) дараах хэрэгслүүд орно. Үүнд: аялагчийн чек, шилжих хэлбэрээр байгаа, ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шилжүүлж болох, ямар нэгэн төлбөр хүлээн авагчид зориулсан, эзэмшил нь хүлээн авсан хүнд шууд шилждэг тохиролцоон дээр үндэслэсэн арга хэрэгслүүд /чек, вексель, мөнгөний ордер/, мөн гарын үсэг зурсан хэрнээ хүлээн авагчийн нэр байхгүй бүрэн бус мөнгөний хэрэгслүүд орно /чек, вексель, мөнгөний ордер/.
Bearer Negotiable instruments	
Мэдүүлэгчийн хувьцаа	Мэдүүлэгчийн хувьцаа - хуулийн этгээдийн өмчлөгч нь хувьцаа эзэмших сертификатыг эзэмшиж байгаа этгээд нь өмчлөгч болдог тохиролцооны арга хэрэгсэл юм.
Bearer shares	
Эцсийн өмчлөгч	Эцсийн өмчлөгч гэдэг нь хуулийн этгээдийг эцсийн дүндээ эзэмшдэг болон хянадаг ⁵⁴ , харилцагчийн нэрийн өмнөөс гүйлгээ хийж байгаа хувь хүнийг ⁵⁵ хэлнэ.
Beneficial owner	Хуулийн этгээд, бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдэд эцсийн хяналтыг тогтоосон хувь хүнийг хэлнэ.
Үр шим хүртэгчид	Зөвлөмж 8-ын тайлбарыг харна уу.

⁵⁴ эцсийн дүндээ эзэмшдэг болон хянадаг гэж өмчлөл болон хяналтыг хяналтын гинжин холбоос буюу шууд бус бусад дамжсан хэлбэрээр хянахыг хэлнэ.

⁵⁵ Энэ тодорхойлолтыг амьдралын даатгалын болон бусад хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын бүтээгдэхүүний үр шим хүртэгчийн эцсийн өмчлөгчид мөн хамруулна.

Beneficiaries**Үр шим хүртэгч**

Үр шим хүртэгч гэдэг нь ФАТФ-ын зөвлөмжид авч үзэж буй асуудлаасаа хамааран өөр өөр утга санаа илэрхийлдэг:

Beneficiary

- Трастын хуулиар траст хэлцэлээс үр шим хүртэгч хувь хүн, этгээдийг үр шим хүртэгч гэдэг. Үр шим хүртэгч нь хувь хүн, хуулийн этгээд, бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд байж болно. Бүх траст нь (хандивын эсвэл хуулиар зөвшөөрөгдсөн хандивын бус траст) тодорхой үр шим хүртэгчтэй байх шаардлагатай. Траст нь заавал тодорхойлж болох эцсийн үр шим хүртэгчтэй байх шаардлагатай ч зарим траст нь тодорхой этгээдэд үр шим хүртэх эрх үүстэл зөвхөн удирдлагыг хэрэгжүүлдэг эсвэл хөрөнгийг заасан хугацаа (хуримтлалын үе гэдэг) болтол өөр хүн хариуцаж болдог. Энэхүү хугацааг трастын байнгын хүчинтэй нөхцлөөс хамааран уртасгаж болдог бөгөөд үүнийг ихэвчлэн трастын гэрээслэлд дурдсан байдаг.

- Амь насны даатгал эсвэл бусад хэлбэрийн хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын бүтээгдэхүүний хувьд үр шим хүртэгч нь даатгалын тохиолдол учирсан үед тухайн даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авдаг хувь хүн, хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд, хүмүүсийн бүлэг байна.

Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.

Хүлээн авагч**санхүүгийн байгууллага**

Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.

Beneficiary Financial Institution**Эрх бүхий байгууллага****Competent Authorities**

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий бүх төрлийн байгууллагыг⁵⁶ эрх бүхий байгууллага гэнэ. Үүнд ялангуяа СМА; мөнгө угаах гэмт хэрэг, холбогдох суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, гэмт хэргийн хөрөнгийг царцаах/битүүмжлэх, хураан авах, мөрдөн шалгах, яллах, чиг үүрэгтэй холбогдох байгууллагууд; мөнгөн тэмдэгт болон шилжих төлбөрийн хэрэгслийг /BNIs/ хил дамнуулан тээвэрлэх мэдүүлэг/мэдээ хүлээн авах байгууллага; санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарын МУТСТ шаардлагыг мөрдүүлэхэд

⁵⁶ Энэ тодорхойлолтод засгийн газрын бус бие даан хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн хянан шалгагч нарыг хамруулсан.

	хянан шалгах эсвэл хяналт тавих үүрэгтэй байгууллагууд тус тус багтана.
Хөрөнгө хураан авах Confiscation	Шүүх эсвэл эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу мөнгө болон бусад хөрөнгийг бүр мөсөн хураан авахыг хөрөнгө хураан авах гэнэ. Хөрөнгө хураан авах үйл явц нь шүүхийн эсвэл захиргааны үйл ажиллагааны дагуу мөнгө эсвэл бусад хөрөнгийн эзэмших эрхийг улсад шилжүүлдэг. Энэ тохиолдолд, хувь хүн эсвэл хуулийн этгээд нь зарчмын хувьд тухайн хөрөнгө, мөнгийг хураах үед бүх эрхээ алддаг. Хөрөнгө албадан хураах шийдвэр нь ихэвчлэн хураасан хөрөнгийг хууль зөрчих үйл ажиллагаанд ашиглах гэж байсан эсвэл хууль бус үйл ажиллагаанаас гаралтай гэж эрүүгийн хэргийн ял шийтгэл эсвэл шүүхийн шийдвэрээр тогтоосонтой холбоотой үүсдэг.
Үндсэн зарчмууд Core Principles	Үндсэн зарчимд Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос боловсруулсан Банкны хяналт шалгалтыг үр дүнтэй хийх үндсэн зарчим, Үнэт цаасны олон улсын хорооноос гаргасан Үнэт цаасны зохицуулалтын зорилт болон зарчмууд болон Даатгалын хянан шалгагч нарын олон улсын ассоциациас гаргасан Даатгалын хяналт шалгалтын зарчим багтана.
Корреспондент банк Correspondent Banking	Корреспондент банкны үйл ажиллагаа нь нэг банк (корреспондент банк) нь нөгөө респондент банкинд (үйлчилгээ хүлээн авагч банк) банкны үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ. Олон улсын томоохон банкууд нь дэлхийн өнцөг буланд орших мянга мянган банкуудын корреспондент банк болон ажилладаг. Респондент банк нь бэлэн мөнгөний менежмент (жн: төрөл бүрийн валютын хүү тооцогдох данснууд гэх мэт), олон улсын цахим шилжүүлэг, чекийн төлбөр тооцоо, дамжин өнгөрөх данс, валютын арилжааны үйлчилгээг оролцуулаад олон төрлийн үйлчилгээ авдаг.
Улс орон Country	ФАТФ-ын зөвлөмжид дурдсан улс орнууд гэдгээр улс, улс орнууд, газар нутаг болон юрисдикцийг хэлнэ.
Нэгтгэсэн төлбөр тооцоо Cover Payment	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Гэмт үйлдэл Criminal activity	Гэмт үйлдэл гэдэгт: а) тухайн оронд мөнгө угаахын суурь гэмт хэрэгт тооцогдох бүх гэмт хэргийг хэлнэ, эсвэл б) хамгийн багадаа Зөвлөмж 3-ын шаардлагын дагуу тодорхойлсон суурь гэмт хэргийг хэлнэ.
Хил дамнасан цахим шилжүүлэг	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.

Cross-border wire transfer

Мөнгөн тэмдэгт

Мөнгөн тэмдэгт гэж төлбөр, арилжааны хэрэгсэл бөгөөд гүйлгээнд байгаа цаасан дэвсгэрт, зоосыг хэлнэ.

Currency

Холбогдох гэмт хэргийн ангилал

Холбогдох гэмт хэргийн ангилалд:

Designated categories of offences

- Зохион байгуулалттай гэмт бүлэгт оролцох, дарамтлах
- Терроризм, терроризмыг санхүүжүүлэх
- Хүн худалдаалах, цагаачдыг хууль бусаар хил давуулах
- Бэлгийн мөлжлөг (хүүхдийн бэлгийн мөлжлөгийг оролцуулаад)
- Хар тамхи болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг хууль бусаар худалдах
- Хууль бус зэвсгийн наймаа
- Хулгайн болон бусад бараа бүтээгдэхүүний хууль бус худалдаа
- Авлига, хээл хахууль
- Залилан
- Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх
- Бараа, бүтээгдэхүүн хуурамчаар үйлдэх болон зохиогчийн эрхийг зөрчих
- Байгаль орчны эсрэг гэмт хэрэг
- Хүний амь нас бүрэлгэх, хүнд гэмтэл учруулах
- Хүн хулгайлах, хууль бусаар эрхийг нь боогдуулах, барьцаалах
- Хулгай, дээрэм
- Хууль бусаар хил нэвтрүүлэх (гааль болон нэмүү өртгийн албан татвартай холбоотой асуудал орно)
- Татварын гэмт хэрэг (шууд болон шууд бус татварыг оролцуулаад)
- Айлган сүрдүүлэх
- Баримт бичгийг хуурамчаар үйлдэх
- Далайн дээрэм
- Худалдааны дотоод мэдээлэл ашиглах, үнэт цаасны зах зээлд хууль бус үйлдэл хийх

Тухайн улс орон нь энэ жагсаалтаас суурь гэмт хэрэгт хамруулахдаа гэмт хэргийн төрлөөр нь болон уг гэмт хэргийн бүрэлдэхүүний ямар элемент нь онц ноцтой гэмт хэрэг болгож буйг дотоодын хууль тогтоомжийн дагуу тодорхойлох хэрэгтэй.

Санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн

Санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ)-д доорх багтана:

Үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ)	<p>a) Казино⁵⁷</p> <p>b) Үл хөдлөх хөрөнгийн зуучлагч</p> <p>c) Үнэт металлын арилжаа эрхлэгчид</p> <p>d) Үнэт чулууны арилжаа эрхлэгчид</p> <p>e) Хуульч, нотариатчид, бусад бие даасан хараат бус эрх зүйн мэргэжилтэн болон нягтлан бодогчид орох бөгөөд үүнд хувиараа ганцаараа ажилладаг хуульчид, хоршин ажиллагсад, мэргэжлийн компанид ажилладаг мэргэжилтнүүд орно. МУТСТ арга хэмжээнд хамрагддаг байх магадлалтай төрийн байгууллага, бусад төрлийн аж ахуйн нэгж, компаниудад ажилладаг “дотоод” мэргэжилтнүүдийг үүнд хамруулахгүй.</p> <p>f) Траст, компанийн үйлчилгээ үзүүлэгчид гэдэг нь гуравдагч этгээдэд доорх үйлчилгээ үзүүлдэг ФАТФ-ын зөвлөмжийн өөр хэсэгт хамрагдаагүй байгаа хувь хүн бизнесүүд багтана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хуулийн этгээдийг үүсгэн байгуулахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг ▪ Компанийн захирал эсвэл нарийн бичгийн дарга, нөхөрлөлийн хамтрагч, бусад хуулийн этгээдтэй холбоотой ижил албан тушаалын үйлчилгээ үзүүлж байгаа (эсвэл өөр хүнээр дээрх албан тушаал эрхлэх нөхцөл бүрдүүлэх) ▪ Компани, нөхөрлөл, бусад хуулийн этгээд эсвэл аливаа газар бүртгэлтэй албан тасалгаа, бизнесийн хаяг, харилцаа холбоо, захиргааны хаяг өгч буй этгээд ▪ Экспресс трастын трастий эсвэл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдэд ижил үүрэг гүйцэтгэх (эсвэл өөр хүнээр дээрхи албан тушаал эрхлэх нөхцөл бүрдүүлэх) ▪ Өөр хүний өмнөөс номинал хувьцаа эзэмшигч болох (эсвэл өөр хүнээр дээрхийг эрхлэх нөхцөл бүрдүүлэх).
Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд	Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд гэж:
Designated person or entity	i. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн 1267 (1999) тогтоолын дагуу байгуулагдсан хороо (1267-ийн Хороо гэх)-ны

⁵⁷ ФАТФ-ын стандартад казино гэдэгт интернетээр болон усан онгоцон дээр үйл ажиллагаа явуулдаг казиног хамруулан ойлгоно.

тодорхойлсон Аль Кайда бүлэгтэй холбоотой хувь хүн, бүлэг, байгууллага, этгээдүүд.

- ii. Аюулгүйн Зөвлөлийн 1988 (2011) тогтоолын дагуу байгуулагдсан хороо (1988-ийн Хороо гэх)-ны тодорхойлсон Афганистаны энх тайван, тогтвортой байдал, аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй Талибан бүлэгт, байгууллагатай холбоотой хувь хүн, бүлэг, байгууллага, этгээдүүд.
- iii. Аюулгүйн Зөвлөлийн 1373 (2001) тогтоолын дагуу аливаа улс орон эсвэл бүс нутгийн юрисдикцийн тодорхойлсон аливаа хувь хүн, хуулийн этгээд, этгээдүүд.
- iv. Аюулгүйн зөвлөлийн 1718 (2006) тогтоол болон дагалдан гарсан тогтоол, хавсралтуудад дурдсан болон “Аюулгүйн зөвлөлийн 1718 (2006) тогтоол”-д (1718-ийн Хоригийн Хороо гэх) хорооны тодорхойлсон санхүүгийн хориг арга хэмжээ авах шаардлагатай хувь хүн, хуулийн этгээд, этгээдүүд.
- v. Аюулгүйн Зөвлөлийн 2231 (2015) тогтоолын дагуу санхүүгийн хориг арга хэмжээ авах шаардлагатай хувь хүн, хуулийн этгээд, этгээдүүд.

Жагсаалтад оруулах

Designation

Жагсаалтад оруулах гэх нэр томъёо нь санхүүгийн хориг арга хэмжээнд хамрагдах хувь хүн⁵⁸ эсвэл аж ахуйн нэгжийг тодорхойлохыг хэлэх бөгөөд доорх санхүүгийн хоригт хамааралтай. Үүнд:

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн 1267 (1999) тогтоол болон дагалдах бусад тогтоолууд.
- Аюулгүйн Зөвлөлийн 1373 (2001) тогтоол, үүнд хориг арга хэмжээнд хамруулахаар тодорхойлсон хувь хүн болон этгээд оруулах болсон шалтгаанаа олон нийтэд мэдэгдэх орно.
- Аюулгүйн зөвлөлийн 1718 (2006) тогтоол болон дагалдах тогтоолууд.
- Аюулгүйн зөвлөлийн 1737 (2006) тогтоол болон дагалдах тогтоолууд.
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээг оногдуулах Аюулгүйн зөвлөлөөс цаашид гаргах бүх тогтоолууд.

⁵⁸ Хувь хүн, хуулийн этгээд.

	Аюулгүйн Зөвлөлийн 2231(2015) тогтоол болон дагалдах бусад тогтоолууд хамаатай “жагсаалтад оруулах” нь “жагсаах”-тай ижил утгатай.
Дотоодын цахим шилжүүлэг	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Domestic Wire Transfer	
Хэрэгжилтийг хангах арга хэрэгсэл Enforceable means	Санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарт шаардлага тавих эрх зүйн үндэслэл тайлбарыг харна уу.
Урьдчилан мэдэгдэлгүй Ex Parte	Эрх нь хөндөгдөж буй талд урьдчилан мэдэгдэлгүйгээр, түүний оролцоогүйгээр хэргийн ажиллагааг явуулахыг урьдчилан мэдэгдэлгүй гэнэ.
Экспресс траст Express trust	<i>Экспресс траст</i> гэдэг нь сетлорийн бий болгосон трастыг хэлэх бөгөөд ихэвчлэн трастын гэрээслэл зэрэг бичгээр үйлдсэн бичиг баримт байдаг. Энэ төрлийн траст нь сетлор этгээдийн траст эсвэл үүнтэй төстэй эрх зүйн зохицуулалт үүсгэх тодорхой санаачлага эсвэл шийдвэрээс улбаалан үүсгээгүй хууль эрх зүйн үйл явцын журмаар байгуулсан трастаас ялгаатай юм (<i>ЖН</i> : констрактив траст).
Худал мэдүүлэг	Зөвлөмж 32-ын тайлбарыг харна уу.
False declaration	
Худал мэдээлэх False disclosure	Зөвлөмж 32-ын тайлбарыг харна уу.
Санхүүгийн групп Financial group	<i>Санхүүгийн групп</i> гэж толгой компани эсвэл бусад хэлбэрийн хуулийн этгээд нь группын Үндсэн зарчмын хүрээнд бүхэлд нь хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг хэрэгжүүлж, группын түвшинд МУТС-тэй тэмцэх бодлого, үйл явцад харьяалагдах салбар, нэгжүүдээ бүхэлд нь хяналт тавьдаг групп юм.
Санхүүгийн байгууллага Financial institutions	Харилцагчид зориулан эсвэл харилцагчийн өмнөөс дор дурдсан нэг буюу түүнээс дээш бизнесийн үйл ажиллагааг эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдийг санхүүгийн байгууллага гэнэ. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Олон нийтээс хадгаламж болон бусад буцаан төлөгдөх хөрөнгө хүлээн авах⁵⁹ 2. Зээл⁶⁰ 3. Санхүүгийн лизинг⁶¹

⁵⁹ Үүнд хувийн банкны үйлчилгээ орно.

⁶⁰ Үүнд хэрэглээний зээл; моргейжийн зээл; солих нөхцөлтэй эсвэл солих нөхцөлгүй факторинг; худалдааны гүйлгээний санхүүжилт /форфейтинг орно/.

⁶¹ Хэрэглээний бараа бүтээгдэхүүнтэй холбоотой санхүүгийн лизинг үүнд хамаарахгүй.

4. Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ⁶²
5. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах болон түүний менежмент (*жн*: кредит, дебит картууд, чек, аялалын чек, мөнгөний ордер болон банкны драфт, цахим мөнгө).
6. Санхүүгийн баталгаа, санхүүгийн батлан даалт
7. Арилжааг хийх:
 - a. Мөнгөний зах зээлийн хэрэгслүүд (чек, төлбөр тооцоо, хадгаламжийн сертификат, санхүүгийн үүсмэл хэрэгслүүд гэх мэт)
 - b. Валют арилжаа
 - c. Валют, хүү болон индекстэй холбоотой хэрэгслүүд
 - d. Шилжүүлж болох үнэт цаас
 - e. Түүхий эдийн фьючерсийн худалдаа.
8. Үнэт цаас гаргахад оролцох болон үүнтэй холбоотой санхүүгийн үйлчилгээ үзүүлэх
9. Хувийн болон нийтийн хөрөнгийн багц удирдах
10. Бусад хүмүүсийн нэрийн өмнөөс бэлэн мөнгө эсвэл хөрвөх үнэт цаасыг хамгаалж хадгалах болон захиран зарцуулах
11. Бусад хүмүүсийн нэрийн өмнөөс хөрөнгө, мөнгө удирдах хөрөнгө оруулалт хийх, менежментийг нь хариуцах
12. Амь насны даатгал болон бусад хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын андеррайтерийн үйл ажиллагаа гүйцэтгэх, даатгуулах⁶³
13. Мөнгө, гадаад валютын солих

**Гадаадын хамтрагч
байгууллага**

**Foreign
counterparts**

Гадаад хамтын ажиллагаатай холбоотой ижил төрлийн үүрэг хариуцлага хүлээж, төстэй үйл ажиллагаа хэрэгжүүлдэг гадаадын эрх бүхий байгууллагыг гадаадын хамтрагч байгууллага гэх бөгөөд үүнд өөр үндсэн шинжтэй болон статустай гадаадын эрх бүхий байгууллагууд ч мөн багтана (*жн*: тухайн улсаас хамаараад санхүүгийн салбарыг МУТСТ хяналт шалгалтыг иж бүрэн хяналт шалгалт хийх чиг үүрэгтэй хянан шалгагч эсвэл СМА-ны хяналт шалгалт хийдэг нэгж гүйцэтгэж болдог).

⁶² Мөнгө шилжүүлэхэд зөвхөн мессеж эсвэл бусад хэлбэрийн хөрөнгө шилжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг хувь хүн, хуулийн этгээд орохгүй. Зөвлөмж 16-ийн тайлбарыг үзнэ үү.

⁶³ Даатгалын компани болон даатгалын зуучлагчдад /агент, брокерууд/ хамаарна.

**Царцаах
Freeze**

Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ (Зөвлөмж 4, 32, 38)-ний хүрээнд царцаах гэдэг нэр томъёо нь хөрөнгө царцаах механизмын дагуу эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэрээр эсвэл битүүмжлэх, хураах шийдвэрийг эрх бүхий байгууллага гаргах хүртэл хугацааны туршид хүчин төгөлдөр байх хөрөнгө, тоног төхөөрөмж болон бусад хэрэгслийг шилжүүлэх, хувиргах, захиран зарцуулах, хөдөлгөхийг хорихыг царцаах гэнэ

Санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой Зөвлөмж 6, 7-ийн хүрээнд царцаах гэдэг нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл эсвэл холбогдох Аюулгүйн Зөвлөлийн тогтоолыг үндэслэн эрх бүхий байгууллага эсвэл шүүхийн холбогдох хоригын жагсаалтад орсон хувь хүн, этгээдийн эзэмшиж, захиран зарцуулж буй аливаа мөнгө болон хөрөнгийг тогтоол хүчин төгөлдөр хугацааны туршид шилжүүлэх, хувиргах, захиран зарцуулах, хөдөлгөөнийг хорих арга хэмжээг царцаах гэнэ.

Бүх тохиолдолд царцаасан орлого, тоног төхөөрөмж, хэрэгслүүд, болон бусад хөрөнгө нь тэдгээрийг царцаах үед эрх нь хөндөгдөж байсан хувь хүн, хуулийн этгээдийн хөрөнгө хэвээр байх бөгөөд эдгээр хөрөнгийг гуравдагч этгээд, эсвэл царцаах арга хэмжээ авахаас өмнө хувь хүн, хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдээр удирдуулж байсан бол үргэлжлүүлэн удирдуулах буюу эсвэл улсын дотоодын хууль журмын дагуу зохицуулж болно. Царцаах үйл ажиллагааны хэсэг болгож улс орнууд нь тухайн хөрөнгө, тоног төхөөрөмж, хэрэгсэл, мөнгө болон бусад хөрөнгийг алдагдахаас хамгаалах үүднээс хяналтыг шилжүүлж авахаар шийдвэрлэж болно.

**Дотоодын хууль эрх зүйн
үндсэн зарчим**

**Fundamental
principles of
domestic law**

Тухайн улсын хууль, эрх зүйн тогтолцооны суурь үндсэн зарчим, хууль тогтоомж боловсруулах болон эрх мэдэл хэрэгжүүлэх ерөнхий тогтолцоог хэлнэ. Эдгээр үндсэн зарчмуудыг ихэвчлэн Үндсэн хууль эсвэл үүнтэй төстэй баримт бичиг, заавал мөрдөх шаардлагатай хуулийн тайлбар, үндэсний хууль, эрх зүйн тодорхойлох бүрэн эрхтэй хамгийн дээд шатны шүүхийн шийдвэрт тусгаж эсвэл илэрхийлсэн байна. Улс орноос хамааран өөр өөр байдаг ч үндсэн зарчмуудад хууль журмын дагуу шийдвэрлүүлэх эрх, шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно, хувь хүний шүүхээр хамгаалуулах эрх орно.

**Хөрөнгө
Funds**

Хөрөнгө гэж бүх төрлийн хөрөнгө, материаллаг болон материаллаг бус, эдийн болон эдийн бус, хөдлөх болон

	үл хөдлөх олсон арга хэлбэр хамаарахгүй, аливаа хэлбэрийн электрон, цахим, эзэмшигч болон хувь хүртэхийг нотолж буй эрх зүйн баримт бичиг болон арга хэрэгслийг хэлнэ.
Мөнгө болон бусад хөрөнгө	Мөнгө болон бусад хөрөнгө гэж санхүүгийн хөрөнгө, эдийн засгийн нөөц бололцоо, эдийн болон эдийн бус, хөдлөх болон үл хөдлөх бүх төрлийн хөрөнгө олсон арга хэлбэр хамаарахгүй аливаа хэлбэрийн электрон, цахим, эзэмшигч болон хувь хүртэхийг нотолж буй эрх зүйн баримт бичиг болон арга хэрэгслийг хэлнэ. Мөн банкны зээл, аялагчийн чек, банкны чек, төлбөрийн даалгавар, хувьцаа, үнэт цаас, бонд, драфт, аккредитив зэрэг мөнгө болон бусад хөрөнгөөс хуримтлагдаж буй бүх төрлийн орлого, хүү, ноогдол ашиг, бусад хөрөнгө, бүтээгдэхүүн, үйлчилгээ авч болох хөрөнгийг хэлнэ.
Funds or other assets	
Тодорхойлох мэдээлэл	Тодорхойлох мэдээлийн эх сурвалжид найдвартай, хараат бус сан болон мэдээллийн эх сурвалжийг хэлнэ.
Identification data	
Дамжуулагч санхүүгийн байгууллага	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Intermediary financial institution	
Олон улсын байгууллага	Олон улсын байгууллага нь гишүүн улс орнуудын албан ёсны гэрээ хэлэлцээр, улс төрийн шийдвэрийн дагуу байгуулагдсан бөгөөд тэдний оршин тогтнол нь гишүүн орнуудад хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн, байрлаж байгаа улсдаа тухайн орны оршин суугч байгууллагын нэгж биш гэсэн статустай байдаг байгууллага юм. Олон улсын байгууллагын жишээнд Нэгдсэн Үндэстний Байгууллага болон холбогдох олон улсын байгууллага болох Олон улсын далай тэнгисийн байгууллага, Европын Зөвлөл, Европын Холбооны байгууллагууд, Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны байгууллага, Америк тивийн орнуудын байгууллага зэрэг бүс нутгийн олон улсын байгууллага, НАТО зэрэг цэргийн олон улсын байгууллага, Олон улсын худалдааны байгууллага эсвэл Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо зэрэг эдийн засгийн байгууллагууд ордог.
International organisations	
Хууль	Санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарт шаардлага тавих эрх зүйн үндэслэл тайлбарыг харна уу.
Law	
Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд	Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд гэж экспресс траст эсвэл бусад ижил төрлийн хууль, эрх зүйн зохицуулалтыг хэлнэ мөн ижил төстэй зохицуулалтад fiducie, treuhand, fideicomiso орно (МУТСТ зорилгоор).
Legal arrangements	

Хуулийн этгээд Legal persons	<i>Хуулийн этгээд</i> гэж санхүүгийн байгууллагатай харилцагчийн харилцаа үүсгэх эсвэл хөрөнгө эзэмших боломжтой хувь хүнээс бусад бүх төрлийн этгээдийг хэлнэ. Үүнд компани, корпораци, сан, anstalt, нөхөрлөл, холбоо болон эдгээртэй төстэй бусад аж ахуйн нэгжүүд орно.
Мөнгө угаах гэмт хэрэг Money laundering offence	<i>Мөнгө угаах гэмт хэрэг</i> гэдэгт зөвхөн үндсэн гэмт хэрэг/хэргүүдээс гадна холбогдох гэмт хэргүүдийг хамруулж ойлгоно /Зөвлөмж 3-аас бусад тохиолдолд/.
Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ Money or value transfer service	<i>Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээнд (МУБЗШҮ)</i> бэлэн мөнгө, чек, бусад төлбөрийн хэрэгсэл эсвэл бусад үнэ бүхий хэрэгсэл хүлээн авч, шилжүүлэг хүлээн авагчид бэлэн мөнгөөр болон бусад хэрэгслээр харилцаа холбоо, мэдээлэл, МУБЗШҮ-ийн харьяалагддаг төлбөр тооцооны клирингийн сүлжээг ашиглан шилжүүлгийг хийдэг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид орно. Энэ төрлийн үйлчилгээнд нэг буюу түүнээс дээш зуучлагчид оролцож болох бөгөөд эцсийн төлбөр тооцоог гуравдагч этгээдэд төлөхдөө шинэ төрлийн төлбөрийн арга хэрэгслийг ашиглаж болно. Заримдаа эдгээр үйлчилгээнүүд нь тодорхой газар зүйн бүс нутагт харьяалагдаж <i>хавала, хунди, фей-чен</i> зэрэг өөр өөрөөр нэрлэсэн байдаг.
Эрүүгийн шийтгэлгүй хөрөнгө хураах Non-conviction based confiscation	<i>Эрүүгийн шийтгэлгүй хөрөнгө хураах</i> гэдэг нь эрүүгийн ял шийтгэл шаардахгүйгээр эрүүгийн гэмт хэрэгт шүүхийн үйл ажиллагаар хөрөнгө хураахыг хэлнэ.
Ашгийн бус байгууллага Non-profit organisations	Зөвлөмж 8-ын тайлбарыг харна уу.
Шилжүүлэгч Originator	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Шилжүүлэгч санхүүгийн байгууллага Ordering financial institution	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Дамжин өнгөрөх данс Payable-through accounts	Зөвлөмж 13-ын тайлбарыг харна уу.
Хил дамнасан биет тээвэрлэлт	Зөвлөмж 32-ын тайлбарыг харна уу.

Physical crossborder transportation

Улс төрд нөлөө бүхий этгээд

Улс төрд нөлөө бүхий гадаадын этгээд нь гадаад улс оронд нийтийн албанд өндөр албан тушаал хашдаг эсвэл хашиж байсан байсан хүмүүс бөгөөд үүнд Төрийн эсвэл Засгийн газрын тэргүүн, нөлөө бүхий улс төрчид, Засгийн газар, шүүх, цэргийн өндөр алба хаагчид, төрийн өмчит компанийн өндөр албан тушаалтнууд, улс төрийн намуудын нөлөө бүхий албан хаагчид орно.

Politically Exposed Persons (PEPs)

Улс төрд нөлөө бүхий дотоодын этгээд нь дотооддоо нийтийн албанд өндөр албан тушаал хашдаг эсвэл хашиж байсан хүмүүс бөгөөд үүнд Төрийн эсвэл Засгийн газрын тэргүүн, нөлөө бүхий улс төрчид, Засгийн газар, шүүх, цэргийн өндөр алба хаагчид, төрийн өмчит компанийн өндөр албан тушаалтнууд, улс төрийн намуудын нөлөө бүхий албан хаагчид орно.

Олон улсын байгууллагад өндөр албан тушаал хашдаг болон хашиж байсан хүмүүст захирлууд, дэд дарга нар, удирдах зөвлөл эсвэл үүнтэй төстэй албан тушаалтай удирдлагын түвшний менежмент хариуцсан гишүүд орно.

Улс төрд нөлөө бүхий этгээд гэдэг тодорхойлолтод дунд түвшний эсвэл доод шатанд ажилладаг хүмүүс хамаарахгүй.

Орлого Proceeds

Гэмт хэрэг үйлдэж шууд буюу шууд бус хэлбэрээр бий болсон эсвэл олж авсан бүх төрлийн хөрөнгийг хэлнэ.

Хөрөнгө Property

Хөрөнгө гэж материаллаг эсвэл материаллаг бус, хөдлөх болон үл хөдлөх, бодит болон бодит бус бүх төрлийн хөрөнгө болон эдгээр хөрөнгийн эзэмших эрх эсвэл ашиг сонирхлыг илэрхийлж буй эрх зүйн баримт бичиг болон хэрэгслийг хэлнэ.

Шаардлага хангахуйц цахим шилжүүлэг

Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.

Qualifying wire transfers

Зохистой арга хэмжээ

Зохистой арга хэмжээ гэж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй дүйцэхүйц зохистой арга хэмжээнүүдийг хэлнэ.

Reasonable Measures

Мөнгө угаах, терроризмын санхүүжүүлэхтэй холбоотой

Зөвлөмж 32-ын тайлбарыг харна уу.

Related to terrorist financing or money laundering	
Шаардлагатай	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Required	
Эрсдэл Risk	Эрсдэлийг дурдсан бүх тохиолдол нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг ойлгоно. Энэ ойлголтыг Зөвлөмж 1-ийн тайлбартай хамт унших хэрэгтэй.
Хангалттай Satisfied	Тодорхой асуудлаар санхүүгийн байгууллага нь хангалттай арга хэмжээ авсан байх шаардлагын тухайд тухайн байгууллага нь өөрийн дүгнэлтийг эрх бүхий байгууллагад нотлох чадвартай байх ёстой.
Битүүмжлэх Seize	Битүүмжлэх гэдэг нэр томъёо нь эрх бүхий байгууллага эсвэл шүүхийн хөрөнгө царцаах механизмын үйл ажиллагааны үндсэн дээр хөрөнгийг шилжүүлэх, хувиргах, зарцуулах, хөдөлгөөнийг хориглохыг хэлнэ. Царцаах үйл ажиллагаанаас ялгарах зүйл нь битүүмжлэх механизмаар эрх бүхий байгууллага эсвэл шүүх нь тухайн хөрөнгийн хяналтыг шилжүүлэн авдаг. Битүүмжилсэн хөрөнгө нь битүүмжлэх үед тухайн хөрөнгөд ашиг сонирхол нь хөндөгдөж буй хувь хүн, хуулийн этгээдийн өмч хөрөнгө хэвээрээ үлддэг ч ихэвчлэн эрх бүхий байгууллага эсвэл шүүх нь битүүмжилсэн хөрөнгийг хяналтандаа авч, менежмент, удирдлагыг хэрэгжүүлдэг.
Өөрийгөө зохицуулах байгууллага (ӨЗБ) Self-regulatory body (SRB)	ӨЗБ гэж тухайн мэргэжлийн гишүүдээс бүрдэж, уг мэргэжлийн (<i>жсн.</i> , <i>хуульчид</i> , <i>нотариатчид</i> , <i>бусад хараат бус эрх зүйн эсвэл нягтлан бодогчийн мэргэжлүүд</i>) бүлгийг төлөөлж, мэргэжлээрээ ажиллаж буй хүмүүсийг гишүүнээр элсэх шалгуурыг тогтоож, тодорхой хяналт болон мониторингтой төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагыг хэлнэ. Энэ төрлийн байгууллага нь өндөр хэмжээний ёс зүй, ёс суртахууны жишгийг тухайн мэргэжлээр ажиллаж буй этгээдүүд сахин биелүүлэхтэй холбоотой журмыг хэрэгжүүлнэ.
Сериал төлбөр тооцоо Serial Payment	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Сетлор Settlor	<i>Settlor</i> гэдэг нь трастын гэрээслэл эсвэл үүнтэй төстэй бусад зохицуулалтаар өөрийн хөрөнгийн эзэмшлийг трастийд шилжүүлж буй хувь хүн, хуулийн этгээд юм.
Халхавч банк Shell bank	Халхавч банк гэж үйл ажиллагаа явуулж байгаа болон тусгай зөвшөөрлөө авсан тухайн оронд бодитоор оршдоггүй, үр дүнтэй нэгдсэн хяналт шалгалтад хамрагддаг санхүүгийн зохицуулалттай группд хамаардаггүй банкыг хэлнэ.

	Бодитоор орших гэдэг нь тухайн оронд байрлаж, зохистой удирдлага болон менежменттэй байхыг хэлнэ. Тухайн орон нутагт төлөөлөгч эсвэл доод түвшний ажилтан байх нь биетээр оршин тогтнож буйг илэрхийлж чадахгүй.
Хэрэгтэй Should	ФАТФ-ын зөвлөмжтэй нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор хэрэгтэй <i>/should/</i> гэсэн үгийг ашиглахад энэ үгийг шаардлагатай <i>/must/</i> гэдэгтэй ижил утгатайгаар ойлгоно.
Төлбөр тооцоог шууд хийх Straight-through processing	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Хянан шалгагч Supervisors	Санхүүгийн байгууллага (“санхүүгийн хянан шалгагч” ⁶⁴), СББМҮҮ нарыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах үүрэгтэй эрх бүхий байгууллага эсвэл олон нийтийн бус байгууллагыг хянан шалгагч гэнэ. Олон нийтийн бус байгууллага нь (зарим төрлийн ӨЗБ хамаарна) санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарыг МУТСТ үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт, шалгалт хийх, биелүүлээгүй бол шийтгэлийн арга хэмжээ авах бүрэн эрхтэй байх хэрэгтэй. Эдгээр олон нийтийн бус байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нь хуулиар баталгаажуулж, үйл ажиллагаанд нь эрх бүхий байгууллага хяналт тавих хэрэгтэй.
Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ Targeted financial sanctions	Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн мөнгө болон бусад хөрөнгийг цаг алдалгүй царцаахыг, хөрөнгө мөнгөөр шууд буюу шууд бусаар хангахгүй байхыг хэлнэ.
Террорист этгээд Terrorist	Террорист этгээд гэдэгт дараах хувь хүмүүс орно: (i) террорист үйл ажиллагааг шууд эсвэл шууд бусаар, ямар нэгэн аргаар, санаатай болон санамсаргүйгээр үйлдэх, үйлдэхийг завдах, (ii) террорист үйл ажиллагаанд хамсаатнаар оролцох, (iii) террорист үйл ажиллагааг зохион байгуулж эсвэл бусдыг зохион байгуулахад удирдан чиглүүлэх, (iv) нэгдмэл зорилготой хэсэг бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа үйлдэхэд хувь нэмэр оруулсан, энэ оролцоо нь санаатай бөгөөд террорист үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн эсвэл тухайн бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа явуулах гэж байгааг мэдэж байсан хувь хүнийг хэлнэ.

⁶⁴ ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг Үндсэн зарчмуудтай холбоотой хяналт шалгалт хийдэг хянан шалгагчид хамаарна.

Террорист үйл ажиллагаа	Террорист үйл ажиллагаа гэж:
Terrorist act	<p>А. Дараах олон улсын гэрээ хэлэлцээрт гэмт хэрэг гэж тодорхойлсон үйлдлүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц /1970/, 2. Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц /1971/, 3. Олон улсын хамгаалалтанд байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай конвенц /1973/, 4. Хүн барьцаанд авахын эсрэг конвенц /1979/, 5. Үй олноор хөнөөх зэвсгийн материалыг хамгаалах тухай конвенц /1980/, 6. Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенцийн нэмэлт Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протокол /1988/, 7. Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц /2005/, 8. Эх газрын хормойд суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протокол /2005/, 9. Террорист бөмбөг дэлбэлэхтэй тэмцэх, таслан зогсоох ОУ-ын конвенц /1997/, 10. Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын конвенц /1999/. <p>Б. Зэвсэгт мөргөлдөөнд идэвхтэй оролцоогүй иргэд болон бусад хүмүүсийн амийг хөнөөх, биед нь хүнд гэмтэл учруулах үйлдэл нь зорилго болон агуулгаараа ард иргэдийг айлгах, төр засаг болон олон улсын байгууллагыг ямар нэгэн үйлдэл хийхэд хүргэх болон хийхээс татгалзуулахад чиглэсэн бусад үйлдэл.</p>
Терроризмыг санхүүжүүлэх	Террорист үйл ажиллагаа, террорист этгээд, террорист байгууллагыг санхүүжүүлэхийг <i>терроризмыг санхүүжүүлэх</i> гэнэ.
Terrorist financing	
Терроризмыг санхүүжүүлэхэд буруугаар ашиглагдах	Зөвлөмж 8-ын тайлбарыг харна уу.
Terrorist financing abuse	
Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг	Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт зөвхөн үндсэн гэмт хэрэг/хэргүүдийг хамруулаад зогсохгүй холбогдох

Terrorist financing offence	гэмт хэргийг хамруулан ойлгоно (Зөвлөмж 4-өөс бусад нөхцөлд).
Террорист байгууллага	<i>Террорист байгууллага</i> гэж дараах үйлдийг хийсэн бүх террорист бүлгийг хамруулж ойлгоно: 1. Террорист үйл ажиллагааг шууд эсвэл шууд бусаар, ямар нэгэн аргаар, санаатай болон санамсаргүйгээр үйлдэх, үйлдэхийг завдах, 2. Террорист үйл ажиллагаанд хамсаатнаар оролцох, 3. Террорист үйл ажиллагааг зохион байгуулах эсвэл бусдыг зохион байгуулахад удирдан чиглүүлэх, 4. Нэгдмэл зорилготой хэсэг бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа үйлдэхэд хувь нэмэр оруулсан, энэ оролцоо нь санаатай бөгөөд террорист үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн эсвэл тухайн бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа явуулах гэж байгааг мэдэж байсан.
Террорист organisation	
Гуравдагч этгээд	Зөвлөмж 6, 7-ийн хүрээнд гуравдагч этгээдэд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар орох бөгөөд гуравдагч этгээд нь үүгээр хязгаарлагдахгүй.
Third parties	Зөвлөмж 17-ын тайлбарыг харна уу.
Трастий	Траст болон трастийг Трастийг хүлээн зөвшөөрөх, тэдэнд үйлчлэх хууль, эрх зүйн тухай Гаагийн конвенцийн ⁶⁵ 2 дугаар зүйлд зааснаар ойлгоно.
Trustee	Трастий нь төлбөр авч бизнесийн үйл ажиллагааг явуулж байгаа бол мэргэжлийн (тухайн улсын хууль тогтоомжоос хамааран хуульч эсвэл трастийн компани г.м.) эсвэл мэргэжлийн бус (гэр бүлийнхээ нэрийн өмнөөс төлбөргүйгээр ажиллаж буй хүн г.м.) гэнэ.
Гүйлгээний тодруулгын онцгой дугаар	Зөвлөмж 16-ын тайлбарыг харна уу.
Unique transaction reference number	
Виртуал хөрөнгө	Виртуал хөрөнгө гэж цахимаар арилжаалах, шилжүүлэх, төлбөрийн болон хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглаж болох цахим үнийн дүн юм. Виртуал хөрөнгөд
Virtual Asset	

⁶⁵ Трастийг хүлээн зөвшөөрөх, тэдэнд үйлчлэх хууль, эрх зүйн тухай Гаагийн конвенцийн 2 дугаар зүйлд:

Энэ конвенцийн хүрээнд “траст” гэж сетлорын амьтдаа эсвэл нас барсны дараа, үр шим хүртэгчид болон тусгасан зориулалтаар трастийн хяналтад хөрөнгө шилжүүлэхээс үүсэх хууль эрх зүйн харилцаа юм. Траст нь дараах шинж чанартай байна:

- Траст нь трастийн өөрийнх нь хөрөнгөнөөс тусдаа хөрөнгө байна
 - Хөрөнгийн өмчлөгчөөр трастий эсвэл түүний нэрийн өмнөөс өөр этгээд байна.
 - Трастий нь бүртгэл тооцоотой байх, трастын заалт болон хуулиар түүнд хүлээлгэсэн үүргийн дагуу удирдах, захиран зарцуулах хариуцлага хүлээх эрх үүрэгтэй.
- Сетлорт зарим эрх үүрэг хариуцуулах, трастий нь үр шим хүртэгч байх заалт орох нь траст байгуулахтай харшилдахгүй.

	<p>ФАТФ-ын Зөвлөмжийн бусад хэсэгт хамруулсан бодит мөнгөн тэмдэгчийн, үнэт цаас, бусад санхүүгийн хөрөнгийн цахим илэрхийлэлийг хамрахгүй.</p>
<p>Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч</p> <p>Virtual Asset Service Providers</p>	<p>Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч гэж Зөвлөмжийн өөр хэсэгт хамрагдаагүй дараах бизнесийн үйл үйл ажиллагааг хувь хүн хуулийн этгээдийн өмнөөс ажиллагаа эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> i. виртуал хөрөнгө болон бодит мөнгө хөрвүүлэх арилжаа хийх ii. виртуал хөрөнгө хооронд хөрвүүлэх арилжаа хийх iii. виртуал хөрөнгө шилжүүлэх⁶⁶ iv. виртуал хөрөнгө, хэрэгслийг хадгалах, виртуал хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлэх v. виртуал хөрөнгө гаргагч, борлуулагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлэх ,оролцох.
<p>Хугацаа алдалгүй</p> <p>Without delay</p>	<p>НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл эсвэл түүний холбогдох Хоригийн хорооноос (Хороо 1267, Хороо 1988, Хоригийн 1718 хороо эсвэл Хоригийн 1737 хороо) хоригын жагсаалтад орууснаас хойш хэдэн цагийн дотор гэж ойлговол зохино.</p> <p>АЗ-ийн 1373 (2001) тогтоолын хувьд хугацаа алдалгүй гэж хувь хүн эсвэл этгээдийг терроризм, терроризм болон террорист байгууллагыг санхүүжүүлдэгт итгэх, сэжиглэх, сэжиглэх хангалттай итгэх үндэслэл, бодит үндэслэлтэй болсон даруйд гэж ойлговол зохино. Энэ хоёр тохиолдолд хугацаа алдалгүй гэдгийг террорист, террорист байгууллага, терроризмыг санхүүжүүлдэг, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой мөнгө бусад хөрөнгийг үрэгдэх, зугтахаас сэргийлэх, дэлхийн хэмжээнд нэгдмэл үйл ажиллагаа авч эдгээрийн урсгалыг зогсоох үйл ажиллагааг хэрэгжүүлэх явдал гэж ойлгоно.</p>

⁶⁶ Виртуал хөрөнгийн хувьд виртуал хөрөнгө шилжүүлэх гэж хувь хүн, этгээдийн нэрийн өмнөөс виртуал хөрөнгийг нэг данс, хаягнаас нөгөө данс, хаяг руу шилжүүлэх гүйлгээ хийхийг хэлнэ.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
ШТХ	Шилжих төлбөрийн хэрэгсэл
ХТМ	Харилцагчийг таньж мэдэх
СББМҮҮ	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид
ФАТФ	Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
МУ	Мөнгө угаах
МҮБЗШҮ	Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ
АББ	Ашгийн бус байгууллага
Палермогийн конвенци	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны конвенц
УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
З.	Зөвлөмж
ЭСА	Эрсдэлд суурилсан аргачлал
ТЗ.	Тусгай Зөвлөмж
ӨЗБ	Өөрийгөө зохицуулах байгууллага
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
ТКҮҮ	Траст, компанийн үйлчилгээ үзүүлэгч
Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх конвенци	Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц (1999)
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
Веннийн конвенци	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенц
АЗ	Аюулгүйн Зөвлөл

ХАВСРАЛТ I: ФАТФ-ЫН ГАРЫН АВЛАГА, БАРИМТ БИЧИГ

ФАТФ-аас олон төрлийн гарын авлага болон хэрэгжүүлэх сайн жишиг баримт бичгүүдийг гаргадаг бөгөөд дараах хуудаснаас харна уу:

www.fatf-gafi.org/documents/guidance/ .

ХАВСРАЛТ II: ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖИД ОРСОН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ

ФАТФ-ын Зөвлөмжид 2012 оны хоёрдугаар сараас хойш оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг дор тусгав. Үүнд:

Огноо	Нэмэлт, өөрчлөлтийн төрөл	Нэмэлт, өөрчлөлт орсон хэсэг
2013 оны 2 дугаар сар	Зөвлөмж 37 болон Зөвлөмж 40 хоорондын уялдаа холбоо	<ul style="list-style-type: none"> Зөвлөмж 37(d) – хуудас 27 Хууль тогтоомжийн дагуу санхүүгийн байгууллага эсвэл санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нар нь нууцлалыг хангах шаардлагатай гэдгээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзахгүй байх (хүсэлттэй холбоотой мэдээлэл нь хууль, эрх зүйн болон мэргэжлийн эрхийн дагуу нууцлалд хамаарах нөхцлөөс бусад тохиолдолд).
2015 оны 10 дугаар сар	Гадаадын террорист халдагчдын аюул, заналхийллийг шийдвэрлэх зорилгоор Зөвлөмж 5-ын Тайлбар хэсэгт оруулсан шинэчилсэн найруулга	<ul style="list-style-type: none"> Зөвлөмж 5-ын тайлбар хэсэг(В.3) – хуудас 37 <p>Гадаадын террорист халдагчдын учруулж буй аюул, заналхийллийг авч үздэг НҮБ-ын АЗ-ийн 2178-р тогтоолын холбогдох элементүүдийг В.3 хэсэгт тусгав. Терроризмын санхүүжүүлэхэд оршин сууж байгаа болон харьяалалын улс орноос бусад улс оронд зорчиж террорист үйл ажиллагаа явуулах, төлөвлөх, бэлтгэх, оролцох, террорист үйл ажиллагааны сургалт хийх, сургалтад оролцох зорилгоор аялсан этгээдийг санхүүжүүлэх хамрах шаардлагатай талаар мөн тусгав.</p> <p>Өмнөх В.3-11-ыг В.4-12 болгосон</p>
2016 оны 6 дугаар сар	Зөвлөмж 8 болон Зөвлөмж 8-ийн тайлбар хэсгийн шинэчилсэн найруулга	<ul style="list-style-type: none"> Зөвлөмж 8, Зөвлөмж 8-ийн тайлбар хэсэг – Хуудас 13 болон 54-59

		<p>Хяналт шалгалтад хамрагдах ёстой АББ-ын дэд хэсгүүдийг тодруулахын тулд АББ-ын стандартыг шинэчлэн батлав. Энэ нь 8-р тайлбар хэсгийг ФАТФ-ын АББ-ын терроризмд буруугаар ашиглагдах эрсдлийн талаарх типологийн тайлан (2014 оны 6-р сар) болон ФАТФ-ын АББ-ын буруугаар ашиглагдахаас сэргийлэх талаархи шилдэг туршлага (2015 оны 6-р сар) -д нийцүүлэн нэгтгэж байгаа бөгөөд бүх АББ буруугаар ашиглагдах өндөр эрсдэлгүй мөн Зөвлөмж 8-ийг тэдгээр АББ-уудад хэрэгжүүлэх шаардлагагүйг тодорхойлж байгаа юм. Иймд, Зөвлөмж 8/ 8-р тайлбар хэсгийг эрсдэлд суурилсан аргачлалаар хэрэгжүүлэх хэрэгтэй.</p>
<p>2016 оны 10 дугаар сар</p>	<p>Зөвлөмж 5-ын Тайлбар хэсэг болон Нэр томъёоны тайлбар хэсгийн “Мөнгө болон бусад хөрөнгө”-ийн тодорхойлолтод оруулсан өөрчлөлт</p>	<p>■ Зөвлөмж 5-ын тайлбар хэсэг болон Нэр томъёоны тайлбар – 37, 121 дүгээр хуудас</p> <p>Зөвлөмж 5-ын тайлбар хэсгийн Зөвлөмж 6-тай ижил цар хүрээг хамруулахын тулд “мөнгө” гэдгийг “мөнгө болон бусад хөрөнгө” гэж сольсон. Мөн “мөнгө болон бусад хөрөнгө”-ийн тодорхойлолтод газрын тос, бусад байгалийн эх үүсвэр болон мөнгөөр сольж авах боломжтой бусад хөрөнгийг нэмж оруулсан.</p>
<p>2017 оны 6 дугаар сар</p>	<p>Зөвлөмж 7-ын тайлбар хэсэг болон Нэр томъёоны тайлбар хэсгийн “Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд”, “Жагсаалтад оруулах”, “Хугацаа алдалгүй”-ын тодорхойлолтод оруулсан өөрчлөлт.</p>	<p>■ Зөвлөмж 7-ын тайлбар хэсэг болон Нэр томъёоны тайлбар – хуудас 45-51, 114-115 болон 123</p> <p>Зөвлөмж 7-ын тайлбар хэсэг болон “Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд”, “Жагсаалтад оруулах”, “Хугацаа алдалгүй”-д оруулсан өөрчлөлтийг НҮБ-ын АЗ-ийн</p>

			<p>тогтоолд нийцүүлж, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээний хэрэгжилтийн явцыг тодорхой болгосон.</p>
2017 оны 11 дүгээр сар	Зөвлөмж 18-ын тайлбар хэсэгт оруулсан өөрчлөлт	■	<p>Зөвлөмж 18-ын тайлбар хэсэг – хуудас 77</p> <p>Санхүүгийн групп нь хэвийн бус болон сэжигтэй гүйлгээний мэдээллийг солилцоход тавигдах шаардлагыг тодорхой болгох үүднээс Зөвлөмж 18-ын тайлбар хэсгийг шинэчлэн найруулав. Мөн МУТСТ эрсдэлийн удирдлагад шаардлагатай гэж үзвэл тус мэдээллээр салбар нэгж болон охин компаниудыг хангах талаар тусгасан.</p>
2017 оны 11 дүгээр сар	Зөвлөмж 21-д оруулсан өөрчлөлт	■	<p>Зөвлөмж 21 - хуудас 17</p> <p>Мэдээллийг задруулахтай холбоотой тавигдах шаардлагуудын уялдаа холбоог тодруулах үүднээс Зөвлөмж 21-д өөрчлөлт оруулав.</p>
2018 оны 2 дугаар сард	Зөвлөмж 2-т оруулсан өөрчлөлт	■	<p>Зөвлөмж 2 - хуудас 9</p> <p>МУТСТ шаардлага, мэдээлэл хамгаалал болон нууцлалын дүрмийн нийцлэлийг хангах, мөн эрх бүхий байгууллагуудын солилцох дотоодын байгууллага хоорондын мэдээлэл солилцоог дэмжих зорилгоор Зөвлөмж 2-т өөрчлөлт оруулсан.</p>
2018 оны 10 дугаар сар	Зөвлөмж 15 болон Нэр томъёоны тайлбарт орсон шинэ 2 тодорхойлолт	■	<p>Зөвлөмж 15 болон Нэр томъёоны тайлбар – хуудас 15, 126-127</p> <p>МУТСТ шаардлага нь виртуал хөрөнгөтэй хэрхэн нийцэж байгааг тодорхой болгох зорилгоор Зөвлөмж 15-д өөрчлөлт оруулан “виртуал хөрөнгө” болон “виртуал</p>

		хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэсэн шинэ тодорхойлолтыг оруулж өгсөн.
2019 оны 6 дугаар сар	Зөвлөмж 15-ын тайлбар хэсэгт оруулсан нэмэлт тайлбар	■ Зөвлөмж 15-ын тайлбар хэсэг – хуудас 70-71 ФАТФ-ын Зөвлөмжийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд ашиглахыг тусгасан шинэ тайлбар хэсгийг оруулав.



www.fatf-gafi.org